


Жилийн тайлан 2017



Гарчиг

2017 оны онцлох үйл явдал	4
Санхүүгийн гүйцэтгэл	6
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	8
Төлөөлөн Удирдах Зөвлөл	9
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	10

ЭРДЭНЭТ ХҮМҮҮН

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	14
Гүйцэтгэх удирдлага	17
ИРГЭДИЙН БАНК	18
2017 оны онцлох үйл явдал	19
Иргэдийн банкны үйл ажиллагаа	20
Салбарууд	21
Иргэдийн банкны бүтээгдэхүүнүүд	22
Харилцагчдыг хамгаалах зарчмууд	24
БИЗНЕС БАНК	25
Бизнес банкны үйл ажиллагаа	26
Корпорейт харилцагчийн түүх: Сүү ХК	27
ЖДБ харилцагчийн түүх: Очирдагинас ХХК	28
ЖДБ харилцагчийн түүх: Есөн од ХХК	29
ЖДБ харилцагчийн түүх: Монфүүдланд ХХК	
Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд	30
ХҮНИЙ НӨӨЦ	32
Манай ажиллагсад	33
Хүний нөөцийн бодлого	34
ХасБанкны олон талт байдал: Грэг Зэгас	35
Сургалт ба хүний хөгжил	36
Ажилтны түүх: Жуковын Баатарболд	38
Ажилтны түүх: Адилбишийн Булгамаа	39
КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	41
Катманду-гийн тунхаглал	42
Х.А.С ТББ-ын санаачлагууд	44
Афлатоны түүхүүд	45
2017 оны онцлох үйл явдал	46
Нэгдмэл сонирхолтой талуудын оролцоо	50

ЭХ ДЭЛХИЙ

Байгаль Орчин, Нийгмийн Хариуцлага	54
Эко Банк	55
Манай Эко харилцагч: Нахиа Импекс	57
Эко бизнесийн түүх	59

ЭРҮҮЛ АШИГ

Бизнесийн үйл ажиллагааны орчин	62
Банкны салбар	64
2017 оны санхүүгийн гүйцэтгэл	66
Эрсдэлийн удирдлага	68
Мэдээллийн технологи	72
Дотоод аудит	74
Олон улсын үнэлгээ	75
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	81
ШАГНАЛУУД	86
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	88

2017 оны онцлох үйл явдал



V сар

VI сар

IX сар

X сар

XI сар

XII сар

2017 онд ХасБанк Уур амьсгалын ногоон сангаас 20 сая америк долларын санхүүжилт авч сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, технологи үйлдвэрлэх, нийлүүлэх, нэвтрүүлэхэд нь ЖДҮ болон бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж эхэллээ.



ХасБанк Монголын эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор IFC, OPIC корпорациудаас 169 сая америк долларын санхүүжилт авлаа.



ХасБанк Уур амьсгалын ногоон сан, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Байгаль орчин, уур амьсгалын сантай хамтран, Ногоон санхүүжилтийн форумыг Монголд анх удаа “Боломжийг бодит ажил болгох нь” сэдвээр зохион байгууллаа.



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд зөвхөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд олгох бизнесийн зээлийн жилийн хүүг 4.2%-аар буурууллаа.



ХасБанк сэргээгдэх эрчим хүчний төслийг дэмжсэн Монголын анхны арилжааны банк болж, Говьсүмбэр аймагт Нарны цахилгаан станц барьж байгуулахад санхүүжилт хийлээ.



Эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, эсвэл үл хөдлөх хөрөнгө худалдан авахыг хүсч байгаа боловч банкны зээл авах барьцаа хөрөнгөгүй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн зуучлалд хамрагдах боломж олгох зорилгоор “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байр бий болгох” төслийн гэрээг Азийн хөгжлийн банкт байгууллаа.




Фитч Рейтингс Олон улсын үнэлгээний байгууллага ХасБанкны урт хугацааны гадаад валют, төгрөгөөр хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадвар (IDR)-ыг ТОГТВОРТОЙ-гоос ЭЕРЭГ болгон үнэллээ. Мөн Мүүдиз агентлагаас ХасБанкны зэрэглэлийг Саа1-ээс В3 болон өсгөж, цаашдын төлөв тогтвортой гэж үнэллээ.




ЕСБХБ-наас бичил, жижиг, дунд үйлдвэрийн газруудыг дэмжих зорилгоор 40 сая америк долларын синдикат зээл авлаа.

Санхүүгийн гүйцэтгэл


Зээлийн багц
+14.0% (тэрбум төг)




Харилцах хадгаламж
+31.3% (тэрбум төг)




Цэвэр ашиг
-6.3% (тэрбум төг)




Өөрийн хөрөнгийн өгөөж (%)
10.8%




Татсан төвлөрүүлсэн эх үүсвэр
+42.7% (тэрбум төг)




Нийт хөрөнгө
+34.8% (тэрбум төг)



Хөрвөх чадвар (%)
43.9%



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)
16.8%



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк нь Монголын банк, санхүүгийн салбарын томоохон компаниудын нэг болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн бүрэн эзэмшлийн охин компани юм. ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хувьцааны дийлэнхийг нэр хүндтэй дотоод, гадаадын компани, олон улсын байгууллага, хөрөнгө оруулалтын сангууд эзэмшдэг.

ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө, сүлжээ нь банкны бизнесийг тогтвортой өргөжүүлж хөгжүүлэхэд өрсөлдөөний давуу тал болж байгаа юм.

Монголын Алт (МАК) Корпораци	20.00%
Олон улсын санхүүгийн корпораци (IFC)	17.17%
ОРИКС Корпораци	16.81%
ЕСБХБ (EBRD)	12.91%
Канадын Үндэсний Банк (NBC)	10.52%
Ронек Партнерз	10.15%
Монголиа Оппортунитиз Сан	6.63%
Триодос Фэр Шэр Фанд	3.73%
Нээлттэй Нийгэм Форум	1.59%
Улаанбаатар Ротари Клуб	0.30%
Магваны Болдоо	0.10%
Чулууны Ганболд	0.09%
Бүгд	100.0%

Төлөөлөн Удирдах Зөвлөл

(2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

ТУЗ-ИЙН ДАРГА

Чулууны Ганболд

ТУЗ-ийн гишүүн
2017 оны 3 дугаар сарын 30-нд дахин сонгогдсон

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Жулиан Хили

ТУЗ-ийн гишүүн
2016.03.31-нд сонгогдсон

Майкл Мадден

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд дахин сонгогдсон

Санжай Гупта

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд сонгогдсон

Нямтайширийн Цэлмүүн

ТУЗ-ийн гишүүн
2017.03.30-нд дахин сонгогдсон

Ёшиаки Мацүока

ТУЗ-ийн гишүүн
2016.03.31-нд сонгогдсон

Ив Жако

ТУЗ-ийн гишүүн
2016.03.31-нд сонгогдсон

Магваны Болдоо

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх Захирал
2017.03.30-нд дахин сонгогдсон

Жэймс Стент

Хараат бус гишүүн
2016.03.24-нд дахин сонгогдсон

Матью Уэлч

Хараат бус гишүүн
2017.03.30-нд сонгогдсон

Баянсаны Уламбаяр

Хараат бус гишүүн
2017.06.14-нд томилогдсон¹

¹2018.03.29-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилогдсон.

ТУЗ-ийн даргын мэндчилгээ



Чулууны Ганболд

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс ХасБанкны 2017 оны тайланг танилцуулж байгаадаа баяртай байна. Та бүхний байнгын дэмжлэг, хамтын ажиллагаанд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Бид эдийн засгийн ирээдүй илүү тод, таамаглаж болохуйц байсан нэг жилийг ардаа орхиж байна. Бизнесийн итгэл сэргэж, эерэг хүлээлтэй боллоо. Ирээдүйн төлөв одоо тогтвортой, эерэг харагдаж байна. Банкны удирдлага сайн ажиллаж, амласандаа хүрч чадлаа. Ашиг, өөрийн хөрөнгийн өгөөж, санхүүгийн бусад зорилтууд бүгд хэрэгжсэн төдийгүй бүр давж биелэгдлээ.

Бид ОУВС, Монголбанкны Активын чанарын үнэлгээ (AQR)-ний шалгалтыг амжилттай давж, эрүүл банк гэсэн дүн авсныг мэдэгдэхэд бахархамаар байна. AQR үнэлгээ бидний эзэлийн багцын удирдлага зохистой тогтолцоотой, зээлийн үйл ажиллагаа зөв зүйтэй байгааг нотоллоо. Уг үнэлгээ Банкны активын чанар, зээлийн эрсдэлийн удирдлагын шалгалт болсон төдийгүй манай зээлийн ажилтнуудын мэдлэг дээшлүүлэх, зөв зохистой тогтолцоог цаашид бэхжүүлэх хөрөнгө оруулалт боллоо.

2017 он бидний сүүлийн жилүүдэд хийж байгаа өөрчлөн байгуулалтын чухал цаг хугацаа байсан бөгөөд ТУЗ жилийн туршид стратеги дээр голлон төвлөрч ажиллалаа.

Брэндийн шинэчлэлт, өөрчлөн байгуулалтын сүүлийн таван жилийн ажлын үр дүнд бидний үйл ажиллагаа чанарын бүх үзүүлэлтээр өөрчлөгдөн сайжирлаа. ХасБанк одоо тогтвортой, хурдан өсч буй банк гэж олон нийтэд танигдсан болжээ. Бид өөрсдийн брэндээ үнэт зүйлстэйгээ нягт уялдуулан өөрчилж чадлаа.

Бид гол бизнесээ иргэдийн банк, бизнесийн банкны үйлчилгээ гэсэн хоёр зах зээл дээр дахин төвлөрүүлээ. Мэдээллийн технологийн суурь бүтцэд хийж буй хөрөнгө оруулалтаа нэмэгдүүллээ. Мөн ногоон санхүүжилт гэж нэрлэгддэг бизнесийн шинэ чиглэлийг эхлүүллээ.

2017 онд бид Банкаа ирэх гурван жилд ашиг орлоготой, тогтвортой хөгжүүлэх хоёр тулгуур зорилт дээр үндэслэгдсэн шинэ стратеги дээр төвлөрч ажиллалаа. Эдгээр зорилт нь 2020 он гэхэд зах зээлд эзлэх хувийг 20% хүртэл тогтвортой өсгөхийн зэрэгцээ өөрийн хөрөнгийн өгөөжийг 20-иос дээш хувьд хүргэх явдал юм. Тиймээс, бид шинэ стратегиа 20/20/20 гэж нэрлэсэн. Ирэх жилүүдэд Банкны байр суурийг улам бэхжүүлэн өсч дэвжих боломжууд байгаа гэдэгт би итгэлтэй байна.

ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн охин компаниуд тус тусын салбар бүрдээ ашигт ажиллагаагаараа тэргүүлэхийн зэрэгцээ хамгийн чухал нь харилцагчдын сэтгэл ханамж, үйлчилгээний чанарыг үйл ажиллагааныхаа төвд тавьж ажиллахыг зорьж байна. Өсөлтийн энэ боломжийг ашиглахын тулд гүйцэтгэх удирдлага харилцагчдийн үйлчилгээг сайжруулах стратегийн өөрчлөн байгуулалтын түлхүүр гурван чиглэлийг тодорхойлсон байна. Эдгээрт салбаруудад хөрөнгө оруулалт хийж, процессыг өөрчлөн шинэчлэх, нийт байгууллагыг цахимжуулах, хүний нөөцийн бодлогод шинэчлэл хийх асуудлууд багтаж байна.

Бид харилцагчдийн үйлчилгээний чанарыг сайжруулж, стандартчилсан бүтээгдэхүүн, зээлийн автоматжуулсан шийдвэр гаргах замаар салбаруудын сүлжээгээ борлуулалтад төвлөрсөн цэг болгох, салбарын ажилтнуудын үр ашигтай

ажиллагааг сайжруулах ажлыг салбарын өөрчлөн байгуулалтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Цахим өөрчлөн байгуулалтын хүрээнд интернэт, мобайл банкны үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийснээр төлбөр тооцоо гүйлгээгээ илүү сайн хянах боломжийг харилцагчдад олгоно. Бэлэн мөнгө тушаах (CDM), автомат төллөр (ATM) төхөөрөмжүүдийн тоог нэмэгдүүлэх замаар хэрэглэгчдэд хялбар хүртээмжтэй болгоход хөрөнгө оруулалт хийнэ.

2017 онд бид Банкны эрсдэлийн удирдлага, хянан нийцүүлэлтийн хүрээг хянан үзэж, сайжруулан, бэхжүүллээ. Бодлогуудыг хялбаршуулж, Банкны тогтвортой өсөлтийг хангах Хамгаалалтын Гурван Бүсийн зарчмуудыг нэвтрүүлэх ажил хийлээ. Компьютерийн автоматжуулалтаар эрсдэлийн хэмжигдэхүүн, зээлийн шийдвэр гаргалт, хянан нийцүүлэлтийн эрсдэлийн үнэлгээг цаашид улам сайжруулах ажлуудыг дараагийн жилд төлөвлөсөн байгаа.

Эцэст нь манай хүмүүс бол Банкны хамгийн чухал хөрөнгө мөн. Тэдний мэдлэг, мэргэжлийн ур чадвар, тууштай ажиллагаа бидний салбарын болоод цахим өөрчлөн шинэчлэлтийг авч явах болно. Бид ХасБанкинд ажиллагсдыгаа өндөр үнэлж, хүний хөгжилд хөрөнгө оруулсан хэвээр байх болно.

Бид үйл ажиллагааныхаа дараагийн жилдээ 20/20/20 стратегитэй, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлээд эхэлчихсэн орж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн болоод өөрийн нэрийн өмнөөс 2017 онд шургуу ажилласан манай удирдлагын баг, нийт ажиллагсаддаа баяр хүргэж, талархал дэвшүүлье.

Мөн бидний оршин тогтнохын учир шалтгаан болсон манай харилцагчид, оролцогч талууддаа баярлалаа. Стратегийн зорилтууддаа хүрэх явдал бид бүгдийн хамтын хүчин чармайлт байх болно.

Та бүхэнд 2018 ондоо амжилт гаргахыг хүсэн ерөөж, өөрчлөн байгуулалт маань улам эрчимжихийн ерөөл дэвшүүлье!

Гүнээ хүндэтгэсэн,

Чулууны Ганболд
ТУЗ-ийн дарга



Эрдэнэт **хүмүүн**

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Магваны Болдоо

Гүйцэтгэх захирал

Эрхэм ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчид, зохицуулагч байгууллагууд, харилцагч түншүүд, хамтран ажиллагсад аа,

ХасБанк 2017 онд гадаад, дотоодын нэр хүнд бүхий хувь нийлүүлэгчид, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон банкны Алсын хараа, Эрхэм зорилгын төлөө тууштай ажилладаг авьяаслаг ажилтнууд, хамт олныхоо дэмжлэгээр компанийн засаглалын хамгийн өндөр стандарт, хэм хэмжээг мөрддөг, хариуцлагатай банк гэдэг нэр хүндээ улам бататгалаа.

ХасБанк олон улсын стандартыг тууштай мөрддөг, зээлийн багцын удирдлагын зохистой тогтолцоотой, зээлтэй холбоотой практик үйл ажиллагаа нь оновчтой бөгөөд зөв зүйтэй байгааг 2017 онд хийгдсэн Активын чанарын үнэлгээ (AQR)-ний үр дүн нотоллоо. Зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд ХасБанкны зээлжих зэрэглэлийг тэр даруй сайжруулж үнэлсэн бөгөөд хөндлөнгийн аудитын тайлан ч Банкны эрүүл, тогтвортой статусыг дахин баталгаажуулав.

Банк санхүүгийн салбарын харилцагчийг хамгаалах нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг өөрийн үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж тууштай хэрэгжүүлдгийг олон улсын Ухаалаг Хөдөлгөөн төвөөс батламжилсан дэлхийн 100 шахам санхүүгийн институц байдгийн нэг нь ХасБанк юм. Эдгээр байгууллагууд давхардсан тоогоор 41 сая хүнд банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Бид 2017 онд The Banker Magazine болон Global Finance Magazine сэтгүүлээс Монгол Улсын Шилдэг Банк өргөмжлөлийг гурав дахь удаагаа хүртээд байна. Түүнчлэн, Global Finance-аас ХасБанкинд гадаад валютын ханган нийлүүлэлтийн Шилдэг Банк өргөмжлөлийг шинээр олгов. Эдгээр шагнал нь ил тод байдал, нээлттэй тайлагнал, сайн засаглалын стандартуудыг олон жил тууштай мөрдөж ирсэн бидний үнэт зүйлс биеллээ олж байгаагийн нэг илэрхийлэл болж байна.

ХасБанк тууштай, тухайн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх, дасан зохицох, тэсвэрлэх уян хатан бөгөөд тогтвортой бизнесийн загвар бүхий, системийн ач холбогдолтой, түргэн хурдацтай өсч буй банк болоод байна. Иргэдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 31.3% өсч, Банкны нийт актив 3 их наяд төгрөгөөс давж өслөө. Чанаргүй зээлийн харьцаа өмнөх оноос 104 суурь нэгжээр буурч 6.9% болов. Банкны цэвэр ашиг 20.1 тэрбум төгрөгт хүрч өссөнөөр ашгийн төлөвлөгөө 116%-иар биелэгдэн, өөрийн хөрөнгийн өгөөж 10.8%-д хүрлээ. Банкны өөрийн хөрөнгө өссөн бөгөөд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 16.8% байгаа нь зохицуулагч байгууллагаас тавьдаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс үргэлж өндөр түвшинд хадгалагдаж ирлээ.

2017 онд үйл ажиллагааны цэвэр орлого 82.4 тэрбум төгрөгт хүрэхэд хүүний цэвэр орлого 62.7 тэрбум төгрөг, шимтгэл, хураамж болон арилжааны цэвэр орлого 19.2 тэрбум төгрөгт хүрч өссөн нь тус тус эергээр нөлөөлөв. Харин шинээр олгосон зээлийн өсөлтөд хугацааны хувьд хоцролт гарсан, зээлийн багцын өсөлттэй харьцуулахад хадгаламжийн өсөлт илүү өндөр байсантай уялдан хүүний зардал өссөн, Монголбанк, Засгийн газрын үнэт цаасанд байршуулсан хөрөнгө оруулалтын өгөөж буурсан, гадаад валютын своп хэлцлийн өртөг, зардал нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж үйл ажиллагааны нийт орлого өнгөрсөн оноос 22.2%-иар бага гарсан юм.

2017 оны эхний хагаст Олон улсын валютын сангийн хөтөлбөрт орох эсэхтэй холбоотой тодорхой бус байдал үүссэний улмаас зах зээлийн төлөв хандлага сул, хүлээлт тогтворгүй бөгөөд сөрөг байлаа. Зээлийн эрэлт сэргэх мөчлөг ийнхүү хойшилж байсантай уялдан Банк зээлийн түүх сайтай, шалгуур нөхцөл сайн хангах зээлдэгчдэд зээл олгохын зэрэгцээ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг байнга өндөр түвшинд хадгалж ажилласан. Харин оны хоёрдугаар хагаст банкны системийн хэмжээнд актив болон зээл алгуур өсөх эерэг төлөв бий болсон юм. 2016 онд 1%-иас бага өсөлттэй байсан нийт зээлийн багц 2017 онд 14.0%-иар буюу хэвийн өсөлтийн хурдаар өсч 1402.5 тэрбум төгрөгт хүрлээ. Жилийн дүнгээр иргэдийн болон бизнесийн зээлийн багц харгалзан 19.1% болон 9.4%-иар өсөв.

Иргэдийн банкны стратегийг хэрэгжүүлэх хүрээнд цахим сувгууд болон банкны салбар, тооцооны төвүүдээр дамжуулж харилцагчдад илүү ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, бодит боломжинд нь нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж байна. ХасБанк Монгол Улсын хэмжээнд бичил болон жижиг бизнесийн өсөлтийг үргэлжлүүлэн дэмжинэ. Энэхүү сегмент нь Банкны иргэдийн зээлийн багцын 22%-ийг бүрдүүлдэг юм. 2017 онд хэрэглээний зээл 70%-

иар буюу мэдэгдэхүйц дүнгээр өсөхөд хадгаламж барьцаалсан болон цалингийн зээлийн өсөлт чухал нөлөө үзүүлээ.

Бизнесийн банкны стратегийн хүрээнд ХасБанк Монгол Улсын 16,000 гаруй бизнесийн харилцагч байгууллагын санхүүгийн хэрэгцээг ханган ажиллаж байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд цогц үйлчилгээ үзүүлэх хүрээнд харилцагчдад зээл, хадгаламж, худалдааны санхүүжилт, гадаад валютын гүйлгээ, арилжаа, төлбөр тооцоо, ажиллагсдын цалин тавих, бэлэн мөнгөний менежмент болон санхүүгийн бусад үйлчилгээг хүргэж байна. Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч, харилцагч байгууллагуудад авлагын санхүүжилтийг зах зээл дээрх хамгийн бага өртөгтэйгээр, бичиг баримт бүрдүүлбэр хамгийн цөөн тоотой байхаар санал болгож, амжилттай хэрэгжүүлж байна. Бид 2017 онд Оюу Толгой ХХК-ийн дотоодын ханган нийлүүлэгч 30 компанид 120 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Харилцах дансны үлдэгдэл 29.0%, хугацаатай хадгаламж 37.7%-иар өссөнөөр татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хэмжээ 31.3%-иар өсч 1,284.9 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ нь харилцах, хугацаагүй хадгаламжийн хэмжээг өсгөх, сегментийн хамрах хүрээг өргөжүүлэх хамтарсан арга хэмжээнүүд, огтлолцоо худалдааг охин компаниуд болон бизнесийн сувгуудаар эрчимжүүлэх ажлын үр дүн байв.

Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 6.0%-иар өсч 922.1 тэрбум төгрөгт хүрлээ. ХасБанк өмнө нь Монголын эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор ОУСК, Голландын хөгжлийн банк, ОПИС тэргүүтэй зээлдүүлэгчдээс 169 сая ам.долларын синдикат зээл авч байсан бол 2017 оны эцэс гэхэд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор ЕСБХБ-наас 40 сая ам.долларын синдикат зээл шинээр аваад байна. Үүний үр дүнд эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнес, ахуй амьдралыг дэмжих зорилгоор зөвхөн тэдний авах бизнесийн зээлийн жилийн хүүг 4.2 нэгж хувиар бууруулах боломжтой болсон.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчилж баталсантай уялдан Банкны төв албаны зарим бүтэц, чиг үүргийг хамгаалалтын гурван бүсийн зарчимд нийцүүлж өөрчлөн зохион байгууллаа. ХасБанкны бүх ажилтнууд банкны нууцлал, компьютерийн зохистой хэрэглээ, кибер аюулгүй байдал, харилцагчийг хамгаалах зарчмууд, мөнгө угаахтай тэмцэх зэрэг сэдвээр жил бүр сургалтанд хамрагдаж цахим модуль дээр ажилласан байх шаардлагыг бий болгож нэвтрүүлэв.

ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдэл (ТСН)-ийн бусад охин компаниуд нь тогтвортой ашиг болон урт хугацааны хөгжил дэвшлийн стратегид

суурилсан, бүрэн хэрэгжихүйц бизнес загварыг сонгон авч хэрэгжүүлж байна. Тогтвортой өсөлтийн загварт тулгуурласан банк болохын хувьд бодит эдийн засаг тогтвортой өсч эрүүл нийгэм бүрэлдэхийн хэрээр эдийн засаг, нийгэмд үнэ цэнэ шинээр үүсч, эрүүл ашиг бий болно гэж бид үздэг.

Өнгөрсөн гурван жилд ТСН-ийн компаниуд оролцогч талуудтайгаа амжилттай хамтран ажилласны үр дүнд нийгэм, эдийн засагт 825 тэрбум төгрөгийн үнэ цэнийг шинээр бий болголоо. ТСН 2017 онд ажиллагсдын цалин хөлс, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг бэлтгэн нийлүүлэгч компаниудад төлсөн төлбөр, улсын төсөвт төвлөрүүлсэн татварын орлого болон бусад төлбөрөөр нийт 78.3 тэрбум төгрөгийн үнэ цэнийг дотоодын эдийн засагт шинээр бий болгосон байна. Бид томоохон корпорациудаас эхлээд жижиг, дунд бизнес эрхлэгчид болон иргэдийн санхүүгийн хэрэгцээг нь зээл, санхүүгийн түрээс, даатгал, хадгаламж зэрэг багц бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах замаар шийдвэрлэж байна. ТСН нь манай хамгийн чухал оролцогч тал болох зээлдүүлэгч, хадгаламж эзэмшигчдэд 119 тэрбум төгрөгийн хүү төлжээ. Үүний зэрэгцээ ТСН 2017 онд 24.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөв. ТСН-ийн хувьцааны үнэ 12.1%-иар өсч 14,346 төгрөг боллоо.

Бид өөрийн 700,000 гаруй идэвхтэй харилцагч, үйлчлүүлэгчдэд өмнөхөөс илүү олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүрч ажиллан, харилцан адилгүй өөр салбарт ажилладаг олон тооны түншүүдтэй хамтран ажиллах боллоо. Бид олон жилийн турш эмэгтэйчүүдэд санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй хүргэх ажлыг дэмжин ажилласан бөгөөд үүний үр дүнд Монгол Улсад эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаа ихээхэн өргөжин тэлж байна. 2017 оны эцсийн байдлаар манай нийт зээлдэгчдийн 63%-ийг эмэгтэй бизнес эрхлэгчид бүрдүүлжээ.

ХасБанк хүүхдүүдэд өөрсдийн ирээдүйн төлөө хуримтлал үүсгэхэд нь туслах зорилгоор “Ирээдүйн саятан” хүүхдийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг тууштай үргэлжлүүлсээр байна. Хамгийн чухал нь энэхүү бүтээгдэхүүнээр дамжуулж хүүхдүүдэд банкны тухай, мөнгө, хадгаламж, хуримтлал ямар чухал болохыг ойлгуулж мэдлэг олгох зорилготой юм. Үүний үр дүнд 200,000 гаруй хүүхэд ХасБанкны харилцагч, бидэнтэй хамтран ажиллагч болсон бөгөөд манай хадгаламж эзэмшигчдийн 40%-ийг зөвхөн хүүхдүүд бүрдүүлдэг боллоо. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах нь Монголын эдийн засгийн цаашдын өсөлт, хөгжилд хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт бид итгэдэг. ХасБанк орон нутаг дахь салбар, тооцооны төвүүд, АТМ сүлжээ болон хамгийн сүүлийн үеийн мобайл банкны технологиор

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

дамжуулж алслагдмал бүс, хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээ үзүүлсээр байна. Манай нийт харилцагчдын 45% нь нийслэл хотоос зайдуу, орон нутагт байна.

ХасБанкны төрөл бүрийн мэдлэг боловсрол, туршлага бүхий ажиллагсад, баг хамт олон нь Банкны өрсөлдөх чадварыг улам бэхжүүлж, харилцагчдын төрөл бүрийн санхүүгийн хэрэгцээг мэдэрч, тэдгээрт тохирох санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зохистой хүргэх боломжийг бүрдүүлдэг. 2017 оны эцсийн байдлаар Банкны бүтэн цагаар ажиллагсдын тоо 1322 (2016 онд 1304, 2015 онд 1429 байсан) байна. Ажиллагсдын дундаж нас 31.1 ба байгууллагад ажилласан жилийн дундаж нь 6.1 жил байна. Нийт ажиллагсдын 64.3%-ийг эмэгтэйчүүд, 35.7%-ийг эрэгтэйчүүд бүрдүүлдэг. Дээд түвшний удирдлагын 36%, дунд түвшний удирдах ажилтнуудын 48% нь эмэгтэйчүүд байна. Нийт 200 орчим ажилтан хуульд заасны дагуу төрөхийн өмнөх болон дараах үеийн ажлын чөлөө авсан байна.

Банк, санхүүгийн үйлчилгээ, цахим банк, мэдээллийн технологийн салбарт 35 гаруй жил ажилласан арвин туршлагатай, мэргэшсэн эксперт болох Арвинд Жоши манай Мэдээллийн технологи, цахим банк хариуцсан захирлаар Сандип Херагийн оронд томилогдлоо. ХасБанкны мэдээллийн технологид шинэ цар хүрээ бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн Сандип Херад талархал илэрхийлж, түүний олон улсын карьерт нь амжилт хүсэн ерөөе.

Франс Күүтт Иргэдийн банк хариуцсан дэд захирлаар манай удирдлагын багт томилогдлоо. Түүний Зүүн өмнөд Азийн санхүүгийн салбарт хуримтлуулсан баялаг туршлага манай иргэдийн банкны үйлчилгээг улам сайжруулахад тус дэм үзүүлэх болно. Банкны дээд түвшний удирдлагын баг тогтвортой ажиллаж байгаа бөгөөд бид дунд шатны удирдах албан тушаалтнуудыг улам бэхжүүлэхэд илүү төвлөрч ажиллав. Үүнийг ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, чадварлаг мэргэжилтэн шинээр ажилд авах замаар хэрэгжүүлсэн. Бид харилцагч төвтэй, бизнесийн зорилгод нийцтэй, олон талын мэргэжил, туршлага бүхий, үр дүнтэй хамтран ажилладаг, зорилго нэгтэй удирдлагын чадварлаг багтай байгаа нь Банкны цаашдын шинэчлэл, цахимжуулалтын үйл явцыг улам бүр эрчимжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

2017 онд бид ногоон санхүүжилтийн бизнесээ гүнзгийрүүлж, байгаль орчны хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч банкны байр сууриа бэхжүүлж чадлаа. ХасБанк нь дэлхийн Уур амьсгалын ногоон сан (GCF)-гийн Батламжит Байгууллагын хувьд олон тэрбум ам.долларын хөрөнгө бүхий тус сангаас таатай нөхцлөөр санхүүжилт авах эрх бүхий, Монголд байгаа цорын

ганц байгууллага юм. Тус сангаас санхүүжилт авах тухай хоёр санал 2017 онд GCF-ээр батлагдаад байна. Үүнд: (i) Эмэгтэй бизнес эрхлэгчдэд бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн зориулалтаар олгох 20 сая ам.долларын бизнес зээлийн хөтөлбөр; (ii) Нарны эрчим хүчний станцыг санхүүжүүлэх 8.65 сая ам.долларын төсөл орж байна. ХасБанкны хамтран санхүүжүүлж буй 10 Мегаваттын хүчин чадалтай, энгийн хэрэглээнд зориулсан нарны цахилгаан станц нь ажиллагааныхаа 25 жилийн хугацаанд нүүрсхүчлийн хийн ялгарлыг 306,750 тонноор бууруулж, 4,276,250 литр ус хэмнэх юм. Энэ нь 2009 онд эхэлсэн Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг түгээх хөтөлбөр хэрэгжсэн 7 жилийн хугацаанд жил бүр дунджаар 282,318 тонн нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулж байсан амжилт дээр нэмэгдэх шинэ алхам болж байна. ХасБанк Уур амьсгалын ногоон сан, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Байгаль орчин, уур амьсгалын сантай хамтран жил тутмын Ногоон санхүүжилтийн форумыг “Боломжийг бодит болгох нь” сэдвээр Монголд анхлан зохион байгууллаа.

Бид Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Хөгжил дэвшил гэсэн үнэт зүйлс дээр тулгуурласан банкны зарчмуудыг баримталдаг болохоо дахин нотолж, GABV холбооноос баталсан Катмандугийн Тунхаглалыг дэмжин 2017 онд нэгдэж орсон болно. ХасБанк, түүний ажиллагсдын үүсгэн байгуулсан Хөгжлийн Алтан сан холбоо ТББ-ын хүрээнд бид орон даяар хүүхдүүдэд санхүүгийн анхан шатны суурь боловсрол олгох байнгын хөтөлбөр хэрэгжүүлж ирлээ. ХасБанкны сүүлийн 7 жилийн турш ивээн тэтгэж ирсэн санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийн зарим хэсгийг дунд болон ахлах сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулаад байна. Ингэснээр Монгол хүүхэд бүр санхүүгийн суурь мэдлэг олж авах боломж бүрдэв.

ХасБанкны 2017 оны ололт, амжилт бол бүхий л оролцогч талуудын хамтын ажиллагаа, түүний дотор хувь нийлүүлэгчид, хөрөнгө оруулагчид, ТУЗ, ажиллагсад, зээлдүүлэгчид, олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын ТББ-ууд, харилцагчид, иргэний нийгэм, зохицуулагч байгууллагууд, хууль тогтоогчид болон Засгийн газартай нягт хамтран ажилласны үр дүнд юм. Дараагийн он жилүүдийн өсөлтийн замыг заасан, биднээс илүү шургуу, чигч тууштай ажиллагаа шаардсан 2020/20/20 стратеги одоо бидний өмнө байна.

Гүнээ хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал
М. Болдоо

Гүйцэтгэх удирдлага

(2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

Магваны Болдоо

Гүйцэтгэх захирал
2014.07.10-нд томилогдсон

Гүмэнжавын Цэвэгжав

Иргэдийн банк хариуцсан захирал
2015.09.23-нд томилогдсон

Торстен Клайн Бойнинг

Эрсдэл хариуцсан захирал
2017.01.01-нд томилогдсон

Арвинд Жоши

Мэдээллийн технологи хариуцсан захирал
2017.04.19 -нд томилогдсон

Төмөрбаатарын Тайшир

Хуулийн зөвлөх
2014.08.01-нд томилогдсон

Дашнямын Ашидмаа

Засаглал хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Юндэнгийн Гэрэлмаа

Зээл хариуцсан захирал
2006.01.18-нд томилогдсон

Ганибалын Амартүвшин

Ерөнхийлөгч
2014.07.10-нд томилогдсон

Ганзоригийн Эрдэнэбаяр

Санхүү хариуцсан захирал
2013.01.07 -нд томилогдсон

Ганзоригийн Зул

Хүний нөөц хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Энэбишийн Уламбаяр

Үйл ажиллагаа хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Энхбаярын Ундармаа

Ерөнхий аудитор
2016.05.05-нд томилогдсон

Сандагдоржийн Болд

Ерөнхий эдийн засагч
2016.09.12-нд томилогдсон

Иргэдийн Банк



Жилийн тайлан | 2017

2017 оны онцлох үйл явдал



Харилцагчийг өрийн дарамтаас хамгаалах

Өр орлогын харьцаа 60%-аас хэтрэхгүй байх



ATM бүх үйлчилгээний шимтгэл 0₮.

Зээлийн хүүгийн дээд хэмжээ **2%**



Зээлийн өргөдлийн хураамж 0₮



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор зах зээлийн дундаж хүүнээс жилийн 4.2%-аар бага хүүтэй зээл олгож эхэллээ.



17 байршилд 20 гаруй орлого авдаг ATM суурьлууллаа.



Харилцагчдадаа улам ойртож, 12 байршилд шинэ салбар нээлээ.


Зайсан, И-Март, Мишээл, Моннис, Ривер Гарден, ИСС Олон Улсын Худалдааны Төв, Энхтайваны гүүр, Шангри-Ла зочид буудал



МИАТ ТӨХК-тай хамтран МИАТ кредит картыг зах зээлд нэвтрүүлээ.




Харилцагчдынхаа захиалсан төлбөрийн картыг баталгаат шуудангаар хүргэж өгдөг боллоо



Интернэт сүлжээгээр ухаалаг утасгүй ч банкны үйлчилгээ авч болох Мобайл банк



Петровисын ШТС-уудаас картаа уншуулаад бэлэн мөнгө авах Cash Back үйлчилгээ



Гар утсан дахь интернэт банкны аппликейшны нууцлалыг улам баталгаажуулж хурууны хээгээр танидаг болголоо.



QR code-оор төлбөр тооцоо гүйцэтгэх Qpay үйлчилгээ



Олон улсын гүйлгээний SWIFT системийн "Аюулгүй байдлын стандарт"-ыг нэвтрүүлээ.



"Үнэ цэнт банкны үйлчилгээ үзүүлэх дэлхийн эвсэл" /Global alliance for banking on values/-ээс гаргасан Катмандугийн тунхаглалд нэгдэн орлоо.

Иргэдийн Банк

Иргэдийн Банкны гол стратеги, стратегийн зорилго нь харилцагчидад чанартай үйлчилгээ үзүүлэхийн тулд тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тогтсон стандарттай, ойлгомжтой, боломжийн үнэ өртөгтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, зохистой сувгаар хүргэж, эдгээрийг цаашид хөгжүүлж улам боловсронгуй болгох явдал юм. Үүнээс гадна, бид харилцагчидад өөрийн хэрэгцээнд тохирсон дансны төрлийг сонгож, байгаа газраасаа тохиромжтой цагтаа банкны үйлчилгээ авах боломж олгохын тулд Иргэдийн Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг янз бүрийн сувгаар дамжуулан энгийн хялбар аргаар хүргэхийг эрмэлздэг.

Өнөөдөр бид ийм боломжийг харилцагчиддаа олгож байгаа. Бүтээгдэхүүн үйлчилгээг авахдаа өөрийн хэрэгцээнд хамгийн тохиромжтой суваг ба хураамжийг хэрхэн сонгох талаар харилцагчиддаа мэдээлэл өгч сургах шаардлагатай байна. Одоогийн байдлаар банкны салбараар үйлчлүүлэх нь ихэнх харилцагчидын сонгодог суваг хэвээр байна. Бусад сувгаар хийгдэж буй үйлчилгээнийг хэмжээ нэмэгдүүлвэл энэ нь Банк болон харилцагчидын хувьд аль алинд нь илүү үр ашигтай шийдэл болох юм.

Иргэдийн Банкнаас гаргаж буй аливаа шийдвэрт харилцагчидыгаа ойлгох явдал гол хүчин зүйл болдог. Үйлчилгээнийхээ чанарт дүн шинжилгээ хийж, харилцагчидынхаа санхүүгийн хэрэгцээг илүү сайн ойлгохын тулд 2017 онд Иргэдийн Банк өмнөх жилүүдийн адил харилцагчидыгаа танин мэдэх судалгаагаа үргэлжлүүлэн явуулсан.

Иргэдийн Банк харилцагчидад үзүүлж буй үйлчилгээг сайжруулахад цаашид ч байнга анхааран ажиллана. Харилцагчидын сэтгэл санамжийг сайжруулахын тулд 2018 онд Харилцагчийн Үйлчилгээний Тусгай Нэгж байгуулан ажиллах төлөвлөгөөтэй байна.

Цахим сувгуудыг бэхжүүлэх нь

Технологи хүн бүрийн өдөр тутмын амьдралд нэвтэрч салшгүй нэгэн хэсэг болохын хэрээр харилцагчид маш хурдан “цахим” сэтгэлгээтэй болж байна. Иргэдийн Банк ийм шилжилттэй хөл нийлүүлэхийн тулд цахим борлуулалтын сувгуудыг хөгжүүлж, цаашид харилцагчидад тусгайлан зориулж бий болгох дижитал банкны үйлчилгээг үзүүлэх суурийг тавих зорилго бүхий багийг бүрдүүлэн ажиллаж байна.

Монголын Харилцаа, Холбооны Зохицуулах Хорооны статистик мэдээгээр, өнгөрсөн онтой харьцуулбал 2017 онд ухаалаг гар утастай иргэдийн тоо 21%-аар, гар утсаараа интернэт ашигладаг хүний тоо 50.2%-аар өссөн байна. Дата хэрэглээний өсөн нэмэгдэж буй ийм хандлага нь илүү олон төрлийн цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжийг харилцагчидад олгож байна.

Иргэдийн Банк 2016 оны амжилтан дээрээ тулгуурлан цахим технологид хийж буй хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, өдөр тутмын гүйлгээг төрөл бүрийн цахим сувгаар хийх боломжийг харилцагчидад олгож байна. Үүнээс гадна Иргэдийн Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний иж бүрдлийг харилцагчидад хялбар хүргэхийн тулд үйл ажиллагаагаа хялбаршуулж эхэлсэн. Ингэснээр салбаруудын үйлчилгээний хурд,

үр ашгийг сайжруулж, харилцагчидад анхаарал тавьдаг шуурхай ажиллагаатай банк болох ажлын эхлэлийг тавьж байна.

2017 онд цахим технологийн хөрөнгө оруулалт, стратегийн түншлэлээ үргэлжлүүлсний үр дүнд хялбар аргаар мөнгө гуйвуулах QRy төлбөрийн систем, ухаалаг утасгүй байсан ч банкны үйлчилгээг авах боломжтой Мобайл Банк 2.0 зэрэг шинэ, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлээ.

АТМ терминалын тоог нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг 2017 онд үргэлжлүүлэн хийв. АТМ-ын адил 24/7 хуваариар ашигладаг бэлэн мөнгө авдаг CRM-уудыг нэвтрүүлснээр харилцагчид бэлэн мөнгийг заавал салбар дээр очиж тушаах шаардлагагүй боллоо. Бэлэн мөнгөний хэрэглээг багасгаж, Иргэдийн болон Бизнес Банкны харилцагчдийн аюулгүй байдал, ая тухыг сайжруулах зорилгоор Худалдан авалт хийсэн цэгээс төлбөрийг цахим аргаар шилжүүлэх боломж олгодог буюу EFTPOS төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж ирсэн, цаашид ч үргэлжүүлэх болно. Бэлэн мөнгөний хэрэгцээ үргэлж байх учраас EFTPOS төхөөрөмжийг зөвхөн төлбөрт ашиглах бус, эдгээрийг мөн мөнгө гаргах боломжтой хослуулснаар илүү олон харилцагчидад хүрч тэдгээрийн бэлэн мөнгөний хэрэгцээг хангах ажлыг Петровисын шатахуун түгээх станцуудтай хамтран эхлүүлсэн.

Салбарын сувгийг бэхжүүлэх нь

Цахим банк өргөжих сүүлийн үеийн хандлага байгаа боловч салбарын биет үйлчилгээ ялангуяа хөрөнгө оруулалт, санхүүгийн бүтээгдэхүүний үйлчилгээний хувьд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно гэдэгт итгэлтэй байна.

Иргэдийн банкны хэрэглэгчдийн судалгаанаас үзвэл, Монголын харилцагчид банктai харилцаа холбоо тогтоохын тулд банкны салбар дээр очиж, банкны ажилтнуудаас санхүүгийн зөвлөгөө авах илүү сонирхолтой байдаг. Үүний үр дүнд, зарим салбарыг харилцагчидад ойртуулан шилжүүлж, салбар дээр шаардлага хангасан ажилтан шинээр авах, авч үлдэх, сургах ажилд хөрөнгө оруулалт хийлээ.

Банкны салбаруудыг үр ашигтай ажиллагаатай, найрсаг харилцаатай, сүүлийн үеийн технологиор тоноглогдсон орчин үеийн “ирээдүйн салбар” болгохын тулд салбаруудад хийх хөрөнгө оруулалтыг цаашид үргэлжлүүлнэ. Харилцагчид салбарын хаалгаар ороод л найрсаг орчинтой учрах ёстой.

Гэвч юуны өмнө салбаруудын ашигт ажиллагаа, үйл ажиллагааны тогтвортой байдал чухал учраас салбарын үйл ажиллагаа цаашид сайжрах хандлагагүй бол тухайн салбарыг хаах эсвэл өөр газарт шилжүүлэн байршуулах зэрэг өмнөх онуудад хийгдэж байсан арга хэмжээг авч ажиллана. 2016 онд салбаруудын тоо 86 байсан бол 2017 оны эцсийн байдлаар 90 болж өссөн байна.

Салбарууд



Улаанбаатар хот	
Салбар	11
Тооцооны төв	25
Өргөтгөл	2
Хөдөө орон нутаг	
Салбар	23
Тооцооны төв	17
Өргөтгөл	4

НИЙТ

82



Иргэдийн Банк

Иргэдийн банкны бүтээгдэхүүнүүд

Карт

Иргэдийн Банкны стратегийн хүрээнд EFTPOS, АТМ-ын сүлжээгээрээ дамжуулан дебит картны хэрэглээг хөхиүлэн дэмжих бөгөөд энэ нь бараа, үйлчилгээний төлбөрт бэлэн мөнгөний оронд дебит карт ашиглах боломжийг нэмэгдүүлж, төлбөр тооцооны аюулгүй байдлыг сайжруулж, харилцагчидад мөнгөний үнэ цэнийг ойлгуулж, хадгаламжийг нэмэгдүүлэхээс гадна салбаруудын үйл ажиллагааны зарим зардлыг ч бууруулахад

тус дөхөм болох юм. Дебит картны зэрэгцээ 2017 оноос кредит карт гаргаж эхэлсэн. Иргэдийн Банк 2018 онд картын бизнесийг цаашид өргөжүүлж, МИАТ үндэсний агаарын тээврийн компанитай хамтран гаргасан, аялал худалдан авалт бүрт урамшуулал цуглуулдаг кредит карт шиг том компаниудтай хамтарсан брэндийн кредит карт гаргах зэргээр шинэ хэлбэрийн хамтын ажиллагаа бий болгоход анхаарч ажиллах болно.

Харилцагчийн сэтгэгдэл:

Элбэгдоржийн Элбэгжаргал
Ирээдүйн саятан

Анх 2003 онд манай ээж СХД-ийн Саппорогийн автобусны буудлын ард байрлах ХасБанкны салбарт дүү бид хоёрт Ирээдүйн саятан хадгаламж нээлгэж байсан. Энэ бол миний банкинд өөрийн гэсэн данстай болж банктai харилцаж үзсэн анхны тохиолдол байлаа. Сар бүрийн орлогоос тодорхой хэмжээний мөнгийг хадгаламжинд минь хийдэг байсан. Ирээдүйн саятан хадгаламжтай байх үед Хасхүүгийн гарын бэлгийг хүүхдийн баяр болгоноор авдаг байсан нь сайхан дурсамж үлдээжээ. Цодгор монгол гэр шиг Хасхүүгийн түлхүүрийн оосор, тоглоом гээд хөөрхөн эд зүйлсээр дүү бид хоёр тоглодог байж билээ.



2013 онд би арван жилийн ахлах сургуулиа төгсч Монгол Улсын Их Сургуульд Эдийн засагч мэргэжлээр элсэн орсон. Энэ үед 18 нас хүрч хадгаламжийн хугацаа дууссан ба хуримтлуулсан мөнгөөрөө сургалтын төлбөрөө төлж, шинэ ном,



хэрэгцээт зүйлсээ худалдан авсан. Тэр үед дөрвөн хүүхдийн сургалтын төлбөр, амьжиргааны хэрэгцээ зэргийг хангадаг байсан аав ээжид минь хүүхдийн Ирээдүйн саятан хадгаламжийн хуримтлал маань их нэмэр болсон билээ. Мөн би хуримтлуулах нь ямар их үр ашигтайг ойлгосон ба надад зориулж хуримтлал үүсгэсэн ээждээ болон Хасбанкинд баярлаж явдаг. Өнгөрсөн жил би МУИС-ийг амжилттай төгссөн бөгөөд анхны харилцагч банк минь болох ХасБанкинд ажилд орж, ажиллаж байгаадаа баяртай байна.

Тогтвортой ажиллагаа манай зах зээл дэх байр суурийг өргөжүүлж байна

ХасБанкны зорилго нь Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчидад үнэ цэнэ авчирдаг санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг насан туршийн санхүүгийн түнш болох явдал юм. Бид зорилгодоо хүрэхийн тулд ил тод нөхцөлтэй, хялбар, ойлгомжтой бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийг зорьж байна.

2015 онд ХасБанкны үйл ажиллагаанд Францад төвтэй, бичил санхүү, нийгмийн хариуцлагын рейтинг тогтоодог, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Planet Rating агентлаг үнэлгээ хийж, дэлхий нийтээр дэмжигдсэн Харилцагчийг хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн банк хэмээн Ухаалаг Хөдөлгөөний Гэрчилгээг олгосон билээ. 2017 онд ТУЗ-өөс дээрх

Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг баримталж ажиллахаа албан ёсоор дахин нотолсон болно.

ХасБанк нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн Харилцагчийг хамгаалах зарчмуудыг баримталдаг хэмээн Ухаалаг Хөдөлгөөний Гэрчилгээгээр батламжлагдсан, нийтдээ 41 сая хүнд хүрч үйлчилдэг дэлхийн 100 гаруй санхүүгийн байгууллагуудын нэг юм.

Компанийн нийгмийн хариуцлага нь бүтээлч сэтгэлгээ, харилцагч төвтэй үйлчилгээ, мэргэжлийн ур чадвар, санхүүгийн хүртээмж, манлайлах эрч хүч зэрэг үнэт зүйлсийн хамт ХасБанкны байгууллагын соёлын нэгэн салшгүй хэсэг юм.

Иргэдийн хадгаламж

Иргэдийн Банк 2016 оны өсөлтийг үргэлжлүүлж 2017 онд иргэдийн хадгаламжийг өнгөрсөн онтой харьцуулахад 33%-аар нэмэгдүүллээ. Зээлийн өсөлтийн нэлээд хэсгийг харилцагчдийн хадгаламжийн эх үүсвэрээс хангаж байгаа бөгөөд ингэснээр Иргэдийн Банкны зээл-хадгаламжийн харьцааг 82 хувьд хүргэв. Иргэдийн хадгаламжийн 85 хувь нь хугацаат хадгаламжаас бүрдэж байна.

Иргэдийн зээл

2017 онд хэрэглээний зээл өнгөрсөн оныхтой харьцуулахад 70%-аар өслөө. Энэ нь 2016 оноос хэрэгжүүлж буй стратегийн хүрээнд хадгаламж барьцаалсан зээл ба цалингийн зээлийн өсөлттэй холбоотой юм. Хэрэглээний зээл иргэдийн зээлийн багцад 53%-ийг эзэлдэг. Харин засгийн газрын 8%-ийн зээлийн санхүүжилт зогссоны улмаас орон сууц худалдан авах зориулалттай ипотекийн зээлийн багц 9%-аар буурсан.

ХасБанк бичил болон жижиг бизнесийн өсөлтийг дэмжсэн хэвээр ажиллаж ирлээ. Бичил болон жижиг зээл Иргэдийн Банкны зээлийн багцын ойролцоогоор 22%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд 2018 онд энэхүү бүлгийн харилцагчидад шинэ, эсвэл сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох дээр анхаарал тавьж ажиллана.



Харилцагчдыг хамгаалах зарчмууд

Бид дэлхий дахинд дэмжигдсэн Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Францад төвтэй, бичил санхүү, нийгмийн хариуцлагын рейтинг тогтоодог, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Planet Rating агентлаг 2015 онд ХасБанкинд үнэлгээ хийж, Ухаалаг хөдөлгөөний батламж бичиг олгосон билээ. 2017 онд манай ТУЗ дээрх Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг баримталж ажиллахаа албан ёсоор дахин нотолж, Харилцагчдыг хамгаалах зарчмуудын бодлогоо шинэчлэн гаргасан юм.

1

Бүтээгдэхүүний зохих ёсны дизайн, хүргэлт

Бид бүтээгдэхүүн, түүнийг хүргэх сувгийн дизайныг харилцагчдад хохирол учруулахгүйгээр гаргахад зохих анхаарал тавина. Бүтээгдэхүүн, хүргэлтийн сувгийн дизайн гаргахдаа харилцагчдын онцлогийг тусгана.

Хэт их өр зээлтэй болохоос сэргийлнэ

Бид зээл олгох ажлын бүхий л үе шатанд харилцагч хэт их өрөнд оролгүйгээр зээлээ төлөх чадвартай эсэхийг тодруулахад зохих анхаарал тавьж ажиллана. Бид хэт их өр зээлтэй болохоос сэргийлэх дотоод систем нэвтрүүлэн, мониторинг хийж, зах зээлийн түвшний зээлийн эрсдэлийн удирдлагаа сайжруулах хүчин чармайлтыг дэмжиж ажиллана.

2

3

Ил тод байдал

Бид тодорхой, хангалттай, цаг үеийн мэдээллийг мэдлэгтэй шийдвэр гаргах хэмжээнд ойлгож чадах хэлбэр, хэлээр харилцагчдад хүргэхийг чармайж ажиллана. Бүтээгдэхүүний үнэ өлтөг, нэр томъёо, нөхцөл болзлын тухай ил тод мэдээллийн хэрэгцээнд илүү анхаарал тавина.

Үнийг хариуцлагатай тогтооно

Үнэ тогтоох, нэр томъёо, нөхцөл гаргахдаа Банкны тогтвортой ажиллагааг хангахын зэрэгцээ харилцагчдад боломжийн хэмжээнд байлгахад анхаарна. Байгууллагын удирдлага хадгаламжийн бодит өгөөжийг ашигтай байлгахын төлөө ажиллана.

4

5

Үйлчлүүлэгчдэд шударга, хүндэтгэлтэй хандана

Бид харилцагчидтайгаа шударга, хүндэтгэлтэй харьцахыг чармайн ажиллах болно. Бид ялгаварлан гадуурхахгүй. Байгууллагын удирдлага авилгалын үйлдэл, мөн ажилтнууд болон агентуудын түрэмгий, зүй бус харьцаа, ялангуяа зээл борлуулах, өр барагдуулах ажиллагааны үеэрх тийм байдлыг илрүүлэх, засаж залруулах зохих ёсны арга хэмжээ авч ажиллана.

Харилцагчийн мэдээллийн нууцлалт

Хувь харилцагчийн дата мэдээллийн нууцлалтыг хууль тогтоомжийн хүрээнд хүндэтгэн ажиллана. Тийм дата мэдээллийг зөвхөн холбогдох мэдээлэл бүртгэж авах явцад, эсвэл хуульд өөрөөр заагаагүй бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд л ашиглана.

6

7

Санал гомдол барагдуулах механизм

Байгууллагын удирдлага харилцагчдын санал гомдлыг хүлээн авч, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх хариуцлагатай механизм ажиллуулж, асуудал тус бүрийг шийдвэрлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулахад ашиглана.

Бизнес Банк



Бизнес банк

ХасБанк нь Монгол Улсын хэмжээнд 16,000 гаруй байгууллагад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Харилцагчид хадгаламжийн үйлчилгээнээс гадна шаарлагатай санхүүжилтээ авах боломжтой. Бид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхдээ харилцагчийн бизнес, түүний онцлогийг харгалзан үзэж зээл, харилцах, хадгаламжийн данс, гадаад худалдааны санхүүжилт, валют арилжаа, төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгийн удирдлага болон бусад нэмэлт санхүүгийн үйлчилгээнүүдийг цогцоор нь хүргэн ажиллаж байна. Түүнчлэн бид байгууллага төдийгүй түүний хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлага, ажиллагсадад мөн адил банкны үйлчилгээг цогцоор нь хүргэхийг зорьдог.

ХасБанк байгууллагын зах зээлд жижиг, дунд бизнесүүд болон томоохон байгууллагуудад нэгэн зэрэг хүрч үйлчилдэг. Жижиг байгууллагуудад банкны үйлчилгээг хүргэхдээ бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг энгийн, хялбар байлгаж, бүрдүүлэх материалыг цөөлөх бодлогыг өнгөрсөн жилүүдэд баримталж ирлээ. Харин дунд бизнесүүдийн хувьд зээл, хадгаламж, төлбөр тооцоо, худалдааны санхүүжилт, ажиллагсадад зориулсан банкны үйлчилгээг цогцоор хүргэх нь тэдгээрийн хэрэгцээнд илүү тохиромжтой гэж үздэг. Томоохон байгууллагуудад банкны үйлчилгээ үзүүлэхдээ ямагт харилцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн багцалж хүргэдэг.



Худалдааны санхүүжилт:

- ХасБанк нь 2017 онд нийтдээ 100 тэрбум гаруй төгрөгийн дүнтэй 1900 орчим хэлцэлийг санхүүжүүлсэний дүнд дотоодын зах зээл байр сууриа хэвээр хадгалж үлдэлээ. Манай банкны хөрөнгө оруулалтын өвөрмөц бүтэц, үйл ажиллагааны ил тод байдал нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас худалдааны санхүүжилтийн эх үүсвэрийг таатай нөхцөлөөр авахад үргэлж хувь нэмрээ оруулсаар ирсэн.
- Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч байгууллагууд ХасБанкнаас авлагын санхүүжилтийн зээлийг бага хүүтэйгээр, чирэгдэл багатайгаар авах боломжтой. 2017 онд бид 30 орчим байгууллагад 120 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт олгож ажиллалаа.

ЖДБ бизнесийн зээл:

- 2016, 2017 онд ХасБанк жижиг, дунд бизнес эрхлэгчид, тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор олон улсын санхүүгийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчидтай санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээнүүдийг амжилттай байгууллаа.
- Үүний үр дүнд 2017 онд 44.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зах зээл дээрх хамгийн бага хүүтэйгээр эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон байгаа.

Бид үндэсний үйлдвэрлэгчиддээ өсөн хөгжихөд нь дэмжэг үзүүлж, олон улсын хүнсний аюулгүй байдал, чанарын стандартыг хэрэгжүүлж амжилтад хүрч байгаад баяртай байна.

Корпорейт харилцагчийн түүх:

СҮҮ ХК
Сүү, сүүн бүтээгдэхүүн



Сүү ХК нь 1958 онд Улаанбаатар хотыг сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор үүсгэн байгуулагдсан ууган үйлдвэр юм. Өнөөдөр Сүү ХК нь “Малчны хотноос таны гэрт” уриан дор нийт 2500 гаруй малчид фермерүүдтэй хамтран ажиллаж Монгол Улсын хамгийн том сүү бэлтгэлийн нэгдсэн системийг бий болгоод байна. Түүнчлэн хоногт 200 тон сүү боловсруулах хүчин чадалтай хамгийн том сүүний үйлдвэр юм. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд тус компани үйлдвэрлэлийн зарим шугамыг бүрэн автоматжуулж, шинэ технологи нэвтрүүлэхийг

зэрэгцээ Орхон аймагт боловсруулах үйлдвэр ашиглалтанд оруулав.

ХасБанк Сүү ХК-д 2013 оноос эхлэн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээл болон



худалдааны санхүүжилтийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. 2017 онд Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн охин компани болох Тэнгэр Капитал ХХК нь “Сүү” бондын туслах андеррайтераар ажиллалаа.



ЖДБ харилцагчийн түүх:

ОЧИРДАГИНАС ХХК

Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл

ХасБанк болон Очирдагинас ХХК-ийн хамтын ажиллагаа 2009 онд эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээл олгосноор эхлэж байсан бол одоо үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, үйлдвэрийн байрны өргөтгөл, цаашлаад олон улсын стандарт хангасан шинэ үйлдвэрийн байрны төсөл дээр хамтран ажиллах зэргээр өргөжин тэлээд байна. Хамтын ажиллагааны хүрээнд бид нийт 20 гаруй бизнесийн зээлийн санхүүжилтийг олгоод байна.

Очирдагинас ХХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Хангинах:

“Өнгөрсөн хугацаанд бидний гаргасан томоохон амжилт, бүтээсэн бүтээн байгуулалтууд бүгд ХасБанктай холбоотой. ХасБанкны зээл шийдвэрлэх процесс хурдан, бидний хэрэгцээ шаардлагыг сонсож, ойлгодог. ХасБанкаар үйлчлүүлэхэд таатай байдаг. Бидний хэрэгцээ шаардлагыг мэдэрч, мэргэжлийн өндөр түвшинд үйлчилж чаддаг.”



ХасБанк нь Очирдагинас ХХК-ийн өсөлт хөгжлийн үе, шат бүрд хамт байж, дараах томоохон төслүүдийн санхүүжилтийг хийсэн. Үүнд:

- 2010 онд компанийн таван жилийн ойн баярын өдөр ашиглалтанд оруулсан хоёр давхар үйлдвэрийн барилгын өргөтгөлийн төсөл
- 2012 онд “Баянмонгол” лаазалсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөл

- 2013 онд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох зорилгоор хэрэгжүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээний таван давхар барилгын төсөл
- 2017 онд ISO 22000 олон улсын стандарт хангасан, 500 тон хүчин чадал бүхий агуулахтай 3,657.0 мкв талбай бүхий үйлдвэрийн төсөл.

Очирдагинас ХХК 2005 онд анхлан хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ эхлүүлж байсан бол өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх замаар технологийн дэвшил шинэчлэлийг тасралтгүй хийж, бүтээгдэхүүний чанар, амт, савлагаанд тогтмол анхаарч, хүнсний салбарын чухал үзүүлэлт болох эрүүл ахуйн



шаардлагыг бүрэн биелүүлж байсны үр дүнд өнөөдөр зах зээлийн тэргүүлэгч үйлдвэрүүдийн нэг болон өргөжөөд байна. Үүний нэг илрэл нь ХБНГУ-ын Франкфурт хотод зохион байгуулагдсан IFFA-2016 буюу мах, махан бүтээгдэхүүний олон улсын том үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцсон явдал юм. Уг үзэсгэлэн худалдаанаас Очирдагинас ХХК-ийн таван төрлийн хиам, махан бүтээгдэхүүн шагнал хүртсэн юм.

Бид үндэсний үйлдвэрлэгчиддээ өсөн хөгжихөд нь дэмжэг үзүүлж, олон улсын хүнсний аюулгүй байдал, чанарын стандартыг хэрэгжүүлж амжилтад хүрч байгаад баяртай байна.

ЕСӨН ОД ХХК

Шоколад, амттаны үйлдвэрлэл

Алтан Говь шоколад - Монголд үйлдвэрлэв.

Есөн Од ХХК нь ХасБанктай 2012 оноос хойш харилцаж байгаа бөгөөд байгууллагын харилцах данс, байгууллагын ажилчдын цалин тавих үйлчилгээ, зээлийн үйлчилгээ зэрэг банкны бүхий л бүтээгдэхүүн үйлчилгээг ашигладаг.

Есөн Од ХХК нь 1991 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй баялаг түүхтэй компани юм. Анх хоршоо хэлбэрээр байгуулагдаж, гадаад дотоод худалдааны чиглэлээр буюу барилгын материал болон хүнсний бүтээгдэхүүний худалдаа эрхэлж байсан бол 1998 оноос Баруун Европын орнуудын



брэнд бүтээгдэхүүн болох Cote d'Or, Mars, Snickers, Twix, M&M, Bounty болон Cadbury гэх мэт төрөл бүрийн шоколадыг импортлон борлуулж эхэлсэн байна. Ийнхүү 2003 онд, өөрсдийн туршлага судалгаанд үндэслэн Монголдоо шоколадны үйлдвэр байгуулах стратегийн шийдвэр гарган 2004 онд Бельги улсын тоног төхөөрөмж болон “ноу хау”-г Монгол улсад нэвтрүүлсэн байна. Шоколад үйлдвэрлэлийн төслийн үйл ажиллагааг явуулахын тулд Бельги болон Есөн Од ХХК-ийн хөрөнгө оруулалттай Есөн Од Фүүд Интернэшнл ХХК-г байгуулсан юм.

Есөн Од Фүүд Интернэшнл ХХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, сав баглаа боодлын чанараа сайжруулж, бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлж, говь брэндийн шоколадыг Японы зах зээлд экспортолж эхлээд байгаа бөгөөд цаашид гадаад зах зээлээ тэлж ажиллах зорилго тавин ажиллаж байна.

1990-ээд онд хоршоо хэлбэрээр байгуулагдаж байсан олон, олон бизнесүүд одоо сураг алдарсан байдаг бол харин Есөн Од ХХК-ийн бизнес өнөөдрийг хүртэл амжилттай явсаар байна. Энэ бол тууштай байдал бодит боломж болж чадахыг харуулсан амжилтын түүх, бусдад урам өгөх үнэн жишээ юм.

МОНФҮҮДЛАНД ХХК

Өглөөний цай, үр тарианы бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Монфүүдланд ХХК нь манай шинэхэн харилцагчдын нэг бөгөөд 2017 оны 1 сард ХасБанкны цалин тавих үйлчилгээг ашиглан ажилчдынхаа цалинг олгож эхлэснээр компанийн ажилчид Банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах боломжтой болсон юм.



2014 оноос эхлэн овъёос, бүхэл үр зэрэг үр тариа, зөгийн бал, ааруул, жимс, жимсгэнээр эрүүл мэндэд тустай, амт чанартай хүнсний бүтээгдэхүүн

үйлдвэрлэж эхэлжээ. Ийнхүү анх удаа Монголдоо үйлдвэрлэсэн өглөөний хоол (Granola cereal) болох Мовъёос нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн нь хүнсний томоохон супермаркетуудаар худалдаалагддаг эрэлттэй бүтээгдэхүүн болж, “Бүтээлч Монгол 2014”, “Улаанбаатарт Үйлдвэрлэв 2014” үзэсгэлэн худалдаанаас тус тус шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан байна. 2017 онд өөрийн шинэ үйлдвэр болон оффисын барилгыг ашиглалтанд оруулсан бол үйлдвэрлэлээ өргөжүүлэн тэлж, тариалангийн газар худалдан авч өөрсдөө овъёосоо тарих болсноор цаашид хэрэглэгчиддээ 100% байгалийн гаралтай, эрүүл мэндэд ач тустай бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна.

Бид Монфүүдланд ХХК-д маш их боломж байгаа гэдэгт итгэдэг. ХасБанк нь харилцагчдынхаа бизнесийг дэмжсээр байх бөгөөд цаашид өсөн дэвжих амжилтын түүхийг нь хамтран бичих чин хүсэлтэй байдаг.

Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд



www.ifc.org

Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) болон ХасБанкны хамтын үйл ажиллагаа нь 2000 онд эхэлсэн. ОУСК нь Монголын санхүүгийн салбарт хамгийн том синдикат зээл болох зээлийг 2016 онд ХасБанкинд олгосон. Мөн ОУСК нь ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн нэг юм.



www.ebrd.com

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк нь Монгол Улсын жижиг дунд бизнес эрхлэгч нарыг дэмжин ажилладаг ба ХасБанкинд 2006 оноос хойш хөрөнгө оруулж буй бидний чухал хамтрагч байгууллага юм. 2017 онд ЕСБХБ нь ХасБанкинд синдикат зээл олгосон.



www.adb.org

Азийн Хөгжлийн Банк нь Монгол Улсын хөдөө орон нутаг болон гэр хорооллын хүн амд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор анх 2014 онд ХасБанкинд урт хугацааны зээл олгосон.



www.bibessen.de

Монгол Улс дахь бичил аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлэх зорилготойгоор Bank Im Bistum нь ХасБанкинд зээл олгосон.



www.calvertfoundation.org

АНУ-ын бичил санхүүгийн Calvert Сан анх 2014 онд ХасБанкинд зээл олгож байсан.



www.dwmkmarkets.com

2017 онд DWM ХасБанкинд нэмэлт эх үүсвэрүүдийг өөрийн шинэ сангаас олгосноор хоёр байгууллагын хамтын ажиллагаа улам бүр өргөжсөн.



www.fmo.nl

Нидерландын Хөгжлийн Банк (FMO) тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа явуулж, 2007 оноос хойш ХасБанкинд зээлийн болон худалдааны санхүүжилтийн эх үүсвэрийг олгосоор ирсэн.



www.cyranо-management.com

Cyranо нь 2012 оноос хойш ХасБанкны идэвхтэй зээлдүүлэгчдийн нэг болсон бөгөөд хөгжиж буй улс орнуудын бичил санхүүгийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.



www.cargill.com

2016 онд IFC-гийн зохин байгуулсан синдикат зээлийн хүрээнд Cargill анх ХасБанктай хамтарч ажиллаж эхэлсэн бөгөөд ХасБанкинд зээлийн эх үүсвэр болон худалдааны санхүүжилтийг олгож байгаа.



www.incofin.com

ХасБанкны урт хугацааны түнш болох Incofin нь 2017 онд ХасБанкинд хоёрдох санхүүжилтийн эх үүсвэрийг олгосон.



www.finnfund.fi

IFC-гаас удирдан зохион байгуулсан синдикат зээлийн хүрээнд 2016 онд Finnfund нь ХасБанкинд зээл олгосон.



en.ibec.int

IFC-гаас удирдан зохион байгуулсан синдикат зээлийн хүрээнд 2017 онд IBEC ХасБанктай хамтран ажиллах гэрээг дахин сунгаж, шинэ эх үүсвэр олгосон.



www.responsability.com

responsAbility Investments AG нь 2008 оноос хойш ХасБанкны санхүүгийн түншээр хамтран ажиллаж байгаа бөгөөд 2016 оноос эхлэн ХасБанкны ногоон зээлдүүлэгч нарын нэг болох Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангаас олгосон санхүүжилтийг хариуцан ажиллаж байна.



www.symbioticsgroup.com

Symbiotics нь ХасБанкны санхүүгийн найдвартай түншүүдийн нэг бөгөөд ам.долларын болон төгрөгийн эх үүсвэрийг олгодог.



www.triodos.com

Триодос Банк нь ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигч бөгөөд ХасБанкинд урт хугацаатай зээл олгодог. ХасБанк Triodos-той 10 гаруй жил хамтран ажиллаж байна.



www.swedfund.se

IFC-гаас удирдан зохион байгуулсан синдикат зээлийн хүрээнд 2016 онд Swedfund ХасБанкинд зээл олгосон.



www.iib.int

IFC-гаас удирдан зохион байгуулсан синдикат зээлийн хүрээнд 2016 онд IIB ХасБанкинд зээл олгосон.



www.blueorchard.com

BlueOrchard өөрийн удирдлага доорх MIFA болон BOFA сангаар дамжуулан ХасБанкинд зээл олгосон.



www.proparco.fr

ХасБанк 2013 оноос хойш Proparco-той жижиг дунд бизнес эрхлэгч нарт тогтвортой санхүүжүүлэлтийг олгохоор чиглэлээр хамтран ажиллаж байгаа ба уг хамтын ажиллагааны хүрээнд Proparco-гоос урт хугацаатай зээлийг аваад байна.



www.oe-eb.at

ХасБанк жижиг дунд бизнес эрхлэгч нарыг дэмжих зорилгоор 2014 онд Австрийн Хөгжлийн Банк (OeEB)-наас урт хугацаатай зээл авсан.



www.sifem.ch

SIFEM ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах зорилготой санхүүжилтийг олгодог ХасБанкны санхүүгийн түншүүдийн нэг юм.



www.ifcamc.org

2016 онд WEDF нь Монголын эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор ХасБанкинд урт хугацааны эх үүсвэрийг олгосон.



www.greencclimate.fund

ХасБанк Уур Амьсгалын Ногоон Сан (GCF)-гийн Ази дахь хамгийн анхны итгэмжлэгдсэн хувийн байгууллага болсон бөгөөд Монгол Улсын ногоон хөгжлийг дэмжих зорилгоор 2017 онд анх GCF-аас урт хугацааны эх үүсвэр авсан.



www.gcptf.lu

Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сан (ДДУАХАС) нь Монголд нүүрстөрөгчийн хийг бууруулах бизнесүүдийг санхүүжүүлэх зорилгоор урт хугацааны эх үүсвэрийг 2017 онд ХасБанкинд олгосон.



www.caixabank.es

CAIXA нь 2017 оноос ХасБанктай хамтын ажиллагааг эхлүүлж, худалдааны санхүүжилтийн олон төрлийн эх үүсвэрийг олгосоор байна.



www.deginvest.de

KfW Группийн салбар байгууллага болох Германы Хөгжлийн Банк (DEG) 2008 оноос хойш ХасБанкинд санхүүжилтийн эх үүсвэрийг олгож байна.



www.frankfurt-school.de

FS Financial Services нь өөрийнхөө төрөл бүрийн сангуудаар дамжуулан ХасБанкинд зээл олгосон.



www.opic.gov

2017 онд OPIC нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор ХасБанкинд урт хугацааны эх үүсвэрийг олгосон.

Хүний нөөц



Жилийн тайлан | 2017

Манай ажиллагсад

НИЙТ
АЖИЛЛАГСДЫН ТОО

1322

Гэрээгээр
ажиллагсад
85

Урт хугацааны
чөлөө
30
199



ТӨВ
АЛБА
456

ХОТЫН
САЛБАНУУД
446


ОРОН
НУТГИЙН
САЛБАР
420

ДЭЭД ДУНД ШАТНЫ
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА
116 ♀ 46%

♂ ЭРЭГТЭЙ
472

♀ ЭМЭГТЭЙ
850

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ЭЗЛЭХ ХУВЬ
64.3%



СУРГАЛТАД ХАМРАГДСАН

3918



НИЙТ ХҮН/ЦАГ

49095 *

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

₮ 684 САЯ



ШИНЭ
АЖИЛЛАГСАД
289

Ажил
горилогчдын тоо
2718



Хүний нөөц

Манай ажилтнууд бидний амжилтын тулгын чулуу билээ. Байгууллагын соёл, үнэт зүйлсээр дамжуулан ажилтнуудад ХАС гэдэг арга барилын нэгдмэл санаа, Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох ухамсарыг төлөвшүүлдэг.

Манай хүний нөөцийн бодлого олон талт, аюулгүй, хүртээмжтэй ажиллах орчинг бүрдүүлэх, өрсөлдөхүйц хэмжээний цалин хөлс олгох, ажил эрхлэлтийн шударга арга барилаар ажиллах, сургалт хөгжлийн боломж олгох зэрэгт чиглэж байна. Бид төрөл бүрийн нийгмийн хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудынхаа амьдралын чанарыг дээшлүүлэх тууштай байр суурийг баримталж байна.

2017 оны эцсийн байдлаар, манай баг 1322 үндсэн ажилтантай болсон бөгөөд 2016 онд 1304, 2015 онд 1429 ажилтантай тус тус байжээ. Ажилтнуудын дундаж нас 31.1 бол банкинд ажилласан дундаж хугацаа 6.1 жил байна. Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийн шаардлагын дагуу 2017 оны туршид нийт 200 орчим ажилтны ажлын байрыг хүүхэд асрах чөлөөний хугацаанд хадгалсан бөгөөд хүүхэд асрах чөлөөнөөс 96 ажилтан ажилдаа буцаж орсон.

ОНЦЛОХ НЬ

Тогтвортой хөгжихийн тулд ажилтнуудын харилцагчдад чанартай үйлчилгээ, шийдэл үзүүлэх чадварыг сайжруулж бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа. Эрсдэл, мэдээллийн технологи, иргэдийн банкны чиглэлийн дээд шатны удирдах албан тушаалд стратегийн ач холбогдол бүхий мэргэжилтнийг ажиллуулах, дунд шатны менежерүүд, салбарын захирлуудын бүтцийг төрөлжүүлэх нь чухал асуудал байв.

Нийт хувийн банкир, зээлийн мэргэжилтнүүдийг дотоод тусгайлсан сургалтад хамруулж,

бизнесийн банкны фронт болон дундын албаны мэргэжилтнүүдэд зээлийн ахисан шатны сургалтыг зохион байгуулж, харилцагчидтай харилцах харилцааны болон зээлийн шийдвэрийн чанарыг сайжруулж, бизнесийн өсөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангалаа. Иргэдийн банкны бүх мэргэжилтнүүдийг бүтээгдэхүүний тухай мэдлэгийн цахим сургалтад хамруулж, зөвлөгөө өгөх ур чадварыг хөгжүүлэн банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэхэд анхаарав.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХАДГАЛАХ

Эрсдэлийн тогтолцоо шинээр батлагдсантай холбоотойгоор бүх чиг үүргийн хүрээг хамгаалалтын гурван шугамаар шинэчлэн зохион байгуулсан. Одоо явагдаж байгаа сургалт нь ажилтнуудыг эрсдэлийн талаар ойлголт, мэдээлэлтэй болгох чиглэлээр хийж буй ажлын салшгүй хэсэг юм. Нийт ажилтнууд мөнгө угаах, банкны нууцлал, компьютерийн зохистой бус ашиглалт, цахим аюулгүй байдал, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зарчмууд зэрэг сэдвээр бэлтгэсэн цахим сургалтуудад жил бүр хамрагдсан байх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд, эрсдэлийн хяналтын үзүүлэлтүүдийг ажилтнуудын гүйцэтгэлийн гол үзүүлэлтэд оруулсан.

АЛБАН ЖУРМЫН АМРАЛТ

Банкнаас жил бүр хамгийн багадаа 10 ажлын өдөр ажил үүргээсээ тасралтгүй амралт авсан байх бодлогыг мөрдөхийг өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ажилтнуудаас шаардан ажиллалаа. Ажлаас албан журмын амралт авсан үед ажилтнууд өөрийн биеэр болон цахим арга хэрэгслийг ашиглан өөрсдийн үндсэн үүргийг гүйцэтгэхгүй байх ёстой. Энэхүү бодлогыг чанд мөрдөн ажилласнаар банк эрсдэлийн удирдлагын бодлогоо дагаж мөрдөх бөгөөд ажилтнуудад бодит хангамж үзүүлж байгаа хэрэг юм. Ажилтнууд ажил үүргээсээ тодорхой хугацаагаар холдож, амарч, хүчээ сэлбэж байх нь тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдал, ажлын гүйцэтгэлд чухал ач холбогдолтой билээ.

Банкны эрсдэлийн стратеги, баримталж буй арга хандлагын талаар энэхүү тайлангийн Эрсдэлийн удирдлага хэсгээс нэмэлт мэдээлэл авах боломжтой.

ОЛОН ТАЛТ, ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН ОРЧИНГ БИЙ БОЛГОХ

Олон янзын мэдлэг туршлагатай ажилтнуудаас бүрдсэн баг банкны өрсөлдөх чадварыг бэхжүүлж, харилцагчдын өөрийн гэсэн онцлогтой банкны үйлчилгээний эрэлт хэрэгцээнд нийцэн ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг гэдэгт итгэдэг.

Хүйсийн төлөөлөл. Нийт ажилтнуудын 64.3 хувь нь эмэгтэйчүүд, 35.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Дээд түвшний удирдлагад эмэгтэйчүүдийн оролцоо 36 хувьтай байгаа бол дунд түвшний удирдлагад 48 хувьтай байна. Одоогоор банкинд таван гадаадын мэргэжилтэн үндсэн ажилтнаар, есөн зөвлөхийг богино хугацаагаар хөлслөн ажиллуулж байна.

Ахмад ажилтнуудад үргэлжлүүлэн ажиллах боломж олгох. Олон жил ажилласан хамтран зүтгэгчдийн маань хуримтлуулсан туршлагыг үнэлэн хуулиар тогтоосон тэтгэвэрт гарах насанд хүрсэн ч гэсэн цаашид ажиллах сонголтыг нээлттэй болгож өгдөг. 2017 онд тэтгэвэрт гарч буй зургаан ахмад ажилтныг эргэн ажилд авсан бөгөөд тэд нартай байгуулсан нэг жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээг жил бүр шинэчлэн сунгах боломжтой юм. Одоогоор банкинд хөгжлийн бэрхшээлтэй есөн хүн ажиллаж байна.

Ажилтнууд маань бидний амжилтын үндэс. Байгууллагын соёл, үнэт зүйлсээр дамжуулан тэд ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн нэгэн эд эс болсноо мэдэрдэг.

ХасБанкны олон талт байдал:



Грэг Зэгас

Принстон ин Азия (Princeton in Asia) Хөтөлбөрийн оюутан

Сонин юу байна? Миний нэр Грэг. Би ХасБанкны Эко банкны хэлтэст Төсөл хариуцсан мэргэжилтнээр ажилладаг. Би Америкт Бостон хотод төрсөн. Би Бостоны Их Сургуульд Байгаль орчин, эдийн засгийн судалгаа шинжилгээний мэргэжлээр сурсан. Төгсөөд Бостон болон Нью Йоркд хоёр жил сэргээгдэх эрчим хүчний зөвлөхөөр ажилласан. Дараа нь Принстон ин Азия Хөтөлбөрт хамрагдаж Монгол руу ирсэн. Принстон ин Азия жил болгон доор хаяж нэг хүнийг ХасБанк руу ажиллахаар явуулдаг юм.

Эко банкны хэлтэст би олон улсын санхүүжүүлэгч байгууллауудаас Монголд хэрэгжүүлж буй том болон жижиг хэмжээний эрчим хүчний хэмнэлттэй мөн сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, эх үүсвэр татах чиглэлээр ажилладаг. Миний хувьд миний ажил сонирхолтой байдаг, мөн би Монголын хөдөөг их үзэсгэлэнтэй гэж боддог болохоор би Монголд үнэхээр дуртай. Манай ХасБанкны хамт олон маань намайг чин сэтгэлээсээ хүлээн авж хамт ажилладаг болохоор би маш их баяртай байна.

ЦАЛИН ХӨЛС, ХАНГАМЖ

Өнгөрсөн онд бид цалин хөлсний бүтцээ дахин шинэчлэх ажлыг эхлүүлсэн. Юуны түрүүнд ажил үүргийн хуваариудыг хянан шинэчилсний дараагаар Tower's Watson Global үнэлгээний системийг ашиглан ажлын байр тус бүрт үнэлгээ хийж, ажлын байрны шатлан захирах тогтолцоог бүхэлд нь шинэчлэн боловсруулсан. Үнэлгээний энэхүү шинэ системийг ашигласнаар өндөр ур чадвартай хувь хүн тус бүрийн бизнест оруулсан хувь нэмрийг удирдах албан тушаалтан, дунд түвшний удирдах ажилтантай ижил тэгш хэмжээнд үнэлэх боломжтой.

Зах зээлийн цалингийн түвшинтэй уялдуулан цалин хөлсний ангилалд өөрчлөлт оруулсан. 2017 онд үндсэн цалинд ямар нэгэн өөрчлөлт ороогүй боловч 2018 оны 1 дүгээр сараас цалин хөлсний шинэ бүтэц нэвтэрсэнтэй холбоотойгоор шинэчлэгдсэн.

Богино хугацааны шагнал урамшуулал. Хувьсах цалин хөлс нь ололт амжилтыг хувь хүн, баг, байгууллагын түвшинд үнэлж, урамшуулахад чиглэсэн бөгөөд дээрээс доош чиглэсэн гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдээр хэмжигддэг. 2016 оны үр дүнд үндэслэн банк нийт ажилтнуудад жилийн урамшууллыг ажлын гүйцэтгэлийг зорилттой нь харьцуулан тооцож олгосон.

Урт хугацааны шагнал урамшуулал. 2016 оны хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрийн дагуу ажилтнуудын эрх нь үүссэн хувьцаанд суурилсан урамшууллыг 2017 онд мөнгөн хэлбэрээр олгосон.

АЖИЛТНУУДЫН ХӨНГӨЛӨЛТ ХАНГАМЖ, САЙН САЙХАН БАЙДАЛ

ХасБанк нь ажилтны сайн сайхан байдлыг хангахын төлөө тууштай байр суурьтай байгаа бөгөөд ажилтнуудын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн олон төрлийг нийгмийн хангамжийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн. Банкнаас эрүүл мэндийн даатгал, хувийн тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлж, санхүүгийн баталгаа гаргаж өгч байна. Нийт ажилтнууд банкны тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж байгаа бөгөөд урт хугацаат хадгаламжийн хэлбэртэй уг хөтөлбөрийн хүрээнд ажилтны төлсөн шимтгэлтэй ижил хэмжээний мөнгийг ажил олгогчоос төлж, хуримтлуулж байна. Мөн түүнчлэн, орон сууцны зээл, хэрэглээний зээл, зээлийн карт зэрэг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд дээр хөнгөлөлт үзүүлдэг.

Давхардсан тоогоор 4270 гаруй ажилтнууд өнгөрсөн оны туршид зохион байгуулсан ажилтны сайн сайхны төлөөх арга хэмжээнүүдэд оролцсон байна. Сайн дурын үндсэн дээр спортын комисс байгуулсан нь спортын арга хэмжээг идэвхжүүлэхэд тустай байлаа.

Сургалт ба хөгжилАжилтны түүх: Жуковын Баатарболд
Ажилтны түүх: Адилбишийн Булгамаа

Хүний нөөц



СУРГАЛТ ХӨГЖИЛ

Ажилтнуудыг байнгын сургалт хөгжлийн хөтөлбөрөөр хангах нь банкны тэргүүлэх чиглэл юм. 2017 онд банкаас олон төрлийн хөтөлбөр, санаачилга гарган хэрэгжүүлж, ажилтнуудын гол ур чадварыг хөгжүүлэх, цаашид өсөх дэвшихэд шаардлагатай чадавх, мэдлэгийг олгоход анхаарсан.

2017 онд өссөн дүнгээр нийтдээ 49,095 хүн/цагийн сургалтыг зохион байгуулжээ (2016 онд 47,644 хүн/цаг; 2015 онд 42,357 хүн/цаг байсан).

Иргэдийн банкны сургалт

Иргэдийн банкны ажилтнуудын ур чадварыг бэхжүүлэх нь 2017 оны тэргүүлэх чиглэл байв. Өссөн дүнгээр 26,800 хүн цагийн сургалтад 800 гаруй иргэдийн банкны ажилтнуудыг хамруулжээ. Салбарын түвшинд зохион байгуулдаг ажилтнууд бие биенээсээ суралцах сургалтуудыг эрчимжүүлж, тогтмол хуваарийн дагуу явуулдаг болсон бөгөөд нийтдээ 11,000 хүн цагийн сургалт бүртгэгдсэн байна. Иргэдийн банкны нийт ажилтнууд бүтээгдэхүүний мэдлэгийн тест өгч, зааварлагчийн удирдлага дор хоёр сарын хугацаатай цахим сургалтад хамрагдсан.

Зээлийн сургалтын хөтөлбөрийг ажлын байранд тусгайлан зориулсан гурван түвшинд ангилж, шинээр боловсруулсан. 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 3 дугаар сар хүртэлх бизнесийн ачаалал багатай улирлын үеэр нийт зээлийн мэргэжилтэн, хувийн банкируудад зориулан шинээр боловсруулсан зээлийн танхимын сургалтыг зохион байгуулж байна.

Компанийн засаглалын сургалт

ТэнГэр санхүүгийн нэгдлийн дээд болон дунд түвшний 13 удирдах ажилтан Компанийн засаглалын төвөөс сертификат авч, компанийн засаглалын талаарх мэдлэгээ зузаатгалаа.

Нийтдээ 250 ажилтан энэхүү зээлийн сургалтад хамрагдаж төгсөх бөгөөд харилцааны удирдлагын сургалтад давхар хамрагдаж, харилцагчдад үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байхад шаардлагатай мэдлэг, практик ур чадварыг эзэмшинэ. Зээлийн дараагийн түвшний сургалтыг Монголын Банк Санхүүгийн академи хариуцан зохион байгуулах бөгөөд бизнес банкируудад зориулан тусгайлан боловсруулсан юм. Сургалтын хүрээнд банкны туршлагатай ажилтны удирдлага дор ажилтан нэг бүрчлэн дасгалжуулан зааварчлах ажил дээрх сургалт хамт хийгдэнэ.

Зээлийн ахисан түвшний сургалтыг 2018 оны 2 дугаар сард байгууллагын банкны ажилтнуудад зориулан Мүүдийг олон улсын сургалтын байгууллагаас зохион байгуулсан. Улаанбаатар хотод ажиллаж байгаа зээлийн үйл ажиллагаанд холбогдолтой 98 ажилтнуудад шинээр нэвтрүүлсэн зээлийн өргөдлийг бүртгэх модул сургалтыг мөн зохион байгууллаа. Салбар тооцооны төвийн теллер, нягтлан бодогч нарт зориулсан байнгын сургалт явагдсан.

Дотоод аудитын сургалт

Өссөн дүнгээр 250 хүн/цагийн сургалтад 16 аудиторыг хамруулсан. Дөрвөн аудитор Токио дахь ORIX Корпорацид очиж, газар дээрх туршлага хуваалцах хөтөлбөрт хамрагдсан. РwC-гийн Монгол дахь салбараас зохион байгуулсан дотоод аудит, Дотоод Аудиторуудын Хүрээлэнгээс зохион байгуулсан тоон мэдээлэл, шинжилгээний сургалтад зарим аудиторыг хамруулсан.

Ажилтнууд маань бидний амжилтын үндэс. Байгууллагын соёл, үнэт зүйлсээр дамжуулан тэд ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн нэгэн эд эс болсноо мэдэрдэг.

Мэдээллийн технологийн сургалт

Цахим банкны шинэ санаа, мэдээллийн технологийн шийдлийн ач холбогдол нэмэгдэж байгааг харгалзан мэдээллийн технологийн сургалтад байнга анхаарал хандуулж ирсэн. 2017 онд өссөн дүнгээр 3,400 хүн/цагийн сургалтад 50 гаруй мэдээллийн технологийн ажилтнуудыг хамруулжээ. Үүнд:

- Compass Plus-ийн мэргэжилтнүүд картын систем (тэр дундаа ATM хяналтын чиг үүрэг)-ээр газар дээрх сургалт явуулж, мэдээллийн технологийн 19 мэргэжилтний техникийн болон системийн мэдлэгийг зузаатгав;
- “Oracle Web Logic Administration”-ийн хүлээн зөвшөөрөгдсөн сургалтад мэдээллийн технологийн хоёр мэргэжилтэнг хамруулж, “Oracle Certified Associate”-ийн олон улсын гэрчилгээтэй болгосон;
- Төслийн удирдлагын сургалтад 10 ажилтныг хамруулсан (гурван ажилтан Төслийн удирдлагын хүрээлэнгийн Монгол дахь салбараас PMP сертификат авсан);
- Энэтхэгийн Koenig Consulting-аас ITIL 2011 суурь сургалт зохион байгуулж, мэдээллийн технологийн 19 мэргэжилтэн анхан шатны сертификат авлаа;
- ITIL Үйлчилгээний шилжилт, үйл ажиллагааны сургалтад мэдээллийн технологийн таван ахлах мэргэжилтэн хамрагдаж, мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх мэдлэг, чадвартай болсон.

АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

ТэнГэр санхүүгийн нэгдлийн хэмжээнд ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг явуулж, засаж сайжруулах шаардлагатай чиглэлээ тодорхойлдог. 2017 онд сэтгэл ханамжийн судалгааг шинэчлэн, Gallup-ийн ажилтнуудын оролцооны санал асуулгыг сайжруулан нэгтгэсэн. Судалгаанд оролцогчдын 81.6 хувь нь идэвхтэй оролцож (2016 онд 79.6 хувь байсан), сэтгэл ханамжийн индекс 78.4 хувьтай гарлаа (2016 онд 78.0% байсан).

Салбарын удирдлагын сургалт

Өссөн дүнгээр 5,300 хүн/цагийн сургалтад нийт салбар, тооцооны төвийн захирлуудыг хамруулсан байна. Салбар, тооцооны төвийн захирлуудын сургалтыг Солонгос улсын Банкны Хүрээлэнтэй хамтран зохион байгуулж явуулсан бөгөөд уг сургалтын хөтөлбөрийг манай эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тусгайлан боловсруулсан. Зарим захирлуудыг дотоод сургагчаар сургаж, бусад салбарын захирлуудад нь сургалт зохион байгуулахад ашигласан. Хэд хэдэн салбар, тооцооны төвийн захирлуудыг дотоодын их, дээд сургуулийн профессоруудын удирдсан салбарын удирдлагын симуляцийн сургалтад, мөн Бельгийн Банкны Академийн Улаанбаатар хотод зохион байгуулсан хөтөлбөрт хамруулсан. Нийт салбар, тооцооны төвийн захирлуудыг жил бүр зохион байгуулдаг иргэдийн банкны семинарт хамруулсан.

Комплайнс, эрсдэлийн удирдлагын сургалт

Анх 2016 онд нэвтрүүлсэн комплайнсийн цахим сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, 2016 онд 1,000 гаруй ажилтан хамрагдаж байсан бол 2017 онд 142 ажилтан хамруулав. Үүний зэрэгцээ 80 орчим дунд түвшний удирдах ажилтнууд 2017 онд шинээр нэвтрүүлсэн комплайнсийн ахисан түвшний цахим сургалтад хамрагдсан байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог танилцуулах сургалтад нийт дунд болон дээд түвшний удирдах ажилтнуудыг хамруулан эрсдэлийн соёлыг бэхжүүлж, хамгаалалтын гурван шугамын хүрээнд гүйцэтгэх тодорхой үүргийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилго агуулсан.

АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО

Ажилтнуудын оролцоо бол ХасБанкны хувьд тэргүүлэх гол чиглэлийн нэг мөн. Нийтийн сонсгол, дотоод сүлжээ, цахим уулзалт, дээд шатны удирдах ажилтнуудын Улаанбаатар болон орон нутгийн салбар, тооцооны төвүүдэд жил бүр хийдэг тойрон аялал, айлчлал, ажилтнуудын цугларалт, компанийн хурал зөвлөгөөн зэрэг харилцаа холбооны сувгуудыг ашиглан бид стратегийн тэргүүлэх чиглэл, зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэл, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, шинэ бодлого, чиглэл зэрэг ач холбогдолтой асуудлаар мэдээлэл өгч нэгдлийн хэмжээнд харилцаж байна.

Бид дунд шатны менежерүүдээ өсөж дэвжихэд нь дэмждэг



Жуковын Баатарболд

Салбарын удирдлагын хэлтсийн захирал

Намайг Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн төгсөх ангийн оюутан байх үед ХасБанкны удирдлагууд манай сургууль дээр ирж банкныхаа талаар танилцуулга хийж, оюутнуудын дунд тэтгэлэгт хөтөлбөр зарласан. Надад зориулагдсан ямар нэгэн зүйл энд байна гэсэн зөн совин төрсөн учраас би шууд л материалаа бүрдүүлж өгөөд, хариуг нь тэсэн ядан хүлээж байлаа. Тэр жил сургалтын төлбөрийн тэтгэлэг авч чадсан азтай 3 оюутны нэг болсон миний бие сургуулиа төгсөнгүүтээ 2004 оны 2 дугаар сард ХасБанкинд ажилд орсон.

Би ажлын гараагаа ХасБанкны Баянгол салбарт жижиг дунд бизнесийн зээлийн мэргэжилтнээр эхлүүлж хоёр жил ажиллах хугацаандаа ирээдүйн карьерийн хөгжлийг маань тодорхойлох банкны секторын суурь ойлголт, практик мэдлэг, санхүүгийн шинжилгээ хийх ур чадвар эзэмшиж, банкир хүний ёс суртахуун, зөв хандлагад суралцаж, төлөвшсөн.

Дараа нь Төв албанд шилжиж баруун бүсийн менежерээр жил орчим ажиллахдаа банкны салбар, тооцооны төвүүдийг амжилттай удирдахын тулд эхлээд өөрөө салбарын захирлаар ажиллаж, туршлага хуримтлуулах хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон. Тиймээс Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь салбарын захирлаар ажиллах саналыг хүлээн авч, илгээлтээр явсан. Адал явдал, сорилтоор дүүрэн тэрхүү ажлын орчин надад баг хамт олныг удирдан манлайлах, бусадтай үр дүнтэй харилцаа холбоо тогтоох, харилцагчтай бат бөх харилцаа бий болгож, борлуулалт хийх, хүнд бэрхийг даван туулах гэх мэт олон чиглэлийн дадал зуршил, чадвар чадамж эзэмшиж, хөгжих боломж олгосон.

Орон нутгийн ажил маань амжилттай өндөрлөж Төв албанд эргэж ирээд 2008 оны 10 сараас

эхлэн Баруун болон Улаанбаатар хотын салбар, тооцооны төвүүд хариуцсан бүсийн захирлаар ажиллаад 2013 оны 3 сард одоогийн албан тушаалд буюу Салбарын удирдлагын хэлтсийн захирлаар томилогдсон. Энэ хугацаанд 3 жил дарааллан тууштай оролдлого хийсний үр дүнд 2014 онд Люксембургийн засгийн газраас банкны ажилтнуудын дунд жил бүр зарладаг тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэн, улмаар Люксембургийн их



сургуульд суралцаж 2016 оны 4 дүгээр сард Банк санхүүч мэргэжлээр магистрийн дипломоо гардан авсан.

Миний бие ХасБанкинд орох тэрхүү боломжийг ашиглаж чадсандаа, банкныхаа хөгжил дэвшилтэй хамт өсөж хөгжиж яваадаа үргэлж талархаж явдаг. ХасБанк нь Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашгийг эрхэмлэсэн эрхэм зорилгод суурилсан үе үеийн Хасчуудын хамтдаа бүтээсэн өвөрмөц байгууллагын соёлтой банк гэж би итгэдэг. Хамгийн чухал нь жилээс жилд нэмэгдсээр буй олон мянган харилцагчдын маань бидэнд өгч итгэл. Амьдралд Ашид хамтдаа.

Ажилтнууд маань бидний амжилтын үндэс. Байгууллагын соёл, үнэт зүйлсээр дамжуулан тэд ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн нэгэн эд эс болсноо мэдэрдэг.

Чадварлаг шинэ ажилтануудыг дэмждэг



Адилбишийн Булгамаа

Санхүүгийн шинжээч

“Эхлээд банкныхаа үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн энгийн нэгэн хэрэглэгч, хүлээн авагч нь байсан бол одоо өөрөө энэ сайхан үйл хэргүүдийг бүтээгчдийн нэгэн төлөөлөл нь болоод байна. ”

Сайн байцгаана уу? Намайг Адилбишийн Булгамаа гэдэг. Би Хас банкнаас ажлын гараагаа эхэлж буй шинэхэн боловсон хүчин. Эх орны минь төв хэсэг болох Архангай аймагт төрж өсөн, бүрэн дунд боловсролоо эзэмшсэн. Арван жилийн сурагч байхдаа “Монгол Улсын Их Сургуульд элсэн орох” гэсэн мөрөөдлөөр ирээдүйгээ хязгаарладаг байсан бол их сургуулийн оюутан болоод илүү олон олон боломжууд нээлттэй байгааг олж харсан юм. Анх төгсөх ангийн оюутан байхдаа Хас банкнаас зарлагдаж буй Питер Морроугийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрт материлаа илгээж, хамгийн анхны ялагчдын нэг болж, улмаар Хас банкны өөрийн сонирхсон аль нэг газар нэгжид үйлдвэрлэлийн дадлага хийх боломжийг олж авсан нь өөрийн гэр бүлийг эс тооцвол хэн нэгнээс авсан хамгийн томоохон тус, маш хүчтэй дэмжлэг байсан юм. Өөрийн мэргэжлийн дагуу буюу санхүү удирдлагын хэлтэст 2 сарын хугацаанд далагын ажлаа амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ хугацаанд Хас банкны байгууллагын соёл, хамт олны уур амьсгал, энэхүү банк өөрөө, миний ажлын гараанд хамгийн зохимжтой төдийгүй маш их боломжуудыг нээж өгөх юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Их сургуулиа амжилттай төгссөний дараагаар би Хас банкиндаа “санхүүгийн шинжээч” гэсэн албан тушаалд ажиллаж эхэлсэн нь ямар нэгэн мэргэжлийн туршлагагүй, шинэхэн төгсөгчийн хувьд томоохон хариуцлага хэмээн боддог юм.

Харин одоо, би Хас банк гэх энэ том айл гэрийн нэгэн гишүүн болсныхоо хувьд бидний гэр бүл харилцагчдынхаа болон олон олон залуусын амьдралд тус нэмэр авчрахуйц сайн хамтрагч нь

байж чаддаг гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр хэлмээр байна. Зорилтот хөтөлбөрийнхөө үр шимийг хүртээж, цоо шинэ боломжуудыг олгосон Хас банкны итгэл, дэмжлэгт маш их талархаж явдгийн хамт улс эх орныхоо хөгжил цэцэглэлтэд дэмжлэг үзүүлдэг, түүний төлөө хөдөлмөрлөдөг нэгэн болох хүслийн минь суурь болж өгсөнд маш их баярлаж байгаагаа илэрхийлье. Хас банкны хувьд харилцагчдынхаа аж амьдрал, бизнес хөгжил зэрэгт дэмжлэг үзүүлэхүйц олон төрлийн бүтээгдэхүүнийг санал болгож тэр дундаа үеэс үед дамжих эх дэлхий, уур амьсгалын



асуудлыг хөндөн, бодитойгоор дэмждэг олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

Эхлээд банкныхаа үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн энгийн нэгэн хэрэглэгч, хүлээн авагч нь байсан бол одоо өөрөө энэ сайхан үйл хэргүүдийг бүтээгчдийн нэгэн төлөөлөл нь болсон байна. Амьдралын минь томоохон эхлэлд хамгийн сайн хамтрагч болсон Хас банкдаа маш их баярлалаа.

Мөн хэн нэгний амьдралд гэрэл түгээж, мэргэжил карьерийн замд нь чиглүүлэгч болсон тэтгэлэгт хөтөлбөрүүд, өөр бусад олон олон төсөл хөтөлбөрүүдээ цаашид ч тасралтгүй үргэлжлүүлээсэй гэж хүсэж байна.

Компанийн **нийгмийн** **хариуцлага**



Компанийн нийгмийн хариуцлага

КАТМАНДУ-ГИЙН ТУНХАГЛАЛ

Компанийн нийгмийн хариуцлага бол манай стратеги, үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ бол Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашиг гэсэн бидний гурвалсан эрхэм зорилгод хүргэх дэлхий дахины стандартуудыг нэвтрүүлэх манай соёл, үнэт зүйлсийн нэг хэсэг мөн. Бидний зориг эрмэлзэл хууль эрх зүй, зохицуулалтын шаардлагаас ч илүү байна. Сайн засаглалтай аж ахуйн нэгж байна гэдэг бидний урт хугацааны тогтвортой өсөлтийн түлхүүр мөн. Бид стратегийн зорилго, хүсэл тэмүүлэлдээ бидний дунд болон урт хугацааны зорилтуудад урамшиж хөрөнгө оруулсан нэгдмэл сонирхолтой оролцогч талуудтайгаа хамтран хүрч чадна гэдэгт бид итгэдэг.

Бид компанийн нийгмийн хариуцлага, өглөг хандивын төслүүд, төрөл бүрийн боловсролын хөтөлбөрүүд, спорт, урлаг, соёлын дэмжлэг хандивын арга хэмжээгээр дамжуулан нийгэмд болон харилцагчдынхаа орчинд эерэг хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж байна. Бид нийгэм дэх сайн сайхны үйл хэргийг дэмжсэн ажлын тэргүүн эгнээнд явахыг хичээж байна.

Бид “Үнэ цэнэт банкны үйлчилгээ үзүүлэх дэлхийн эвсэл” (GABV)-ээс гаргасан Катманду-гийн Тунхаглалыг дэмжин, 2017 онд нэгдэн орсноор компанийн нийгмийн хариуцлагын үйл хэрэгтээ шинэ амьсгаа орууллаа. Тунхаглалд заасан амлалтууд нь бидний хувьд шинэ зүйл биш бөгөөд манай ажлын соёлд аль хэдийнэ шингэсэн, манай эрхэм зорилго, суурь үнэт зүйлсэд бүрэн нийцэж байдаг юм. Катманду-гийн Тунхаглал нь бидний юу, яагаад, хэрхэн хийдгийг тодорхойлсон үнэ цэнэ бүхий банкны үйлчилгээний 5 зарчмыг баримтлан ажиллах хүсэл зоригийг маань дахин нотолж байна.

ХАРИЛЦАГЧИДДАА ХАНДАХ ЁС ЗҮЙН ӨНДӨР СТАНДАРТ

Манай иргэд болон байгууллагын харилцагчид бидний стратеги, үйл ажиллагааны төвд оршиж байдаг.

2015 онд Планет Рейтинг агентлаг дэлхий дахинаа дэмжигдсэн Харилцагчдыг хамгаалах зарчмуудын стандартыг ажилдаа нэвтрүүлж, онцгой амжилт гаргасан гэж манай Банкинд Ухаалаг хөдөлгөөний батламж бичиг олгосон билээ. 2017 онд манай ТУЗ дээрх Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг баримталж ажиллахаа албан ёсоор дахин нотолсон болно. ХасБанк 7 зарчим, 99 үзүүлэлт бүхий Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг нийт үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн дэлхийн 39 байгууллагын нэг нь юм.



²Үнэ цэнэт банкны үйлчилгээ үзүүлэх дэлхийн эвсэл” (GABV) нь 2009 онд байгуулагдсан, банкуудын бие даасан сүлжээ бөгөөд ХасБанк үүсгэн байгуулагч гишүүдийн нэг юм.



КАТМАНДУ-ГИЙН ТУНХАГЛАЛ

Удиртгал

Хүндэтгэл, итгэл дээр тулгуурласан хүмүүс хоорондын эерэг харилцааг бий болгоход байгаль орчин, нийгмийн сорилтуудыг шийдвэрлэх явдал тулгамдсан асуудал болоод байна.

Эдгээр сорилтыг шийдвэрлэх эдийн засгийн өөрчлөн байгуулалт, түүний дотор технологийн инновацийг дэлхий дахинаа хувь хүмүүс, үйлдвэр аж ахуйн газрууд санхүүгийн тусламжтайгаар удирдан зохион байгуулах юм.

Бодит эдийн засгийн хэрэгцээнд үйлчилсэн санхүүгийн тогтвортой систем байгуулснаар санхүү хөрөнгө ард түмний аж амьдралд нөлөө үзүүлж чадах юм.

Улс орны нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хэрэгцээг хангахдаа үнэ цэнэ бий болгох явдал өөрөө өөрийгээ гэхээсээ илүү бусдыг өөрчлөн шинэчлэх хүчин зүйл болсон мөнгөтэй банк санхүүгийн байгууллагын ажиллагааны төвд байх ёстой.

Бидний Амлалт:

- a) Бидний үйлчилж байгаа нутаг дэвсгэр, нийт нийгмийн урт хугацааны, интеграцчлагдсан нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжиж ажиллах
- b) Үнэ цэнэд суурилсан банкны зарчмуудад тулгуурласан үйлчилгээг хувь хүмүүс, үйлдвэр аж ахуйн газруудад үзүүлэх
- c) Идэвхтэй, янз бүрийн хувь хүмүүс, үйлдвэр аж ахуйн газруудад үйлчилж, нийгэм, байгаль орчин, соёлын хувьд өөрсдийн оролцогч талуудын хөгжил, аз жаргал, сайн сайхны төлөө гэсэн ухамсартай байх
- d) Улс орон, бүс нутаг, дэлхий дахинд манлайлагч байж, үйл ажлаараа банкны системийг шинэчлэгч алсын хараатай үлгэр загвар байгууллага байх
- e) Бодит эдийн засгийг манай гариг дэмжиж чадах хэмжээнд зохицуулан, шинэлэг аргаар, байнга шинэчлэх ажлыг дэмжиж, үүний сацуу ард иргэдийг болон хүн хоорондын харилцааг анхаарлынхаа төвд байлгах.

Компанийн нийгмийн хариуцлага

ХҮҮХЭД, ЗАЛУУСЫН САНХҮҮГИЙН ИРЭЭДҮЙД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙНА

Өнөөгийн ярвигтай, инновацлаг дэлхий ертөнцөд аль болох нас залуу дээрээ санхүүгийн суурь чадвартай болох нь уншиж бичиж сурахтай адил ач холбогдолтой болоод байгаа бид үзэж байна. Санхүүгийн илүү өндөр түвшний бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлтэй нүүр учрах болж, насанд хүрсэн хойноо санхүүгийн илүү өндөр эрсдэл үүрэх хүүхэд, залуучуудын хувьд санхүүгийн суурь мэдлэг олж авах нь амьдралын амин чухал чадвар болох юм.



Бид банкны салбартаа анхдагч болж, 2009 оноос хүүхдүүдэд зориулсан нийгэм, санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Хүүхдийн санхүүгийн боловсролын чиглэлээрх манай 8 жилийн баялаг туршлага дээр үндэслэн, Монголын ахлах сургуулийн хичээлийн хөтөлбөрт санхүүгийн боловсролын сургалт орох болсон бөгөөд энэ нь санхүүгийн суурь мэдлэг олж авах боломжийг хүүхэд бүрт олгосон хэрэг болсон билээ.

“Тэмүүлэл” гэж хадгаламжийн хөтөлбөр юм. Анх Эмэгтэйчүүдийн дэлхийн банк хэмээх ТББ-ын техник тусламжаар охидын санхүүгийн боловсролын хөтөлбөр хэлбэрээр эхэлсэн “Тэмүүлэл” хөтөлбөр нь улам өргөжин тэлж, нийт Монголын өсвөр насны бүх хүүхэд, түүний дотор дунд сургуулийн сурагчид, дотуур байр, хорих ангид байгаа хүүхдүүдийг хамрах болсон. 2009 онд ажиллаж эхэлснээсээ хойш тус хөтөлбөрт 26'500 өсвөр насны хүүхэд хамрагджээ. Одоо хөтөлбөрт нийгмийн чиглэл нэмэгдэж, орон даяар энтрепренер үйл ажиллагаа, байгаль орчныг

хамгаалах сайн дурын арга хэмжээнд оролцох замаар амьдралын туршлага чадвараа нэмэгдүүлэх урам зоригийг залуу хүмүүст өгч байна. 2016 онд манай харьяа ТББ болох ХАС Хөгжлийн алтан сан Монголын залуучуудын санхүүгийн боловсролын үндэсний сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан, ахлах сургуулийн 10 дугаар ангийн сурагчдын хичээлийн хөтөлбөрт санхүүгийн боловсролын сургалт оруулсан байна. 2017 онд “Тэмүүлэл” хөтөлбөрийн санхүүгийн боловсролын

агуулгыг сурагчдын сурах бичиг, багшийн гарын авлагад тусгасан байна.

Тэмүүлэл дебит картыг 2016 онд нэвтрүүлсэн бөгөөд одоо 14-18 насны 3'500 хүүхэд эзэмшиж байна. Уг карт санхүүгийн танхимын боловсролоо бодит амьдрал дээр туршиж үзэх боломж хүүхдүүдэд олгож байна.

“Афлатон” гэж бас нэг амжилттай явж байгаа хөтөлбөр бий. Энэ хөтөлбөрөөр Монголын 8-13 насны хүүхдүүдэд нийгмийн болоод санхүүгийн боловсрол олгодог юм. 2017 оны байдлаар тус хөтөлбөрт 2'700 хүүхэд хамрагджээ.

Эдгээр хөтөлбөрт нийтдээ 65'500 хүүхэд, багш нар, сайн дурынхан орон даяар хамрагдсан бөгөөд ХасБанкны бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетингийн хүрээг нэмэгдүүлэх санхүүгийн боловсролыг зузаатгаж байна.

2017 онд хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл дотуур байранд амьдардаг 120 хүүхэд санхүүгийн боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэжээ.

Хөгжлийн Алтан Сангаараа дамжуулан нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна.

МАНАЙ АФЛАТОН ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОГЧ БАГШ НАР, СУРАГЧДЫН СЭТГЭГДЭЛ



Жанчивын Оюунцэцэг
Улаанбаатар хотын 120-р сургуулийн Бага ангийн багш

Би 2012 онд Афлатон Хөтөлбөрийн сургагч багш болж, бага ангийн хүүхдүүдэд Афлатон хичээл зааж эхэлсэн. Эдгээр хүүхдүүд маань одоо ахлах сургуулийн сурагчид болсон. Тэдний хувь хүний хүмүүжил, үйл хөдлөлд санхүүгийн боловсролын хөтөлбөр эерэг өөрчлөлт оруулсанд би баяртай



Алтан-Айн Энхриймаа
10 настай, Афлатон хөтөлбөрийн 4-р ангийн сурагч

Би өнгөрсөн 10 дугаар сараас хадгаламжтай болсон. Хуримтлуулсан мөнгөө нууц саванд хадгалж, овоо их болохоор нь ээждээ өгч хадгаламжийн дансандаа хийлгүүлдэг. Би том болтлоо мөнгөө хэмнэн хуримтлуулж, ээждээ цэвэр агаарт том байшин барьж өгнө.

байна. Тэд маш сайн суралцаад зогсохгүй, мөнгөтэй зохистой зөв харьцаж, бүхий л үйл ажиллагаагаа төлөвлөж, төсөвлөж суран, бие биенийгээ сайн дэмжиж явдаг болсон байна. Жишээлбэл, Афлатон хөтөлбөрт хамрагдсан бага сургуулийн 4,5 дугаар ангийн сурагчид сургуулийн мухлагаас чихэрлэг зүйл худалдан авдаггүй болсон. Харин бусад ангийн хүүхдүүд нь их хэмжээний чихэр боов худалдан авч байсныг бид ажигласан.

Тэр үед багш бид нар ч санхүүгийн хангалттай мэдлэггүй байсан. Тиймээс бид сургачдад хичээл заах явцдаа өөрсдөө санхүүгийн боловсролтой болсон. Энэ туршлага бидний бодит амьдрал дахь санхүүгийн хандлага, зуршилд маш эерэг нөлөө үзүүлж чадсан.

Санхүүгийн боловсролын хөтөлбөрийн хичээл заахад оролцсон манай сургуулийн багш нар аливаа зүйлийг худалдан авахын өмнө энэ зүйл бидний бодит хэрэгцээ мөн үү гэж өөрөөсөө асуудал боллоо. Дээр нь бид мөнгө хурааж суран, хүн бүр хадгаламжтай болсон.



Ариунбаярын Элбэгсайхан
10 настай, Афлатон хөтөлбөрийн 4-р ангийн сурагч

Афлатон хөтөлбөрийн дараа би мөнгөө хуримтлуулж эхэлсэн. Аав ээжтэйгээ хамт хадгаламжийн данс нээлгэсэн. Би хангалттай мөнгө хуримтлуулаад машин авна. Афлатоны мөнгө хуримтлуулсан түүхүүд тун сонин. Би саяхан ээждээ зориулсан мөнгө хуримтлуулах хайрцагтай болсон. Тэнд хураасан мөнгөөрөө Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөр ээждээ бэлэг авч өгнө.

Компанийн нийгмийн хариуцлага

2017 оны онцлох үйл явдлууд

- “Тэмүүлэл” хадгаламжийн данс, “Тэмүүлэл” дебит картыг хүүхэд, залуучуудад ээлтэй банкны бүтээгдэхүүн гэж Хүүхэд, залуучуудын санхүү олон улсын байгууллагаас үнэлсэн.
- Глобал мөнгөний долоо хоног, Дэлхийн хадгаламжийн өдөр арга хэмжээний үеэр ахлах сургуулийн 1’520 сурагчдад санхүүгийн тухай лекц уншиж, залуу хүмүүсийг санхүүгийн боловсрол, санхүүгийн хүртээмжийн тухай мэдлэгтэй болгох бусад ажил зохиолоо.
- 2017 оны хичээлийн жилд санхүүгийн боловсролын 30 цагийн хөтөлбөрт дунд сургуулийн бага ангийн 2’700 сурагчдыг хамруулав.
- Өсвөр насны 1ө200 хүүхдийг 3 цагийн санхүүгийн боловсролын хөтөлбөрт хамруулж, Улаанбаатар (9) болон Багануурын дунд, ахлах сургуулийн 320 сурагчдыг банк, санхүүгийн байгууллагуудаар танилцах аялалд оролцуулав.
- Санхүүгийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа 5 дунд сургууль дээр зохион байгуулж, 2’500 сурагч, 1’000 орчим эцэг эх хамрагдав.
- Афлатон хөтөлбөрийн хоёр өдрийн “Сургагч нарын сургалт” арга хэмжээг 9 дунд сургуулийн бага ангийн 132 багшийг оролцуулан зохион байгуулав.
- 21 аймгийн лаборатор сургуулиудын ахалх ангийн 35 багшид сургагч нарын ахисан түвшний сургалт зохион байгуулав.



Хөгжлийн Алтан Сангаараа дамжуулан нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна.

ӨРГӨН ОЛОН НИЙТЭД САНХҮҮГИЙН АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХОД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙНА

Бид манай харилцагчид, өргөн олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг сайжруулах ажлыг өөрийн компаний нийгмийн хариуцлага гэж үргэлж үзэж ирсэн. Харилцагчдынхаа насан туршийн санхүүгийн түнш байж, санхүүгийн мэдлэг, ур чадварыг түгээгч тууштай сургагч болох эрхэм зорилгоо бид ухамсарлан ажиллаж байдаг. Бид санхүүгийн аанхан шатны боловсролыг сайжруулах нь ард иргэдийн санхүүгийн сайн сайхан, банкны

бүтээгдэхүүн, үйлчилгээний бий болгож байгаа боломжийг ашиглах чадварт гүнзгий нөлөө үзүүлж, тэднийг санхүүгийн системд илүү өргөн оролцуулахад хүргэдэг гэдэгт итгэдэг.

ХасБанк, манай ажиллагсдын байгуулсан Хөгжлийн алтан сан ТББ-ын шугамаар санхүүгийн анхан шатны боловсрол олгох хөтөлбөрөө орон даяар тогтмол явуулж байна.

2017 оны онцлох үйл явдлууд

- Хагас жилийн туршид, Монголын үндэсний радиотой хамтран, шууд асуулт, хариулт бүхий “Мөнгөний мод” радио нэвтрүүлгийг орон даяар долоо хоног дутам цацлаа.
- Худалдаа, үйлдвэрийн их сургууль, 120 дугаар дунд сургуулийн 100 багш, ажиллагсдад “Хадгаламж” гэсэн ерөнхий сэдвээр 2 цагийн санхүүгийн суурь мэдлэгийн сургалт зохион байгууллаа.
- Санхүүгийн боловсролын талаар 4 цагийн сургалтыг ХасБанкны 44 ажиллагсдад хоёр удаа зохион байгуулсан.
- ХасБанкны Улаанбаатар дахь борлуулалтын 23 ажилтанд нэг өдрийн давтан сургалт зохион байгуулж, санхүүгийн мэдээллийг харилцагчдад хүргэх ур чадварыг нь ахиулав.

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

2017 онд ХАС Хөгжлийн алтан сангаас 1000 орчим хүүхэд хөгжлийн шууд дэмжлэг авсан байна.

- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн сурагчдад зориулсан урт болон богино хугацааны 7 төсөл, арга хэмжээ зохион байгууллаа.
- Аймаг, хотын дунд сургуулиудтай хамтран орон даяар зохион байгуулсан хүүхдийн авьяасыг хөгжүүлэх 23 арга хэмжээнд 1100 хүүхэд хамрууллаа.
- Манай ТУЗ-ийн гишүүд сонсголын бэрхшээлтэй 29 дүгээр тусгай дунд сургуульд зочлов. ХасБанк дотуур байрыг тавилгажуулах, гадаа тоглоомын талбай тохижуулах, хүүхдүүдийг бичгийн хэрэгслээр хангах зэргээр сургуулиудыг дэмжиж ирлээ.

Компанийн нийгмийн хариуцлага

СОЁЛЫН ӨВ, УРЛАГИЙГ ДЭМЖИЖ БАЙНА

Соёл, урлагийг ивээн тэтгэсэн манай ажиллагаа урт хугацааны уламжлал болсон. Бид Монголын урлаг, соёлынхныг ивээн тэтгэж, бүтээлийнх нь үзэсгэлэн гаргах, сурч боловсроход нь тусалж ирлээ. Мөн Монголын үзэгчдэд бусад орны соёл, урлагийг танилцуулах ажлыг ивээн тэтгэж байна.

- 2017 онд La Biennale di Venezia байгууллагаас зохион байгуулсан Орчин үеийн урлагийн олон улсын 57 дахь үзэсгэлэнд оролцох Монголын төлөөлөгчдийг ивээн тэтгэж, бүтээлийг нь худалдан авах замаар (3 бүтээлийг Банкны төв байранд байрлуулсан) залуу уран бүтээлчдийг дэмжиж ажиллаа. 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр бидний ивээн тэтгэсэн урлагийн зарим нэг бүтээлийг ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчдийн анхааралд толилуулсан.



Шагдаржавын Чимэддорж
Би шувуу

- Бид олон улсын уран бүтээлчдийн мэдээллийн технологи дээр суурилсан урлагийн бүтээлийг Монголын үзэгчдэд танилцуулах зорилгоор Монголын Урлагийн Зөвлөлөөс “Ул мөр” сэдвийн дор зохион байгуулдаг Олон улсын медиа урлагийн “Улаанбаатар” фестивалийг хоёр дахь жилдээ ивээн тэтгэлээ.
- Бид Монголын хөгжмийн онлайн платформын анхны аппликэйшнийг бүтээгч Хуур Мюзик Групптэй хамтран ажилладаг ажлын хүрээнд Хуур мюзик стриминг үйлчилгээний нээлт болон сүүлийн үеийн R&B, Hip Hop, цахилгаан хөгжмийн үзүүлбэр орсон хөгжмийн урлагийн томоохон арга хэмжээ болох Хуур Мюзик Фестивальд “Тэмүүлэл” карт эзэмшигчдийг урин оролцуулаа..
- Бид Хүүхдийн өдрийг тохиолдуулан, урлаг, гар урлалын “Хүүхэд бүр уран бүтээлч” уралдааныг

хоёр дахь жилдээ зохион байгуулж, уралдаанд ирүүлсэн хүүхдүүдийн зураг, ирлагийн бүтээлээр “Миний аз жаргалын морь” сэдэвт үзэсгэлэнг Монголын Урлагийн Зөвлөл, Занабазар дүрслэх урлагийн музейтэй хамтран гаргалаа. Уралдаанд оролцсон хүүхэд бүрт ТУЗ-ийн гишүүдийн дэмжлэгтэйгээр “Ирээдүйн саятан” хадгаламжийн данс нээж өгөн, бэлэг барилаа.

- Канадын тусгаар тогтнолын 150 жилийн ойг тохиолдуулан, Канадын уугуул иргэдийн “Cris Derksen Trio” хамтлагийн тоглолтыг ивээн тэтгэж, Улаанбаатарт зохион байгууллаа.
- ХАС Хөгжлийн алтан сангийн шугамаар залуучуудын бүжгийн “King of Rap” тэмцээнийг 9 дэх жилдээ ивээн тэтгэж зохион байгуулав. 6 сум болон Улаанбаатараас 29 багийн 260 хүүхэд өнгөрсөн жилд Говьсүмбэр аймагт зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байна.
- Бид эх орондоо хайртай бөгөөд Монголын түүхэн болон соёлын өвийг сурталчлах янз бүрийн санаачилгыг ивээн тэтгэж байна.



- 2017 онд Монголын богино өгүүллэгийн мастер Жагдалын Лхагвын бүтээлийн цуглуулгаар хийсэн “Толгодын цаана ингэ буйлна” хэмээх номыг ивээн тэтгэж хэвлүүллээ.
- Бид Дэлхий дахины монголчууд ТББ-тай хамтран, Монголын Эзэнт гүрний 810 жил, Ил Хаант Улсын 760 жилийн ойд зориулсан “Ил хаадын урлаг, соёл” гэсэн номыг перс болон англи хэлээр хэвлүүлж, суртачиллаа.

СПОРТЫГ ДЭМЖИЖ БАЙНА

Бидний спортын арга хэмжээ, санаачилгыг ивээн тэтгэж байгаа нь брэнд сурталчлах, маркетингийн ажил төдий биш юм. Энэ бол олон нийт, залуу үеийн сайн сайхны төлөө гэсэн бидний хүсэл эрмэлзэл юм. Хүүхдүүд, залуучуудыг спортод хамруулах, идэвхтэй амьдралын эрүүл зуршилтай болгох боломж гаргаж өгөх нь бидний зорилго болно.

- Улаанбаатарын ярианы болон сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн 29 дүгээр тусгай сургуулийн сурагчдыг баскетболын үндэсний дээд лигийн нэг баг бөгөөд ХасБанкны ивээн тэтгэдэг “Хасын хүлгүүд” багтай нэг өдөр хамт өнгөрүүлэх ажлыг 13 дахь жилдээ зохион байгууллаа.
- Дотоод болон гадаадын олон тэмцээнд амжилттай оролцож ирсэн “ХАС дугуйн клуб”-ын үйл ажиллагааг хоёр дахь жилдээ ивээн тэтгэж ажиллаа. “Tour de Mongolie” хэмээх дугуйн тэмцээнийг Монголын дугуйн холбоотой хамтран ХасБанкнаас зохион байгуулав.
- ХасБанк болон Хөгжлийн алтан сан ТББ тус Банкнаас анхлан 2006 онд санаачилсан жил дутмын футзал тэмцээн болох “Бум 2020” арга хэмжээг үргэлжлүүлэн ивээн тэтгэлээ. 2017 онд Улаанбаатар хотын захын хорооллын 6 сургуулийн хүүхдүүдийн багийн оролцоог ивээн тэтгэсэн.
- Бид ХАС Хөгжлийн алтан сангийн шугамаар “Х.А.С. Ассоциаци” хэмээх волейболын залуучуудын тэмцээнийг гурав дахь жилдээ ивээн тэтгэж байна. 2017 онд 39 багийн 320 залуучууд энэ арга хэмжээнд оролцлоо.

БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИЖ БАЙНА

Боловсрол бол тогтвортой амьжиргаа, ирээдүйн орлогын тулгын чулуу учир залуу үеийн потенциалыг илрүүлэх, оюун ухааныг нь хөгжүүлэх, эмзэг бүлгийн оюутан сурагчдад бололцоо олгох боловсролын санаачилгуудыг дэмжиж, ивээн тэтгэж байна.

- 2017 онд банк, санхүү, эдийн засгийн чиглэлээр суралцдаг потенхиал сайтай оюутнуудад амьдралд хөлөө олоход нь туслах зорилгоор 2016 оноос хэрэгжиж эхэлсэн ХасБанкны Питер Морроугийн нэрэмжит тэтгэлгийг дахин 3 оюутанд олгож, сургалтын нэг жилийн төлбөрийг нь хариуцан, ХасБанк дээр дадлага хийх боломжоор хангасан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙНА

Бид эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагаа, санхүүжилтийг идэвхтэй дэмжин ажиллаж байна.

- Бид АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн REACH төсөл, төслийг хэрэгжүүлэгч Хөгжлийн шийдэл ТББ-тай эрүүл мэндийн салбарт хамтран ажиллаж байна. 2017 онд АНУ-ын ОУХА-ийн REACH төсөл болон бусад байгууллагатай хамтран, эрүүл мэндийн салбар дахь санхүүжилт, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор “BUSINESS TO BUSINESS” арга хэмжээ зохион байгууллаа.
- ХасБанк болон Эрүүл мэндийн яам Гепатит С вирусыг илрүүлэх, эмчлэх талаар хамтран ажиллахаар тохиролцлоо. Бид үнэ өртөг ихтэй эмчилгээг бага хүүтэй зээлээр санхүүжүүлэх ажлыг эхлүүлсэн.
- ХасБанк Гэмтэл согог судлалын Үндэсний төвийн ортопед тасгийг бүрэн шинэчлэн засварлах ажлыг санхүүжүүллээ. Cargill компанитай хамтран, Ерөнхий мэс заслын өрөөг дэлхийн түвшний технологи, тоног төхөөрөмжөөр шинэчлэх ажлыг мөн санхүүжүүлэв.

ХАС-ЫН ТӨГӨЛ ТӨСЛӨӨ АНХААРЧ БАЙНА

Бид ХАС Төгөл төслийн хүрээн дэх санаачилгаа үргэлжлүүлэн ажиллаж байна. 2005 оноос хойш 37'600 мод бүхий 29 төгөл байгуулжээ. Бидний тарьсан модны 75% нь ургаж байна.

2017 онд бид “Төгөлдөө анхаарал тавья” уриан дор мод арчлах арга хэмжээнд төвлөрч ажиллаа. Өмнөд нутгийн таван аймгийн захиргаатай хамтран ажиллаж, хашаа хороо сэргээх, хөрс сайжруулах ажил зохиолоо. Хоёр байршилд усжуулалтын систем байгууллаа. 600 ширхэг мод суулгав.

- Бид Банк, санхүүгийн академитай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, тэндээс зохион байгуулдаг сургалтын хөтөлбөр болох “Шинэ үеийн банкир” арга хэмжээний стратегийн түнш болсон.
- Бид Монголд гурав дахь удаагаа зохион байгуулагдсан, олон улсын боловсролын симуляци арга хэмжээ болох “Загвар НҮБ” хэмээх тэмцээнийг дэмжиж ажиллаа.

Компанийн нийгмийн хариуцлага

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

ХасБанк байгуулагдсан цагаасаа эхлэн, нийгэм, байгаль орчин, мөн санхүүгийн үйлчилгээний гарц, чанар зэрэг асуудлаар төрөл бүрийн оролцогч талуудыг сонсож, тэднийг хамтын ажиллагаа, зөвлөлдөх уулзалтад татан оролцуулж ирсэн бөгөөд энэ нь Ард иргэд, Дэлхий ертөнц, Хөгжил дэвшил гэсэн бидний гурвалсан эрхэм зорилгоо биелүүлэх, хамгийн чухал нь ажил үйлчилгээгээ сайжруулах зорилготой юм. Бид мөн Тайлагнах глобал санаачилга, НҮБ-ын глобал компакт үйл ажиллагааны хүрээнд тогтвортой байдлын тайлан гаргах асуудлаар оролцогч талуудтай ажиллаж байна.

2015 оноос Талуудын оролцоог хангах батлагдсан төлөвлөгөөний дагуу холбогдох хүчин чармайлтаа нэгтгэн, оролцогч талуудын харилцааг бүтцийн хандлагаар хөгжүүлж, системтэй, үр нөлөөтэй оролцооны үйл явцыг онилон ажилласан бөгөөд гол оролцогч талуудаа манай шинэчлэгдсэн стратегийн алсын хараан дор нэгтгэн, манай дунд болон урт хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд тэдний сонирхол, хөрөнгө оруулалтыг татах зорилго тавин ажиллаж байна. Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд манай гол оролцогчид, тэдний хүлээлтийг биелүүлэх бидний амлалт, мөн түүнийг хэрэгжүүлэх сувгууд, арга хэрэгсэл, хамтран ажиллах, хариуцлагатай гүйцэтгэх удирдлагаар хангах асуудлуудыг тусгасан болно.

	 АЖИЛТНУУД	 ХАРИЛЦАГЧИД	 ХӨРӨНГӨ ЭЗЭМШИГЧИД	 САНГУУД	 ЗАСГИЙН ГАЗАР	 ХОЛБООД	 БАЙГАЛЬ ОРЧИН
БИДНИЙ ГОЛ ИЛГЭЭМЖ	Ажил олгогч нь ажил мэргэжлийн хувьд ажилтнаа өсөж дэвжих боломжийг олгох, ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангах, ажлын таатай орчинг бүрдүүлдэг байна.	Бүхий л шатны үйлчлүүлэгчийн амьдрал болон бизнесийн найдвартай түнш амжилт олох, өсөж дэвжихэд нь туслах санхүүгийн найдвартай хамтрагч нь байна.	Санхүүгийн болон нийгмийн ашигтай урт хугацааны найдвартай хөрөнгө оруулалт нь компанийн засаглалын ил тод байдлыг бүхий л талаас бүрэн дүүрэн хангана.	Урт хугацааны тогвортой харилцаа үүсгэх хариуцлагатай хамтрагч	Үр дүнтэй болон нийгмийн хариуцлагаа ухамсарласан шийдвэр гаргах хууль сахин биелүүлэх иргэн	Бидний оршиж байгаа нийгмийн сайн сайхны төлөө өөрийн хувь нэмэрээ оруулах ёстойг ухамсарласан байгууллага	Байгаль орчны тогтвортой байдлыг хангахад түншүүд болон олон нийтийг татан оролцуулахад удирдгч нь байх
ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭЛТ	• Өрсөлдөхүйц цалин хөлс болон ашиг орлого • Ажлын сэтгэл ханамж болон танин мэдэх • Ажил мэргэжлээ хөгжүүлэх • Итгэл үнэмшил, хүндлэл • Ажил хөдөлмөрийн таатай орчин • Ажлын байрны эрүүл орчин	• Сайн бүтээгдэхүүн болон үйлчилгээ • Үндэслэлтэй хураамж • Түргэн шуурхай үйлчилгээ болон санхүүгийн зөвлөгөө • Аюулгүй гүйлгээ • Мэдээлэл болон хувийн нууцын хамгаалалт • Бүтээгдэхүүн, үйлчилгээнтэй хүртээмжтэй байдал • Гомдлыг хүндэтгэн шийдвэрлэх	• Урт хугацааны тогтвортой хөгжил • Үр ашигтай болон үндэслэлтэй хөрөнгө оруулалт • Хөрөнгө оруулалгчдын үнэлэмжийг нэмэгдүүлэх • Хүчтэй компанийн засаглал болон дотоод хяналт • Хөрөнгө оруулагчдын эрхийг хүндлэх	• Санхүүгийн тогтвортой байдал • Найдвартай актив, эрүүл эх үүсвэр, хөрөнгийн чадвар • Үндэслэлтэй зээл болон хөрөнгө оруулалт • Компанийн засаглалын туршлагыг бататгах, ил тод байх • Шуурхай тодруулга	• Хууль тогтоомжийг дагаж мөрдөх • Компанийн засаглалын өндөр стандарт болон ёс зуртахууны хэм хэмжээ • Санхүүгийн залилан, мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх • Санхүүгийн тогтвортой байдал • Татвар	• Ард иргэдтэй уялдаа холбоо • Үндэслэлтэй зээл болон хөрөнгө оруулалт • Ёс суртахуунтай харилцаа • Шуурхай, ил тод мэдээлэл • Орон нутгийн эдийн засаг болон аж үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих	• Байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах
СУВГУУД	• Онлайн портал • И-мэйл • Сошиал суваг • Багийн тайлангийн хурал	• Харилцагчтай харилцах тодорхой сувгууд (салбар, цахим хуудас, имейл, утсан харилцаа, сошиал суваг) • Хэвлэмэл сурталчилгаа • Зурагт • Цагаан мэдээ • Тусгай арга хэмжээ	• Албан ёсны хурал • Утсан холбоон хурал • Шаардлагатай тайлан • Захидлууд • Дижитал харилцаа: нууцлалтай мейл, цахим хуудас, онлайн санал авалт • Онлайн портал	• Албан ёсны уулзалт • Томоохон зөвлөгөөнд оролцох • Газар дээрх шалгалт • Газар дээрх танилцах уулзалт • Утсан холбоогоор хуралдах • Дижитал харилцаа: имейл, цахим хуудас, сошиал суваг	• Уулзалт • Албан захидал • Хүлээн авалтын арга хэмжээ	• Уулзалт, хуралт • Нийгмийн хариуцлагыг дэмжих арга хэмжээ болон спортын уралдаан тэмцээн • Хэвлэмэл сурталчилгаа • Зурагт • Хэвлэлийн бага хурал • Тусгай арга хэмжээ	• ГЗ • Ерөнхий захирал • С төвшний бүх захирлууд
ХАРИУЦАХ УДИРДЛАГА	• Гүйцэтгэх захирал • Хүний нөөцийн асуудал хариуцсан захирал • Иргэдийн банк хариуцсан захирал	• ГЗ • Ерөнхий захирал • Иргэдийн банк хариуцсан захирал • Үйл ажиллагаа хариуцсан захирал	• Гүйцэтгэх захирал, • Хөрөнгө оруулагч, компанийн засаглал хариуцсан захирал • Ерөнхий хуульч • Санхүү хариуцсан захирал	• ГЗ • Ерөнхий захирал • Санхүү хариуцсан захирал • Иргэдийн банк хариуцсан захирал • Эрсдэл хариуцсан захирал • Засаглал хариуцсан захирал	• ГЗ • Ерөнхий захирал • Санхүү хариуцсан захирал • Засаглал хариуцсан захирал • Officer • Ерөнхий хуульч • Үйл ажиллагаа хариуцсан захирал	• ГЗ • Ерөнхий захирал • Иргэдийн банк хариуцсан захирал • Үйл ажиллагаа хариуцсан захирал	• CEO • President • All C-level executives
ХАРИЛЦАН УЯЛДАА ХОЛБОО	• Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх ярилцлага болон ажил мэргэжлийн хөгжил дэвшлийн туршлага судлах (хагас жил тутам) • Сэтгэл ханамжийн санал асуулга (жил тутам) • Брэндийн үнэ цэнэ, байгууллагын соёл таниулах сургалт (жилийн турш) • Харилцаа холбоо: груп интранет, портал болон имейл (долоо хоног тутам) • Нийтийг хамарсан арга хэмжээнд ажилтнуудын гэр бүлийг давхар хамруулах	• PR болон маркетингийн кампанит ажлууд/шууд маркетинг хийх сурталчилгаа (жилийн турш) • Нийгмийн хариуцлагын төслүүд, арга хэмжээ болон форум зохион байгуулахад туслалцаа дэмжлэг үзүүлэх (жилийн турш) • Брэнд үйлчилгээ, харилцагчийн сэтгэл ханамжийн мониторинг болон зах зээлийн судалгаа (жил тутам)	• Хугацаат тайлан • Асуудал хариуцсан тодорхой албан тушаалтан (жилийн турш) • Хувьцаа эзэмшигчдийн хурал (жил тутам) • Хувьцаа эзэмшигчдийн тусгай уулзалт, ретрит • ТУЗ-ийн тусгай уулзалт, ретрит • ТУЗ-ийн хороодын хурал	• Асуудал хариуцсан тодорхой албан тушаалтан (жилийн турш) • IFRS audited financials (annual, semi-annual) • Үнэлгээ (жилийн) • Жилийн тайлан • Менежментийн шинэчлэл (жил/ улирал/сар тутам) • Covenants тайлан (жил/улирал/ сар тутам) • Газар дээрх шалгалт, мониторинг (улирал, жил тутам)	• Засгийн газрын институттай харилцах тодорхой албан тушаалтан (жилийн турш) • Засгийн газар болон түүний харьяа агентлагууд, хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөгчидтэй уулзах, хуралдах • Засгийн газрын болон нийгмийн хариуцлагын төсөл ивээн тэтгэх (жилийн турш)	• Хэвлэл мэдээлэл болон хүрээлэнгүүдтэй харилцах тодорхой албан тушаалтан • ТББ, хүрээлэн, иргэдийн холбоодын төлөөлөгчидтэй уулзаж нийгмийн хариуцлагад чиглэсэн арга хэмжээг ивээн тэтгэх, мөн өөр бусад төрлийн арга хэмжээ, форум зохион байгуулахад туслалцаа дэмжлэг үзүүлэх (жилийн турш) • Нийтийн оролцоог хангасан мэдлэг олгох арга хэмжээ, олон нийтийг татан оролцуулах арга хэмжээ (жилийн турш)	• Байгаль орчны менежментийн системийн группээс тодорхойлсон чиглэлийн байгаль орчны үнэлгээний мониторинг (жил тутам, улирал тутам) • Хүрээлэн, ТББ болон засгийн газрын агентлагуудтай уулзалт зохион байгуулах (жилийн турш) • Олон нийтийн оролцоог хамруулсан арга хэмжээ, сургалт (жилийн турш)



Эх дэлхий

Байгаль Орчин, Нийгмийн Хариуцлага

Энэ дэлхий бидэнд цор ганц.

ХасБанк хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Нийт 173.852 эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг гэр хорооллын өрхийн 80% буюу 150,489 айл өрхөд борлуулсан.
- Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд 7 жилийн хугацаанд жил бүр 282,318 тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан.
- 803 эко (цахилгаан бензин хосолмол хөдөлгүүрт) машины зээл олгосон.

Бид Монголын арилжааны банкуудаас сэргээгдэх эрчим хүчний төслийг санхүүжүүлсэн анхны арилжааны банк боллоо.

10МВт нарны цахилгаан станцыг барих төслийн үр дүнд нийт 306,750 тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 4,276,250 литр ус хэмнэх (төсөл хэрэгжих хугацаанд буюу 25 жилийн хугацаанд) ба уг төслийг Уур амьсгалын ногоон сантай (УАНС) хамтран санхүүжүүлж байгаа болно.

ХасБанк нь түнш байгууллагууд болон олон нийтэд байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжлийн талаар сурталчлан таниулахад манлайлагч байгууллага билээ

ХасБанкны нийгэм, байгаль орчны бодлого нь компанийн нийгмийн хариуцлагын журмаар зохицуулагддаг бөгөөд энэ нь бидний бизнесийн хариуцлагыг хэрэгжүүлэх, урт хугацааны бизнесийн амжилтыг хангахад чухал үүрэгтэй бодлого юм. ХасБанк нь бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой үндэсний болон олон улсын байгаль орчны дүрэм журам, зохицуулалтыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг билээ.

ХасБанк нь Нийгэм, Байгаль Орчны Менежментийн Системийн Бодлогын дагуу байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлдэг бөгөөд 2014 онд шинэчлэгдсэн болно. Үүнд:

- Зээлд тогтмол хяналт хийж, тайлагнах. Тухайлбал, зээлдэгч нарт байгаль орчны үнэлгээ хийдэг
- Зээлдэгчийн эрхэлж буй үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх
- Зээлийн анхан шатанд Банкны санхүүжүүлэхийг хориглосон жагсаалтад орсон үйл ажиллагаа мөн эсэхийг шалгаж, хэрэв мөн бол санхүүжүүлэхээс татгалзах
- Шаардлагатай тохиолдолд зөвлөгөө өгч ажиллахаас гадна зөрчлийг арилгах арга хэмжээ авах
- Зээлийн хяналтыг тогтмол болон гэнэтийн хяналт хэлбэрээр хийдэг
- Хөндлөнгийн байгууллагаар өөрсдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийлгэдэг.

Нийгэм, Байгаль Орчны Менежментийн Системийн Бодлого нь зээлээр санхүүжүүлэх үйл ажиллагаа бүрийн онцлогт тохирсон байдаг.

Бид жил бүр нийгмийн сайн сайхны төлөө болон олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг санаачлан зохион байгуулдаг бөгөөд 2017 оны 9-р сард Боломжийг бодит бий болгоё уриан дор ХасБанкны Ногоон Санхүүжилтийн Анхдугаар Форумыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 350 бичил, ЖДБ эрхлэгч болон оролцогч талууд хүрэлцэн ирсэн бөгөөд ХасБанкны хүлэмжийн хийг

бууруулах бизнесийн зээлийн талаар олон нийтэд мэдээлж, Уур Амьсгалын Ногоон Сангийн магадлан итгэмжлэгдсэн байгууллага болсныг зарласан.

- 2017 оны 5 дугаар сард 8 дахь жилдээ Сэргээгдэх эрчим хүчний форумыг хамтран зохион байгуулсан ба нийт 300 бизнес аж ахуйн нэгж, засгийн газрын мэргэжилтнүүд оролцсон ба энэ арга хэмжээний үеэр ХасБанкны эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүчний хөгжилд оруулж буй хувь нэмэр, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлсэн юм.
- 2017 оны 9-р сард Тогтвортой Санхүүжилтийн 5 дугаар форумын үеэр ХасБанкны болон УАНС-ийн санхүүжилттэй хэрэгжиж буй хүлэмжийн хийг бууруулах зээлийн бүтээгдэхүүнийг танилцуулав.
- ММСГ ХХК-ийн зохион байгуулсан “Бизнесийг ногооруулах ДНХ” форумд 200 хүн оролцсон бөгөөд форумын үеэр Хүлэмжийн хийг бууруулах зээлийн бүтээгдэхүүнийг танилцуулан оролцлоо.
- 2017 онд Барилга Хот Байгуулалтын Яам, Даян Дэлхийн Байгаль Орчны Сан ба НҮБХХ-н зохион байгуулсан Монгол улсын барилгын салбарт хүлэмжийн хийг бууруулах дугуй ширээний уулзалтад ХасБанкны хүлэмжийн хийг бууруулах зээлийн бүтээгдэхүүнийг танилцуулав.

Бид банкны хэмжээнд хийгдсэн нийгэм, байгаль орчны үнэлгээг цуглуулан нэгтгэж хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт нийгэм, байгаль орчны тайланг тогтмол хүргүүлдэг билээ. Мөн бид банкны хэмжээнд дотооддоо байгаль орчныг хамгаалах буюу эрчим хүч, түлш, цаасны хэрэглээг бууруулах болон хог хаягдлыг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Эко Банк



Эко банк

Төсөл хэрэгжүүлэх

Эко Банкны Хэлтэс нь 2010 - 2015 оны хооронд Монголын Мянганы Сорилтын Сан, Засгийн Газрын тусгай сан болох Цэвэр Агаар Сан, Дэлхийн Банкны “Улаанбаатар - Цэвэр Агаар Төсөл”-үүдийн санхүүжилтээр “Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нийлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, өөрийн Борлуулалтын цэгүүдээр дамжуулан гэр хорооллын айл өрхүүдэд эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын нийт айл өрхийн 80 гаруй хувь буюу 185,000 айл өрхөд хүрч ажилласан билээ. Гэр хорооллын айл өрхүүд 8 сарын турш үргэлжлэх халаалтын улиралд уламжлалт зууханд түүхий нүүрс шатаах замаар гэр орноо дулаацуулдгаас их хэмжээний утаа ялгарч, энэ нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80%-ыг бий болгодог байна. Агаарын бохирдлыг багасгах зорилгоор хэрэгжүүлсэн Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нийлүүлэх хөтөлбөр нь уламжлалт зуухыг эрчим хүчний хэмнэлттэй зуухаар сольж, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгахад бодитой хувь нэмэр оруулж ирсэн юм.

2017 онд ХасБанк нь Монгол улсын үндэсний эрх бүхий байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны харьяа Байгаль Орчин Уур Амьсгалын Санг төлөөлж бэлэн байдлын дэмжлэгийн хүсэлтийг УАНС руу илгээсэн. Уг бэлэн байдлын санхүүгийн дэмжлэгийн санхүүжилтийг 2017 оны 11-р сард хүлээн авч Эко банкны хэлтэс энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Бэлэн байдлын дэмжлэгийн гол зорилго нь үндэсний эрх бүхий байгууллагын чадавхыг бэхжүүлэхээс гадна УАНС-тай хамтран ажиллах стратегийн төлөвлөлт, үндэсний хөтөлбөрийг боловсруулж УАНС-аас олгосон санхүүжилтийн үр ашигтай, зохистой хэрэглээг дэмжихэд оршино.

Мөн ХасБанк нь бичил, ЖДБ эрхлэгч харилцагч нарынхаа чадавхыг бэхжүүлэх зорилгоор санхүүгийн тайлан бэлтгэх анхан болон гүнзгий шатны сургалт, эрчим хүчний хэмнэлттэй төсөл хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан. 2017 оны 9-р сарын 6-нд ХасБанк Ногоон Санхүүжилтийн Анхдугаар форумыг зохион байгуулсан ба уг арга хэмжээнд 350 гаруй бичил, ЖДБ эрхлэгч болон оролцогч талууд хүрэлцэн ирсэн юм. Уг форумын гол зорилго нь бизнес эрхлэгч нарт эрчим хүчний хэмнэлтийн боломжууд болон ХасБанкны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа, харилцагч нарын туршлагыг танилцуулах байсан билээ.

Тогтвортой санхүүжилт

Эко Банкны Хэлтэс нь 2013 оноос Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангийн эх үүсвэрээр Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг эхлүүлсэн юм. Тус хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэрэглээг 20% хэмнэх, эсвэл хүлэмжийн хийн ялгарлыг 20 буюу түүнээс дээш хувиар бууруулж бай гэсэн шалгуурыг хангасан сэргээгдэх эрчим хүчний болон эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, мөн тоног төхөөрөмжөө сольж буй эцсийн хэрэглэгч бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийг санал болгон ажиллаж байна. 2014 онд тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн цар хүрээг улам нэмэгдүүлэх зорилгоор Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилт (МонСЭФФ)-ийн эх үүсвэр, 2016 онд DWM Securitizations-н эх үүсвэр авсан бол 2017 онд Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрт зориулан санхүүжилт олгосноор зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээ улам нэмэгдсэн юм. Эдгээр хамтрагч байгууллагууд нь ХасБанкны Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж байгаа бөгөөд Үйлдвэрлэл, худалдаа, угсралт суурилуулалтын үйлчилгээ эрхлэгч нарт болон сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй технологийн эцсийн хэрэглэгчдэд хөнгөлөлттэй санхүүжилт авах боломжийг бүрдүүлсэн юм.

Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр 51 тэрбум төгрөгийн зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгож 854,020 тонн хүлэмжийн хийг бууруулсан байна.

Эко Банкны Хэлтэс нь 2015 онд Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч РеспонсАбилити байгууллагатай хамтран ажиллаж цахилгаан хөдөлгүүртэй автомашины түлшний хэмнэлтийг бензин хөдөлгүүртэй автомашины түлшний хэрэглээтэй харьцуулсан судалгааг хийж, судалгааны үндсэн дээр Эко автомашины зээлийн хөтөлбөрийг эхлүүлсэн юм. Эко автомашины зээлийн хөтөлбөрт хамрагдсан ХасБанкны харилцагчид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авснаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулаад зогсохгүй шатахууны зардлаа хэмнэх боломж бүрдсэн юм. Тус хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 803 харилцагчид нийт 8.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна.

Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран ажилласанаар эко төслүүдийг санхүүжүүлэхэд таатай нөхцөлтэй эх үүсвэр татаж байна.

Эко Банкны Санаачилга

Эко Банкны Хэлтэс нь 2009 онд байгуулагдсан бөгөөд банкны энэхүү нэгж нь байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдэд тогтвортой эрчим хүчний санхүүжилт хийдэг, эрчим хүчний хэмнэлттэй төслийн хүлэмжийн хийн бууралтын суурь үзүүлэлтийг тогтоож, эрчим хүчний хэмнэлтийг хэмжих чиглэлээр мэргэшсэн Монгол Улсын банкны салбар дахь цорын ганц бизнесийн нэгж юм. ХасБанк нь үйл ажиллагаандаа гурван тулгуурт эрхэм зорилго буюу Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашгийг эрхэмлэн ажилладаг билээ. Харин Эко Банкны Хэлтэс нь ХасБанкны энэхүү гурван тулгуурт эрхэм зорилгын Эх Дэлхий хэмээх эрхэм зорилгод өөрийн үйл ажиллагааг чиглүүлж, тогтвортой санхүүжилт, карбоны санхүүжилт болон төсөл хэрэгжүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай эко харилцагч

Нахиа Импекс
Эмийн үйлдвэрлэл

“ХасБанкны Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн зээлийн хэрэглэгч болсноор Нахиа Импекс нь эрчим хүчний хэмнэлттэй, хүлэмжийн хийг багасгах шийдэл олсон бөгөөд Good Manufacturing Practice (GMP) стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг Монголын 3 дахь эмийн үйлдвэр болж чадсан. Мөн эмэгтэй бизнес эрхлэгчдийн хөнгөлөлттэй нөхцөлийн дагуу хүүгийн хэмжээгээ улам бууруулж чадсанд баяртай байгаа.



Нахиа ХХК нь эмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч компаниудын нэг бөгөөд 1994 онд бизнесээ эхэлснээс хойш хурдацтайгаар өсч байна. Компанийн хэтийн зорилго нь хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологиор үйлдвэрлэсэн өндөр чанартай эмээр монголчуудыг хангах явдал юм. Тус компани нь эмийн үйлдвэр, эмийн сан, эм ханган нийлүүлэх төвийг эзэмшдэг бөгөөд үйл ажиллагааг нь удирддаг. Тус үйлдвэр одоо 100 гаруй ажиллагсадтай бөгөөд тарилгын эм, шахмал, нунтаг бэлдмэл, тос тосолгооны материал, галеин бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан нунтаг антибиотик гэх мэт 70 гаруй төрлийн эм үйлдвэрлэж байна.

Карбоны Санхүүжилт

ХасБанк нь Эрчим хүчний хэмнэлттэй (ЭХХ-тэй) бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд борлуулсан ЭХХ-тэй бүтээгдэхүүний хэрэглээнд Микро Энерги Кредитс компанитай хамтран мониторинг хийдэг билээ. Энэ хүрээнд карбоны сайн дурын зах зээл болон НҮБ-н цэвэр хөгжлийн механизмын зах зээлээс карбоны нөхөн олговор хүлээн авах боломж бүрддэг. Эдгээр карбоны бууралтыг нийгмийн хариуцлагаа хүлээх болон карбоны бууралтын зорилтдоо хүрэх зорилгоор олон улсын байгууллагууд худалдан авдаг. Карбоны бууралтын арилжааны орлого нь эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулагдах болно. ЭХХ-тэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн үр дүнд бий болсон карбоны бууралтыг Eсо Climate Care Sale, Швед улсын засгийн газар болон Микрософт корпораци зэрэг байгууллагууд худалдан авсан болно.



Одоо байгаа үр ашиггүй тоног төхөөрөмжийг шинэ эрчим хүчний хэмнэлттэй технологиор сольсноор нэгж бүтээгдэхүүнд ногдох үйлдвэрлэлийн зардлыг эрс багасгаж чадсан. Эрчим хүчний хэрэглээгээ багасгаж, үр ашгийг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлсэн болно.

2017 онд Нахиа Импекс нь ХасБанкаас Хүлэмжийн Хий Бууруулах Бизнесийн зээл авч 54% ийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгосноор 370 МВтц /жил эрчим хүчийг хэмнэж байгаа. Төслийг хэрэгжүүлснээр жилд 52 сая төгрөгийг хэмнэж байгаа бөгөөд төслийн хэрэгжих хугацаанд 6000 тонн хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж байгаа юм.

Уур Амьсгалын Ногоон Сан (УАНС)

ХасБанк нь Монгол Улсад цор ганц Уур Амьсгалын Ногоон Сангийн (УАНС) магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд Уур Амьсгалын Ногоон Сан нь хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC)-ийн хүрээнд байгуулагдсан юм. Тус сан нь өөрийн магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудаар дамжуулан дэлхий даяар хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг санхүүжүүлдэг.

Монгол улсын тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх зорилгын хүрээнд ХасБанк 2017 оны 9-р сард хоёрдугаар санхүүжилтийн саналаа

УАНС-д илгээсэн. Энэхүү санал нь дотоодын санхүүжилтээр шийдсэн ахны нарны цахилгаан станц барих төсөл юм. Монгол улсын өмнөд зүгт 10МВт нарны цахилгаан станц нь жилд 12,270 тонн хүлэмжийн хийг бууруулж (20,000 гаруй айл өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах) төслийн хугацаанд буюу 25 жилд нийт 171,050 литр ус хэмнэх төсөл юм.

Мөн ХасБанк нь цаашид УАНС-тай хамтарч хэд хэдэн санхүүжилтийн санал дээр ажиллаж байгаа болно. Монгол улсад илүү их хөнгөлөлттэй тогтвортой санхүүжилт оруулж ирэх зорилгоор харилцагч нарт илүү таатай боломж бий болгож байгаль орчинд чиглэсэн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх болно.



Бид Уур амьсгалын ногоон сантай хамтран ажиллаж, уур амьсгал, байгаль орчны чиглэлийн төслүүдийг таатай нөхцлөөр санхүүжүүлэх боломжтой боллоо.

Зээлдэгч Пүрэвдорж, Мягмарсүрэнгийн бизнес
ХасБанкны харилцагч болж ЭКО бүтээгдэхүүнийг Монгол улсад борлуулж байгаа түүхээс:

“ Бид анх дулааны сүлжээнд холбогдоогүй хөдөө орон нутагт байрладаг айл өрхүүдэд хүйтэн усаар угааж болдог угаалгын нунтаг борлуулж эхэлсэн юм. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь зах зээл дээр маш хурдан эрэлттэй болж эхэлсэн. Үүний дараа бид Хятад улсад бүтээгдэхүүний судалгаа хийсний үр дүнд “Яагаад заавал гараараа угаах ёстой гэж?” гэсэн бодол толгойд орж ирсэн бөгөөд нарны эрчим хүч ашигладаг угаалгын машин борлуулах төлөвлөгөө гаргасан юм. Энэхүү төсөл маань ч амжилттай хэрэгжээд удаагүй байтал “Яагаад хөдөө орон нутгийн хүмүүс үрчгэр хувцас өмсөх ёстой гэж?” гэх бодол орж ирснээр бид нарны эрчим хүчээр ажилладаг индүү зах зээлд оруулж ирсэн. Үүгээр ч зогсохгүй бид телевизор, хөргөгч зэрэг бүтээгдэхүүнийг борлуулж эхэлсэн юм.”

Мягмарсүрэнгийн ХасБанкны Анхдугаар Ногоон Санхүүжилтийн Форум дээр хэлсэн үг
(2017 оны 9-р сар)



Пүрэвдорж болон түүний гэргий Мягмардорж 1998 онд Эрхүү хотод худалдаа эрхэлдэг байсан боловч рублийн ханш унасны улмаас бизнес нь зогссон. 1999 оноос Улаанбаатарт ирээд Нарантуул захад лангуу түрээсэлж нарны зайн систем борлуулж эхэлсэн. 2002 оноос Хөгжлийн Алтан сан ББСБ-с анх 150,0 төг-ийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авсан.

Анх зээл авах үед сэргээгдэх эрчим хүчний төрлийн бараа зах зээлд байхгүй байгааг анзаарч, зах зээлд нэвтрүүлнэ гэсэн зорилготойгоор бизнесээ эхлүүлж байсан түүхтэй. Тэр үеэс хойш 15 жил өнгөрөөд байна.

Бид маш олон төрлийн өргөн хэрэглээний цахилгаан бараа буюу нарны эрчим хүчний дэлгэц, салхин сэнс, хөлдөөгч, зурагт, угаалгын машин, ус буцалгагч, төрөл бүрийн гэрэл, сүү боловсруулах машин, мотор, усны насос, дуран зэрэг бүтээгдэхүүнийг хөдөө орон нутгийн айл өрхүүдэд худалдаалж эхэлсэн. Мөн бидний бүтээгдэхүүнүүд бүгд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг юм.

ХасБанк бидний санхүүгийн найдвартай түнш байгууллага байсаар ирсэн. Энэ нь биднийг бизнесээ итгэл төгс, тогтвортой явуулах урам

зориг өгч байсныг хэлэхэд таатай байна.

ХасБанктай олон жилийн турш хамтран ажиллахад бид нэг зүйл анзаарсан. Найдвартай, үнэнч харилцагчдаасаа хэзээ ч санхүүжилтээ татдаггүй харин тууштай бус, бизнесээ байнга сольдог, зээлийн эх үүсвэрээ зориулалт бусаар ашигладаг харилцагч нарыг дэмждэггүй гэдгийг ойлгосон.

Энэ 15 жилийн хугацаанд хамт бизнес хийж байсан болон Нарантуул захад бизнес эрхэлж байгаа боломжийн орлого сайтай хүмүүсийг ажиглахад ихэнхдээ зээл аваад хийнэ гэсэн зүйлээ хийхгүй, зээлийг зориулалт бусаар зарцуулж бизнесээ зогсооход хүрдэг.

Хамгийн чухал зүйлүүдийн нэг бол зээл авсны дараа зориулалтаар нь зарцуулж чаддаг байх ёстой. Бид үүнийг 15 жил мөрдөж ажиллаад бизнестээ том хөрөнгө оруулалтыг ХасБанкнаас авч чадсан. Бид өрхийн орлого зарлагын тооцоог маш сайн хийж, төлөвлөгөөгүй хэрэглээг дэмждэггүй бөгөөд хэрэглээгээ маш сайн тооцож чаддаг. Энэ нь зээлээ зориулалтын дагуу эргэлтэндээ оруулж барааны үлдэгдлээ байнга нэмэгдүүлж, бидэнд давуу тал үүсгэж чадсан гэдгийг цаг хугацаа болон бидний эрхэлж байгаа бизнес өргөжин тэлж байгаа нь нотолж байна.

Харилцагч үйлчлүүлэгч нартаа маш сайн үйлчилж, үнэнч байж чанартай сайн бараа зарж 3 жилийн баталгаа өгөөд эргэж ирэхэд нь барааг нь сольж өгөх, засах зэрэг бүх үйлчилгээг үзүүлж байсан нь орон нутгийн малчдын сэтгэлд хүрч тэдний үнэнч нийлүүлэгч болж чадсан.

Мөн манай компанийг хариуцаж ажилласан банкны зээлийн мэргэжилтний зөвлөгөө бидний бизнесийн ажилтанд маш их хэрэг болсон. Бизнесийн зардал, төсөв гэх зэргийг маш сайн тайлбарлахад бид ч мөн анхааралтай сонсож зөвлөмжийг дагаснаар бизнесээ өргөжүүлж чадсан.

Эрүүл ашиг



Бизнесийн үйл ажиллагааны орчин

Монгол Улсын эдийн засгийн мөчлөг өнгөрсөн 2 жилийн турш үргэлжилсэн 1-2 хувийн нам дор өсөлтөөс 5-6 хувийн дундаж түвшний өсөлттэй орчинд шилжлээ. Үүнтэй уялдан бизнесийн үйл ажиллагааны орчин ялангуяа 2017 оны 2 дугаар хагасаас эхлэн сайжрав. Өнгөрсөн онд эдийн засгийн бодит өсөлт 5.1%-д хүрэхэд бөөний ба жижиглэнгийн худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ болон тээврийн салбарын өсөлт голлон нөлөөллөө. 2016 онтой харьцуулахад худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар, боловсруулах үйлдвэрлэл болон үйлчилгээний салбар тус бүрийн ДНБ-ий бодит өсөлтөд үзүүлэх хувь хэмжээнд харгалзан 2.0, 1.6, 1.4, болон 0.8 нэгж хувийн мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гарсан байна.

Монгол Улсын экспортын үнийн агрегат индекс 18%-иар өссөнөөр гадаад худалдааны нөхцөл 13%-иар сайжирлаа. Нийт экспорт 26%-иар өсөхөд нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн хугацааны хамгийн өндөр түвшин болох 33 сая тоннд хүрч нэмэгдсэн нь шууд нөлөөлж, энэхүү урьдчилан таамаглагдаагүй эерэг өөрчлөлтийн нөлөөгөөр гадаад худалдааны ашиг 20%-иар өсчээ. Тайлант онд барааны импорт 29%-иар, анхдагч болон хоёрдогч орлогын дансны алдагдал 74%-иар тус тус өссөн нь гадаад төлбөрийн урсгал тэнцлийн алдагдлыг 63%-иар нэмэгдүүлж 1.1 тэрбум ам.доллар буюу нэрлэсэн ДНБ-ий 10.2%-тай тэнцэх хэмжээнд хүргэв. Гэхдээ гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэсэн, ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд өмнө нь хүлээгдэж байснаас илүү их хэмжээний зээлийн эх үүсвэр авсан, төлөгдөх хугацаа нь болсон гадаад бондыг дахин санхүүжүүлэх зорилгоор олон улсын зах зээлд шинээр арилжаалсан Засгийн газрын бондын эх үүсвэр орж ирсэн зэрэг өөрчлөлтийн улмаас гадаад төлбөрийн санхүүгийн тэнцлийн ашиг 3.2 дахин нэмэгдсэн бөгөөд улмаар төлбөрийн нийт тэнцэл 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Оны эцэс гэхэд гадаад валютын улсын нөөц 2 дахин өсч 3 тэрбум ам.долларт хүрэв.

Макро эдийн засгийн гадаад тэнцэлд дээр дурдсан эерэг өөрчлөлтүүд гарсан, гадаад валютын улсын нөөцийн позиц сайжирсан, нийт дүнгээрээ 1.1 тэрбум орчим ам.долларын Засгийн газар, түүний баталгаатай бондын дахин санхүүжилтийг амжилттай гүйцэтгэсэн, төсвийн алдагдал мэдэгдэхүйц дүнгээр буурсан зэрэг нь эдийн засагт итгэх итгэлийг сэргээх, зах зээлийн дунд хугацааны хүлээлтийг сайжруулах, валютын захыг тогтворжуулах, нийт мөнгөний нийлүүлэлт 30.5%-иар өсөх, мөнгөний хатуу бодлогын төлөв үе шаттай зөөлрөх нөхцөлийг бүрдүүлэх, нийт эрэлт 2014 оны түвшинд тэмүүлж алгуур өсөхөд тус тус


эергээр нөлөөлж байна. Инфляци жилийн турш 1.1%-иас 6.4% болж өссөн хэдий ч, төв банкны зорилтот түвшин болох 8%-иас доогуур түвшинд гарлаа.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2018-2019 онд 0.2 нэгж хувиар сайжран 3.9% болох төсөөлөлтэй байгаа нь 2016 оны гүйцэтгэлээс даруй 0.7 нэгж хувиар өндөр байхаар байна. Ийнхүү дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн суурь төсөөллүүд сайжирч, БНХАУ-ын эдийн засгийн итгэл сэргэж байгаа нь ашигт малтмалын түүхий эд, тэр дундаа коксжих нүүрс болон өнгөт металлын суурь эрэлт тогтвортой байхад эергээр нөлөөлнө. Гадаад орчинд бий болсон эдгээр эерэг хандлага нь Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл, хөрөнгийн урсгалын тогтвортой байдал, нийт эдийн засагт итгэх итгэл, эдийн засгийн өсөлтийн шинэ мөчлөгийг дунд хугацаанд үргэлжлүүлэн дэмжихээр байна. Монголын эдийн засгийн өсөлт саарах мөчлөг 2016 онд дуусгавар болж 2017 оны 2 дугаар хагасаас алгуур өсөх мөчлөгт шилжсэн, 2018 онд эдийн засаг бүрэн сэргэнэ гэсэн хүлээлт зах зээлд давамгайлж байна. Энэхүү бодитой хүлээлттэй холбоотойгоор 2015 оноос хойш бүтэн 3 жилийн турш тасралтгүй уналттай байсан орон сууцны зах зээлд алгуур сэргэх дохио 2018 оноос гарах магадлалтай юм.

2018 оны макро эдийн засгийн гол эрсдэл нь өсөн нэмэгдэж буй инфляци болж байна. Түлш, шатахуун, хүнсний бүтээгдэхүүний үнэ болон тээврийн өртөг зардал өсч, нийлүүлэлтийн гаралтай болон зардлын шалтгаантай инфляцийн дарамт өсөх сөрөг хүлээлт бий болов. Хэрэв инфляци төсөөлснөөс илүү хурдацтай өсвөл энэ нь өрхийн бодит орлого, худалдан авах чадвар, иргэдийн зээлийн эргэн төлөлт болон дотоодын зах зээлд хүүний түвшин буурч байгаа эерэг хандлагад тус тус сөрөг нөлөөлөл бий болгох эрсдэлтэй байна.


Монгол Улсын экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засгийн шингээх чадавхийг дээшлүүлэх, бодит секторын идэвхжилийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлд шинэчлэл хийх, нийгмийн дундаж давхаргыг бэхжүүлэх, эдийн засагт урт хугацааны хуримтлал ба хөрөнгө оруулалтын оновчтой бүтцийг бий болгох замаар макро бодлогын шинэчлэл хийх нь эдийн засгийн гол зангилаа асуудал, бодлогын сорилт хэвээр байна.

Хөрөнгийн урсгал: Нүүрсний экспортын өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын сэргэлтийн нөлөөгөөр мэдэгдэхүйц сайжирлаа.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

ДНБ бодит өсөлт: 5%-ийн түвшинд хүрч сэргэв.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Төлбөрийн тэнцэл: \$1450 сая ашигтай гарав.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Макро тэнцэл: Гадаад төлбөрийн урсгал дансны алдагдал өссөн ч, санхүүгийн дансаар бүрэн санхүүжигдэв. Улсын төсвийн алдагдал буурлаа.




Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Инфляци: Зорилтот 8%-ийн түвшинд нийцтэй байв.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад валютын нөөц: \$3 тэрбум болж өсөв.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

Банкны салбар

Өмнөх 2016 оноос дамжин ирсэн эдийн засагт итгэх итгэлийг сулруулсан нэн сөрөг хүлээлт, эдийн засгийн цаашдын хандлага дахь тодорхой бус байдал болон гадаад санхүүжилтийн хэрэгцээ нь 2017 оны эхний хагаст дотоодын санхүүгийн салбар, хувийн хэвшилд ачаалал, дарамт үүсгэж байв. Үүнтэй уялдан зээлийн эрэлт нэмэгдэх, санхүүгийн зуучлал сэргэх хугацаа бүхэлдээ оны сүүлийн хагас хүртэл хойшилсон юм. Харин гадаад зах зээлийн орчин тогтвортой сайжирч дотоодын эдийн засагт эерэг нөлөө үзүүлсээр байсан, дэлхийн болон бүс нутгийн зах зээлд ашигт малтмалын үнэ өссөн, нүүрсний экспорт үлэмж хэмжээгээр нэмэгдсэн, оны 3 дугаар сард Засгийн газрын баталгаатай бондыг дахин санхүүжүүлсэн, оны 5 дугаар сард ОУВС-гаас Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг баталсантай уялдан эдийн засгийн эрсдэл буурч, цаашдын төлөв хандлага нь илүү тодорхой, ойлгомжтой, төсөөлж болохуйц болсон билээ.

Ингэснээр эдийн засгийн хүлээлт эерэг чиглэлд өөрчлөгдөж, бизнесийн итгэл сэргэж эхэлсэн бөгөөд хувийн хэвшлийн зээлийн эрэлт оны сүүлийн хагасаас алгуур нэмэгдэх хандлагатай болсон юм. Монгобанк мөнгөний бодлогын нэн хатуу төлөвийг 2017 оны 6, 12 дугаар саруудад зөөлрүүлж, мөнгөний бодлогын хүүг нийт 3 нэгж


хувиар бууруулан 11% болгов. Банкны салбарын нийт актив, харилцах болон хадгаламж, зээлийн өрийн үлдэгдэл харгалзан 14%, 23%, 10%-иар тус тус өслөө.

2017 оны 2 дугаар хагаст бизнесийн үйл ажиллагааны орчин сайжирсан хэдий ч, хөндлөнгийн аудитын фирмийн гүйцэтгэсэн Активын чанарын үнэлгээнд банкууд ихээхэн хүчин чармайлт, цаг хугацаа, нөөц зарцуулсан юм. Активын чанарын үнэлгээ нь ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн нэг нөхцөл, банкны салбарыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын эхний шатны арга хэмжээ гэж зохицуулагч байгууллагууд үзсэн бөгөөд уг үнэлгээний үр дүнд банкны салбар тогтвортой, системийн шинжтэй тогтворгүй байдлын эрсдэл бага гэсэн дүгнэлт гарсан байна.


Монгол Улсын банкны салбарт активын чанар муудах эрсдэл мэдэгдэхүйц буурч системийн хэмжээнд чанаргүй зээлийн харьцаа тогтворжоод байна. 2017 оны эцсийн байдлаар чанаргүй зээлийн харьцаа 8.5%-д тогтвортой байгаа бол хугацаа хэтэрсэн зээлийн харьцаа 6.0% болж буурсан үзүүлэлттэй гарчээ. Банкны салбарын өөрийн хөрөнгө нь хоёрдогч өглөгийг хассанаар 14.9%-иар өсч 2709 тэрбум төгрөгт хүрсэн бол системийн хэмжээнд цэвэр ашиг 40.7%-иар өсч 249 тэрбум төгрөгт хүрчээ.

Активын чанар: Муудах эрсдэл буурсан.

Актив, хадгаламж, зээл: Алгуур өссөн.



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк



Тоон өгөгдлийн эх сурвалж: Монголбанк

2017 оны санхүүгийн гүйцэтгэл

ХасБанкны санхүүгийн чадавхийн хувьд 2017 он шалгуур өндөртэй жил байлаа. Хэдийгээр бид зээлийн хүүгийн түвшинг тодорхой түвшинд бууруулан ажилласан боловч үйл ажиллагааны сайн үр дүнг үзүүлж 20.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтайгаар дүгнэгдлээ. Эдийн засгийн тааламжтай нөхцөл бүрдэж буйн хамтаар банкны зээлийн багцын өсөлтөд эерэг үр дүн харагдаж, харилцах хадгаламжийн багц 31.3% - иар өсөж, чанаргүй зээлийн багцын дүнг бууруулж чадсан.

2017 оны турш балансын уян хатан удирдлагыг хэрэгжүүлж хэтийн өсөлтийг дэмжин ажилласан. Эдгээр шинэчлэлт, хөрөнгө оруулалтын ажлуудын хамтаар ХасБанк өөрсдийн байр сууриа хадгалан ажиллах зорилготой байсан бөгөөд энэхүү зорилгодоо хүрсэн үр дүнг харууллаа.

Санхүүгийн үзүүлэлтүүд

тэрбум төгрөг			
Санхүүгийн үзүүлэлтүүд	2017	2016	Өөрчлөлт
Үйл ажиллагааны үр дүн			
Үйл ажиллагааны цэвэр орлого	82.4	77.1	6.9%
Үйл ажиллагааны зардал*	62.1	53.9	15.3%
Сангийн зардал	(0.7)	31.1	-102.3%
Цэвэр ашиг	20.1	21.5	-6.3%
Үлдэгдлийн тэнцэл			
Нийт хөрөнгө	3,042.5	2,257.3	34.8%
Зээл, цэвэр	1,322.1	1,139.9	16.0%
Нийт зээл	1,402.5	1,230.7	14.0%
Зээл төлөгдөхөд гарч болзошгүй алдагдлаас хамгаалах сан	(88.9)	(98.9)	-10.1%
Хадгаламж	1,284.9	978.3	31.3%
Татан төвлөрүүлсэн эх үүсвэр	1,504.8	1,054.8	42.7%
Өөрийн хөрөнгө	199.4	179.0	11.4%
Харьцаа (%)			
Эрсдэл даах чадварын харьцаа	80.9	88.6	
Хөрвөх чадварын харьцаа >25%	43.9	42.5	
Өөрийн хөрөнгийн өгөөж	10.8	13.5	
Хөрөнгийн харьцаа >9%	11.2	12.7	
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа >14%	16.8	19.2	

*өөрийн эх үүсвэрийн зардлаар тохируулга хийв

2017 оны санхүүгийн гүйцэтгэл



ҮР ДҮНГИЙН ӨСӨЛТҮҮД

ХасБанк 2017 оны туршид 20.1 тэрбум төгрөгийн цэвэр ашиг, 10.8 хувийн өөрийн хөрөнгийн өгөөж, 82.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны цэвэр орлоготойгоор ажилласан. Өнгөрсөн жилийн үзүүлэлттэй харьцуулахад цэвэр ашиг 6.3 хувиар буурсан бөгөөд үйл ажиллагааны орлогыг өсгөж, эрсдэлийн сангийн зардлыг бууруулж чадсан хэдий ч ашгийн түвшин буурахад үйл ажиллагааны зардал голлох нөлөөтэй байсан.

Цэвэр үйл ажиллагааны орлогын хувьд 6.9 хувийн өсөлттэй байсан ба хураамж шимтгэлийн орлогын өсөлт болон зээлийн эрсдэлийн сангийн орлогоос хамааран дээрх үр дүнд хүрсэн.

Зээлийн хүүгийн түвшин буурсан болон хүүгийн зардал өндөр байсан зэргээс улбаалан цэвэр хүүгийн орлого 30.8 хувиар буурч улмаар ашигт ажиллагааны түвшинд нөлөөлсөн. Хураамж шимтгэлийн цэвэр орлогын өсөлт 29.0 хувь байсан нь картын үйл ажиллагааны шимтгэл болон дансны үйлчилгээний орлогоос зонхилох нөлөөлтэй байсан байна.

2017 онд үйл ажиллагааны зардлын өсөлтөд нөлөөлсөн онцлог хэд хэдэн үйл хэргүүд банкны ашигт ажиллагаанд тодорхой хэмжээний нөлөө авчирсан. Үйл ажиллагааны зардал 62.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 15.3 хувиар өссөн ба үүнд хүний нөөцийн зардлын өсөлт, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний төлбөр зэрэг багтаж байсан.

Шаргуу ажиллагаа, хөрөнгийн чанарын удирдлагын үр дүнд чанаргүй зээлийн түвшинг харьцангуй тогтвортойгоор барьсан. Нийт чанаргүй зээлийн түвшинг бууруулж чадсанаар 2017 онд банкны хэмжээний зээлийн эрсдэлийн сангийн зардал эерэг буюу 0.7 тэрбум төгрөгийн дүнтэй байсан байна.

Уян хатан санхүүгийн тайлан

Банкны нийт хөрөнгийн хэмжээ өнгөрөгч онтой харьцуулахад 34.8 хувиар өссөн. Нийт хөрөнгө өнгөрөгч оны 2,257.3 тэрбум төгрөгөөс 3,042.5 тэрбум төгрөгт хүрч өсөхөд харилцах хадгаламжийн багц, гадаад эх үүсвэрийн багц болон зээлийн багцууд нөлөөлсөн байна. Харилцах хадгаламжийн багцын жилийн өсөлт 31.3 хувьд хүрч нийт багцын хэмжээ 1,284.9 тэрбум төгрөг болсон нь банкны бизнес нэгжүүд болон нэгдлийн охин компаниудын хамтын зорилтот үйл ажиллагаануудын үр дүн юм. Хугацаатай хадгаламжийн хувьд мөн үнэмлэхүй өсөлтийг 2017 онд үзүүлжээ.

Зээлийн багцын хувьд 2016 онтой харьцуулахад 14.0 хувийн өсөлттэй байж, энэ онд багцын хэмжээ 1,402.5 тэрбум төгрөгт хүрсэн. Зээлийн багцын өсөлтийг сегментийн хувьд авч үзвэл, цалингийн зээл болон хадгаламж барьцаалсан зээлийн өндөр өсөлтөөс улбаалсан 19.1 хувийн өсөлтийг нийт иргэдийн зээлийн багц үзүүлсэн байна.

Банкны хувьд активын чанарын үзүүлэлтээ харьцангуй тогтвортой барьж чадсан буюу сайн менежментийн үр дүнд 2016 оны эцэст 111.8 тэрбум төгрөг байсан чанаргүй зээлийн багцыг 2017 онд 109.9 тэрбум төгрөг болгож бууруулж чадсан. Оны эхнээс нийт зээлийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ (МИК-д шилжүүлсэн чанаргүй орон сууцын зээлүүдийг оруулан тооцсон) 6.9 хувьд хүрч сайжирсан нь чанаргүй ангилалд байсан бизнесийн зээлүүдийн бууралттай холбоотой.

Зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 88.9 тэрбум төгрөг, зээлийн эрсдэл даах чадварын харьцаа 80.0 – аас өндөр хувийн үзүүлэлттэй байсан нь банк зээлийн эрсдэлийг хаах хангалттай түвшний нөөц байгуулсныг илтгэж байна.

Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр өмнө жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 6.0 хувиар өссөн бөгөөд эдгээр нь банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн нийт эх үүсвэрийн талаас илүү хувийг бүрдүүлж байгаа юм.

Мөн 2017 онд банк нийт 140.0 сая ам.долларын гадаад эх үүсвэрийг татаж чадсанаас дурьдвал, “Хилийн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпораци” (OPIC-The Overseas Private Investment Corporation)-ийн жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэгдсэн 49.0 сая ам.долларын санхүүжилтийг нэрлэж болно.

Түүнчлэн, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-аас 40.0 сая ам.долларын синдикат зээлийг авсан бөгөөд энэ нь тус байгууллагаас авсан Хас банкны хоёр дахь удаагийн эх үүсвэр болсон юм.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Банк өөрийн хөрөнгийн удирдлагаа тухайн оны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан, түүнд шаардагдах капиталын бүрдэл болон эрсдэлээр жигнэсэн активын өсөлтөө тодорхойлон хэрэгжүүлдэг.

Жилийн туршид Хас банк нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүдийн заавал байх доод шалгуурыг биелүүлэн ажилласан. 2017 оны эцсийн байдлаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 11.2 хувь, нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ 16.8 хувь тус тус байсан. Эдгээр харьцааны үзүүлэлтүүд эрсдэлээр жигнэсэн активын өсөлттэй холбоотойгоор өнгөрсөн онтой харьцуулахад буурсан байгаа юм.

2017 оны байдлаар эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 27.3 хувиар өсөж 1,696.5 тэрбум төгрөгт хүрсэн нь активын өсөлттэй шууд холбоотой.

Хөрвөх чадварын үзүүлэлт нь тухайн банкны бусдын өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ биелүүлэх чадамжийг илэрхийлдэг чухал хэмжүүр юм. Хас банк иргэд, аж ахуйн нэгжийн харилцах хадгаламж болон гадаад эх үүсвэрийн багцын тогтвортой түвшинг барьж ажилласан ба үүний үр дүнд хөрвөх чадварын харьцаа өмнөх оноос 140 суурь нэгжээр өсөж 43.9 хувьд хүрсэн байна.

Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлагын арга барил

2017 онд ХасБанк эрсдлийн болон хянан нийцүүлэлтийн удирдлагын арга барилаа бүрэн хэмжээгээр хянан үзэж, шинэчилж сайжруулсан.

Эрсдлийн удирдлагын шинэчлэгдсэн арга барилаар эрсдлийн удирдлагын үүрэг хариуцлагыг “Хамгаалалтын Гурван Бүс”-ийн зарчмын дагуу тодорхойлсон. Энэ зарчмын дагуу хамгаалалтын бүс тус бүр эрсдлийн удирдлага, хяналтад тодорхой чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Хамгаалалтын Нэгдүгээр Бүс нь эрсдлийг хариуцан удирддаг. Хамгаалалтын Нэгдүгээр Бүс нь өөрийн хяналт хараан дор байгаа эрсдлийг хариуцаж, түүнийг үнэлж хянаж, саармагжуулах чиг үүрэгтэй.
- Хамгаалалтын Хоёрдугаар Бүс нь эрсдлийг хянадаг. Хамгаалалтын Хоёрдугаар Бүс нь эрсдлийн удирдлагын ерөнхий хүрээ, бодлого, журмыг тогтоох, эрсдлийн лимит болон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг нягтлах, эрсдлийн цар хүрээг хянах чиг үүрэгтэй. Энэ чиг үүргийн хүрээнд Хамгаалалтын Хоёрдугаар Бүс нь Хамгаалалтын Нэгдүгээр Бүсийн хяналтын бүтэц, үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж, чиг удирдамжаар хангадаг.
- Хамгаалалтын Гуравдугаар Бүс нь хөндлөнгийн хяналт тавьдаг. Дотоод аудитын газар нь Банкнаас эрсдлийн цар хүрээг үнэлэх, удирдах талаар авч буй арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, хамгаалалтын нэгдүгээр ба хоёрдугаар бүсийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг шалгаж, эрсдэлд суурилсан арга барил хэрхэн хэрэгжиж байгаа талаар ТУЗ-д хөндлөнгийн баталгаа гаргадаг.

Банкны Хамгаалалтын Гурван Бүсийн зарчмыг хөгжүүлж хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрсдлийн удирдлагын гол чиг үүргийг тодруулахдаа Банкны эрсдлийн болон хяналтын хүрээг зохистой удирдлагаар хангаж улам боловсронгуй болгох, эрсдлийн үйл ажиллагааг Банкны бизнесийг дэмжих байдлаар зохион байгуулж явуулах талаас нь тодотголоо.

2017 онд эрсдлийг илрүүлэх, хэмжих, тайлагнах, удирдах ажлыг сайжруулахын тулд хүч хөрөнгө зарцуулж ажиллалаа. 2017 онд хийгдсэн Активын чанарын үнэлгээ (AQR)-гээр Банкны эрсдлийн удирдлагын чадвар, үйл ажиллагаа өндөр түвшинд байгаа нь нотлогдсон бөгөөд AQR-ний зөвлөмжийг бусад хүчин зүйлийн хамт ашиглан, Банкны эрсдлийн бодлого, үйл ажиллагааг эрсдлийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцүүлэх ажлыг хийлээ.

Эрсдэлийн засаглал

Эрсдлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг тогтоох, эрсдлийг үр дүнтэй удирдах эцсийн хариуцлагыг ТУЗ хүлээнэ. Банкны ТУЗ-өөс эрх олгосноор ТУЗ-ийн Эрсдлийн Удирдлагын Хороо нь эрсдлийг хянаж, Банкны эрсдлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд байгааг нягтлан шалгаж, ТУЗ-д холбогдох зөвлөмж гаргах үүрэгтэй.

Тус Хорооны хариуцлагын хүрээнд мөн Банкны эрсдлийн удирдлагын арга барил ба эрсдлийн хяналт зохих түвшинд, үр дүнтэй байгаа эсэхийг нягтлах, түүний дотор том зээлийн эрсдлийг батлах, чанаргүй зээлийг сангаас хаах шийдвэр гаргах зэрэг асуудлууд багтдаг. ТУЗ-ийн Эрсдлийн Удирдлагын Хороо нь Банкны Эрсдлийн удирдлагын ерөнхий бодлогыг баталж, эрсдлийн удирдлага, эрсдлийн цар хүрээ, зээлийн багц, стресс тест, эрсдлийн хувилбаруудын дүн шинжилгээ зэргийг тусгасан эрсдлийн удирдлагын тайлан болон Банкны бизнесийн төлөвлөгөө болон зах зээлийн эрсдлийн дүн шинжилгээний тайланг авч хэлэлцдэг.

Банкны гүйцэтгэх удирдлагын түвшинд эрсдлийн удирдлагыг Банкны Эрсдлийн удирдлагын хороо болон Эрсдлийг хариуцсан захирал хариуцдаг. Банкны хорооны засаглалын бүтцээр эрсдэл хүлээх, эрсдлийн удирдах бодлого, эрх мэдлийг ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын холбогдох хороодод шилжүүлэн хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн засаглал



Банкны эрсдэлийн удирдлагын гол зорилго нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд үндэслэн эрсдэлийг зохистой удирдах, хяналтыг боловсронгуй болгож, улмаар банкны бизнесийг дэмжихэд оршино.

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, стресс тест ба эрсдэлийн хувилбаруудын дүн шинжилгээ

2017 онд Банк эрсдэлийн цар хүрээ болон эрсдлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг шинэчлэн баталсан. Үүнд дараах ойлголтууд багтдаг. Үүнд:

- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ нь Банкны бизнес стратегийг хэрэгжүүлэхийн тулд хүлээх эрсдлийн хэмжээг тодорхойлдог.
- Эрсдэлийн хязгаар ба эрсдэлд орох магадлалын хязгаар нь Банкны эрсдэл хүлээх боломжит түвшнийг тогтоодог. Жишээлбэл, зээлийн эрсдлийн хязгаар, эсвэл зээлийн нягтралын хязгаар гэх мэт үзүүлэлт ашигладаг.
- Эрсдэлийн чадавхи нь Банк хууль тогтоомжоор хязгаарлагдсан хүрээн дотроо эрсдэл хүлээж чадах хэмжээг тодорхойлдог.
- Бэлэн байдлын ажиллагаа нь урьдчилан тодорхойлсон бэлэн байдлын янз бүрийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн ажиллагааг тодорхойлдог.

Банк эрсдэлийн тайлан гаргах ажлаа сайжруулж, эрсдэл хүлээх боломжит түвшинг баримталж байгаа эсэхийг тогтмол хянаж байна. Нөхцөл байдлын тусгасан сценариудыг ашиглан, хөнгөн рецессийн үед, онцгой хүнд рецессийн үед байх Банкны санхүүгийн ажиллагаанд үнэлгээ хийдэг.

Үүний дээр, Банк өөрийн бизнес загварын тэсвэрлэх чадварыг үнэлэх нөөц сценариудыг авч үздэг. Нөөц сценариудыг нөхцөлт эрсдлийн иж бүрэн анализаар баяжуулдаг.

Эрсдэлийн цар хүрээ

Банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын хувьд ХасБанк эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд эрсдэл хүлээнэ. Банкны эрсдэлүүдийг дараахь байдлаар тодорхойлдог. Үүнд:

- Зээлийн эрсдэл – эзэлдэгч гэрээний нөхцлийн дагуу Банкинд төлбөр хийж чадахгүй болсонтой холбоотой алдагдал гарах магадлал;
- Зээлийн төвлөрлийн эрсдэл – хэмжээнээс хэтэрсэн зээлийн төвлөрлөөс үүдсэн алдагдал хүлээх магадлал;
- Зах зээлийн эрсдэл – санхүүгийн зах зээл дээр, мөн/эсвэл үнэ өртөгт сөрөг өөрчлөлт гарснаас үүдсэн орлого, эсвэл эдийн засгийн үнэ цэнэ алдагдалд орох магадлал;

- Хөрөнгийн эрсдэл – өөрийн хөрөнгийн хүрэлцээгүй байдал эсвэл зохицуулагчийн шаардлагын дагуу хөрөнгө нэмэгдүүлж чадаагүйгээс (гэхдээ хүлээн зөвшөөрөхүйц бус алдагдал хүлээлгүй) банкны бизнесийг явуулах чадвараа алдах магадлал;
- Төлбөрийн чадварын эрсдэл – активын өсөлтийг санхүүжүүлэх чадваргүй, хугацаа нь болоход төлбөр хийх чадваргүй байх магадлал (гэхдээ хүлээн зөвшөөрөхүйц бус алдагдал хүлээлгүй);
- Үйл ажиллагааны эрсдэл (түүний дотор луйвар) – дотоод процесс, хүмүүс, системийн үйлдэл хангалтгүй, эсвэл бүтэлгүйдсэнээс, эсвэл гадаад орчны үйл явдлын нөлөө, түүний дотор хууль эрх зүйн эрсдлээс үүдсэн алдагдал гарах магадлал;
- Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл – мэдээллийн системийн хамгаалалт алдагдах, халдлагад өртөхөөс болон мэдээлэл алдагдахаас үүдсэн хор хохирол, алдагдал гарах магадлал;
- Ёс зүйн эрсдэл – харилцагчдын хувьд шударга бус бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлснээс болон Банкны Ёс зүйн журмыг зөрчсөнөөс үүдсэн алдагдал хүлээх магадлал;
- Хянан нийцүүлэлтийн эрсдэл – хянан нийцүүлэлт хэрэгжээгүйн улмаас үүдсэн алдагдал гарах магадлал;
- Нэр хүндийн эрсдэл – орлогоо алдсанаас Банкны брэнд, нэр хүндэд хохирол учирч болох магадлал;
- Стратегийн эрсдэл – Банкны бизнес загварын орлого бий болгох чадавхийг оновчтой болгож чадаагүйн улмаас боломжоо алдах магадлал.

Эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдлийн удирдлага

2017 онд Банк зээлийн болон зээлийн төвлөрлийн эрсдлийн удирдлагын бодлого, дүрэм журам, тайлан, загварыг нягтлан үзэж сайжруулан, зээлийн багцыг эерэг чанартай болгож чадсан.

Шинэ харилцагчид зээл олгоход зээлийн зохистой бодлого баримтлах замаар зээлийн болон зээлийн төвлөрлийн эрсдэлийг удирдаж ирлээ. Одоо байгаа зээлийн багцыг нягтлан хянаж, гүйцэтгэлийг шалгаж байв. Зээлийн эрсдэлийг хянаж бууруулах зорилгоор зээлийн эрсдэлийн удирдлагын янз бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

Үүнээс гадна зээлийн багц, барьцаа хөрөнгийн удирдлагын эрчимтэй арга хэмжээ авч, чанаргүй активд чиглэсэн тусдаа стратеги гаргаж ажиллав. Ингэсний үр дүнд, Банкны чанаргүй зээлийн харьцаа өнгөрсөн жилээс 100 нэгж хувиар сайжирч, 2017 оны эцсийн байдлаар 6.9%-д хүрлээ.

2017 оны Активын чанарын үнэлгээ (AQR) нь Банкны активын чанар, зээлийн эрсдэлийн удирдлагад шалгалт хийсэн төдийгүй, Банкны зээлийн ажилтнуудын чадавхийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийсэн хэрэг боллоо. Тус арга хэмжээ нь Банкны зээлийн багцын менежмент, зээлийн практик зөв зохистой байгааг нотолсон.

Луйвар ба санхүүгийн гэмт хэрэг

2017 онд Банк луйвар болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүтцээ шинэчлэн зохион байгуулсан. Газар дээр нь болон зайнаас мөрдөн шалгах ажиллагаа явуулах, дата мэдээллийн дүн шинжилгээ хийх ажлыг багтаасан дүн шинжилгээний хүчин чадлыг сайжруулах шаардлага байна.

Луйвар, санхүүгийн гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэхийн тулд ажилтнуудыг эрчимтэй сургалтанд хэд хэдэн үе шаттайгаар хамрууллаа. Луйвар болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжид аудитын арга барилын талаар эрчимжүүлсэн сургалт явуулсан.

Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах шинэчилсэн арга барилын хүрээнд луйвар, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэх, гүйцэтгэх асуудалд онцгой анхаарал тавьж байна.

Зах зээлийн болон төлбөрийн чадварын эрсдлийн удирдлага

2017 онд Банкны зах зээлийн, төлбөрийн чадварын, хөрөнгийн эрсдэлийн удирдлага зохих ёсоор хэрэгжиж байгаа эсэхийг шалгах, Банкны хөрөнгө, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг үр ашигтай, үр дүнтэй ашиглах явдлыг хангахын тулд санхүүгийн эрсдэлийн бодлогыг хянан үзэж, шинэчлэн гаргасан.

2017 оны туршид гадаад валютын болон хүүгийн ханшны зах зээл харьцангуй тогтвортой байлаа. Төлбөрийн тэнцэл сайжирч, гадаад валютын нөөц нэмэгдсэний үр дүнд төгрөг (MNT)-гийн ханш аажмаар өссөн. Монголбанк ОУВС-гийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүгээ хоёр удаа, 6 дугаар сард 14%-иас 12% хүртэл, 12 дугаар сард дахиад 11% хүртэл бууруулсан.

Банк гадаад валютын позицийг валютын зах зээлийн хөдөлгөөнтэй уялдуулан хянасан. Банкны төлбөрийн чадвар 2017 оны туршид сайн байлаа. Банкны хадгаламжийн багц тогтвортой өссөний улмаас зээл-хадгаламжийн харьцаа багасах хандлагатай байсан. Актив болон пассивын цэвэр зөрүү нийт дүнгээрээ цаг үеийн бүх мөчлөгт эерэг байлаа.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

ХасБанк Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хорооны хяналт дор үйл ажиллагааны эрсдэлийг удирдах арга барилаа шинэчлэх ажлыг санаачлан эхлүүлсэн бөгөөд ингэснээр тохиолдол бүрийг мэдээлэх арга барилаас хяналтын зохистой хүрээ тогтоох арга барилд шилжиж байна.

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх, илрүүлэх, саармагжуулахад чиглэсэн үр нөлөөтэй, шуурхай хяналтын тогтолцоог тодорхойлж, хэрэгжүүлэх талаар үйл ажиллагаа хариуцагчдыг удирдан чиглүүлж байна. Процессыг нягтлан хянах, хяналтын дүн шинжилгээ хийх нь үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг тодорхойлж, тэр нь үйл ажиллагааны эрсдэлийн хүлээн зөвшөөрөхүйц түвшний чиг баримжаа болдог. Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага дор хяналт шалгалтын ажлыг нягтлан үнэлж, сорьж байх нь онцгой чухал бөгөөд дээр нь тохиолдол бүрийг илтгэн тайлагнаж, дүн шинжилгээ хийж байх нь зүйтэй.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын ерөнхий хүрээний тухай ойлголтыг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд ажилтнуудыг дотоод болоод зайны сургалтад хамруулж байгаа бөгөөд цаашид ч хамруулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Банкны эрсдэлийн удирдлагын гол зорилго нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд үндэслэн эрсдэлийг зохистой удирдах, хяналтыг боловсронгуй болгож, улмаар банкны бизнесийг дэмжихэд оршино.



Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн удирдлага

2017 оны жилд Банкны кибер аюулгүй байдлын ерөнхий хүрээ тогтоох ажлыг кибер аюулгүй байдлыг бүрэн хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдүгээр үе шат болгон эхлүүллээ. Кибер аюулгүй байдлын баг ерөнхий хүрээг зохистой байдлаар боловсруулж, кибер аюулгүй байдлын удирдлага болон асуудал үүссэн тохиолдолд үзүүлэх хариу арга хэмжээний процессыг тодорхойлж гаргалаа.

Кибер аюулгүй байдлын баг системийн цоорхойг олж илрүүлэх зорилгоор системд нэвтрэх туршилт, эмзэг байдлын үнэлгээ хийсэн бөгөөд ийм ажлыг байгууллагын дотоод хүн хүчээр урьд нь огт гүйцэтгэж байгаагүй юм. Эдгээр ажиллаагааны үр дүнд Банк шаардлагатай газар нь засаж залруулах арга хэмжээг тодорхойлж, авч хэрэгжүүлсэн.

Урьд нь Мэдээллийн технологийн нэгжийн хариуцаж байсан аюулгүй байдлын систем, тоног төхөөрөмжийг 2018 оны эхний улирлаас эхлэн кибер аюулгүй байдлын баг хариуцан ажиллах болж байгаа нь аюулгүй байдлын хяналт шалгалтыг үр ашигтай, үр нөлөөтэй явуулах зорилготой юм. Банкны аюулгүй байдлын баг Банкны төв алба, салбаруудын ажилтнуудад аюулгүй байдлын ойлголт, мэдлэг өгөх танхимын сургалт зохион байгуулж, мэдээллийн аюулгүй байдлын тухай сануулга мэдэгдлийг цахим шуудан, дотоод сүлжээгээр танилцуулсан.

Харилцагчдын мэдээллийг хамгаалахын тулд Банк ISO 27001, ISO 22301, PCIDSS, SWIFT

стандарт болон мэдээлэл хамгаалах хуульд нийцсэн удирдлагын систем байгуулсан. Мөн бүх салбаруудыг онилсон мэдээллийн болоод биет аюулгүй байдлын үнэлгээ хийж, аюулгүй байдлын арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдлыг шалгах, хэрэгжээгүй арга хэмжээг гүйцээх төлөвлөгөө гаргах, хэрэгжээгүйн үндсэн шалтгааныг судалж тодруулах, шаардлагатай газар нь ажил сайжруулах төлөвлөгөө гаргах зэрэг арга хэмжээ авч байна.

Хянан нийцүүлэлт

ХасБанк холбогдох бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн дагаж мөрдөх зорилготой ажилладаг. 2017 онд хянан нийцүүлэлтийн үйл ажиллагааг хянан үзэж, шүүн үзэх, мониторинг хийх, тайлагнах аппликейшн нэвтрүүлж, эрсдэл өндөртэй харилцагчдыг илрүүлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээний матриц гаргах зэрэг арга хэмжээнүүд авч сайжжрууллаа.

Банкны хянан нийцүүлэлтийн нэгж сургалт явуулж, Хамгаалалтын нэгдүгээр бүсийг бэхжүүлж, харилцагчийн нарийвчилсан дүн шинжилгээ хийх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, “Харилцагчаа танин мэдэх” шалгалтанд туслалцаа үзүүлж байна.

Мэдээллийн технологи

ЦАХИМ БАНК

Гол ололтууд:

- Бид цалингийн зээл авагч харилцагчдад төвлөрсөн ХасБанкны кредит картыг 4 дүгээр сард нэвтрүүлэв. Энэ нь шинэ чадавхийг бий болгосон шинэ ажил байлаа. Үүний зэрэгцээ, салбаруудын ажиллагсадтай хамтран, кердит карт харилцагчдад санал болгох шалгуур гаргаж, энэхүү шинэ кредит карт болон дебит картын хоорондын ялгааг харилцагчдад ойлгуулах ажил хийлээ.
- Мобайл банкны Unstructured Supplementary Service Data (USSD) формат 6 дугаар сард нэвтрүүлэв. Энэ формат нь хөдөлгөөнт утас хэрэглэгчид байршил, утасны төрлөөс хамааралгүйгээр банкны үйлчилгээ авах боломж олгож байна. Энэ онцлог үйлчилгээг хэрэгжүүлэхээр Мобиком, Юнител, Скайтел гэсэн сүлжээний гурван оператор ХасБанктай түншлэл байгуулав. Жилийн эцэс гэхэд бүртгэгдсэн харилцагчдын тоо 25'000 болж, тогтвортой өсөж байна.
- Бид цахим төлбөрийн хүртээмжийг 5 дугаар сард өргөтгөв. QR код дээр суурилсан төлбөрийн системийг мобайл аппликейшнь дээрээ үндэслэн хэрэглэгчдэд хүргэв. QR кодыг уншуулах нь төлбөрөө утсаараа төлөхдөө гараар шивж оруулдаг байдгийг арилгаж төлбөрийг хялбаршуулав.
- ХасБанк 7 дугаар сард үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж, транзакцийн урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан, Энэ нь Монголдоо анхны тийм түншлэл байсан бөгөөд улс орон дахь хамгийн том шатахуун түгээгч компаний бүх POS транзакцийг хариуцах болов. Энэхүү онцлог түншлэлийн үр дүнд худалдан авалтын транзакци 31% өссөн байна. Ийм сүлжээний үйлчилгээ Монгол даяар тархсан 300 шатахуун түгээх станцаас бэлэн мөнгө гаргаж авах боломжийг ХасБанкны карт эзэмшигчдэд олгож байна.
- Бид 10 дугаар сард агаарын тээврийн компанийн брэнд нэр бүхий анхны кредит карт гаргав. МИАТ компанитай байгуулсан түншлэл нь карт ашигласнаар “миль” цуглуулах, түүгээрээ МИАТ ХХК-наас бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжийг харилцагчдад олгож байна.
- Манай Интернэт банкны платформ бэхжиж, аюулгүй байдал, ашиглалтын хялбар байдал нь сайжрав. Хэрэглэгчдэд туслах гарын хурууны хээ таних үйлчилгээ нэвтрүүлсэн. Эдгээр нэмэлт

үйлчилгээг 5 болон 10 дугаар сард тус тус эхлүүлсэн байна.

- 7 дугаар сард цөөн туршилтын салбар дээрээ харилцагчдын үйлчилгээг сайжруулах, дотоод процессыг хурдасгах, харилцагчдын зээлийн баримт бичгийг цахимжуулах Зээлийн эхлэл, зээлийн баримт бичгийн менежментийн систем хэрэгжүүлэв. Дараа нь энэ модулийг Улаанбаатар дахь бүх салбар, улмаар хөдөөгийн бүх салбарт нэвтрүүлсэн. Одоо манай бүх салбарт үйлчилж байгаа энэ модуль нь Банкны зээлийн процессыг стандартчилсан.
- Дотоод процесс, ажиллагсдын ур чадвар дээр төвлөрч ажиллав. Бид , олон улсын MT-ийн стандарт нэвтрүүлэх зорилгоор SDLC (Software Development Lifecycle) болон ITIL (IT Infrastructure Library) сургалт явуулав. Эдгээр арга хэмжээний үр дүнд, дотоод процесс, программ хангамжийн чанар, программ хангамжийн гарын авлагыг сайжруулж, системийн зогсолтыг багасган, системийн урт хугацааны тогтвортой ажиллагааг сайжруулав.
- Бид транзакцийн бүхий л процессыг хуучин технологиос манай банкны суурь систем болох Flexcube рүү шилжүүлж, төлөрүүдийн ажиллагаа, аюулгүй байдлыг сайжруулав.
- Жилийн эхний хагаст орлого хийх анхны АТМ-ийг системтэйгээ холбосон бөгөөд энэ нь АТМ-ээс бэлэн мөнгө авах төдийгүй бэлэн мөнгө тушаах боломжийг хэрэглэгчдэд олгож байгаа юм. Туршилтын төсөл амжилттай хэрэгжсэний дараа бид Улаанбаатар дахь салбарууд дээр орлогын АТМ 20 ширхэгийг суурилуулав.
- Бид Майкрософтын SharePoint хамтран ажиллах платформ дээр суурилсан ХасLaw хэмээх шинэ системийг манай хуулийн багийнханд зориулан хөгжүүллээ.

2017 оныг 2016 онтой харьцуулсан зарим статистик тоо мэдээ:

- Интернэт банк:
 - Харилцагчид 28% өссөн
 - Транзакци 57% нэмэгдсэн
 - Транзакцийн үнэ 90% өссөн
- ХасInfo мэдэгдлийн тоо 46% нэмэгдсэн
- Картын гүйлгээний үнэ 44% өссөн
- Карт хэрэглэгчдийн тоо 25% нэмэгдсэн

ЦАХИМ АЮУЛГҮЙ БАЙДАЛ


Харилцагчийн төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлыг улам сайжруулах зорилгоор олон улсын PCIDSS стандартын шаардлагыг олон улсын байгууллагаар давтан шалгуулж, баталгаажууллаа.

Гадаад төлбөр тооцооны SWIFT байгууллагын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлснээр улс хооронд хийж буй харилцагчийн мөнгөн гүйлгээний аюулгүй, найдвартай байдлыг олон улсын шаардлагад бүрэн нийцүүлсэн.

Кибер халдлагаас банкний хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааг бүрдүүлж, үйл ажиллагааныхаа тасралтгүй найдвартай ажиллагааг хангахад дэвшил гаргалаа.

Харилцагчдад үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах үүднээс ажилтнуудынхаа мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголт, чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлж үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, харилцагчийн мэдээллийн хөрөнгийн найдвартай байдлыг сайжруулж ажилласан.

Цахим сувгуудынхаа аюулгүй, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах үүднээс хөгжүүлэлт сайжруулалт, шинэчлэлтийг тогтмол хийж, харилцагчдад зориулсан анхааруулах мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэж, харилцагчдад учирч болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж чадавхийг нэмэгдүүлээ.



Дотоод аудит

Дотоод Аудит нь группын дотоод хяналтын тогтолцооны хамгаалалтын гуравдугаар бүс бөгөөд хараат бус, бие даасан үйл ажиллагааг явуулдаг нэгж юм. Хувьсан өөрчлөгдөж буй орчинтой уялдуулан Дотоод Аудит нь үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх зорилгоор өөрийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй сайжруулж байна.

Аудитын цар хүрээг тэлэх, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд өнгөрөгч 2017 онд салбарын аудитын арга аргачлалаа илүү боловсронгуй болгож ажиллалаа. Мөн түүнчлэн баталгаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд зайн хяналтыг нэвтрүүлээд байна. Үүгээр журам заавартай нийцээгүй, ашиглангийн шинж агуулсан байж болзошгүй үйлдлийг эрт илрүүлэх зорилгоор өгөгдлийн шинжилгээг зайнаас удирдах нөхцөл бүрдлээ.

Мөн түүнчлэн, дотоод аудитын мөрөөр засч залруулах арга хэмжээний хэрэгжилтийн хяналтыг автоматжуулах төслийг амжилттай эхлүүлээд байна.

Дотоод Аудитын оруулж буй хувь нэмэр, үүрэг хариуцлагыг сурталчилан таниулах зорилгоор банкны бусад нэгжийн ажилтнуудыг аудитын үйл ажиллагаанд түр хугацаанд хамруулж, мэдлэг туршлага солилцох “Зочин аудитор” хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Тодруулбал “Зочин аудитор”-ууд нь газар дээрх аудитын үйл ажиллагаанд аудитын багийн гишүүний хувиар оролцов. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд оролцогч бүр шинэ соргог мэдлэг олж авах, өөрт буй туршлагыг бусадтай хуваалцах боломжийг олгосон алхам байв.

Байнгын өөрчлөгдөж буй бизнесийн хэрэгцээнд тулгуурласан сургалт хөтөлбөрүүдэд аудиторуудыг тогтмол хамруулсаар ирсэн. Дотоод Аудитын уламжлалт арга барилыг орчин үеийн шинэлэг аргачлалаар баяжуулахын зэрэгцээ аудитын мөрөөр өгөх зөвлөмжийн агуулгыг банкны үйл ажиллагаанд үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарлаа түлхүү хандуулж байна. Эдгээр зөвлөмжүүд нь банкны стратеги зорилгод хүрэхэд чухал хувь нэмэр бүхий засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохистой тогтолцоог дэмжихэд чиглэдэг.

МТ-ийн аудитын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, програм хангамж, техник хангамжийн архитектур зэрэг процессуудад эрсдэл болон хяналтын үйл ажиллагааг үнэлэх ажлууд хийгдлээ. МТ-ийн аудитын төлөвлөгөө болон дотоод нөөцийг байгууллагын стратегитэй нийцүүлэн бэлтгэж байна.

Тэргүүлэх туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дотоод Аудит нь өөрсдийн үйл ажиллагааг Дотоод Аудиторуудын Олон Улсын Институт (IIA)-ээс боловсруулсан чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөр (QAIP)-ийн дагуу тогтмол үнэлж байна.

Ерөнхий аудиторын удирдлага дор Дотоод Аудитын Газар чадварлаг 20 аудитор ажиллаж байна. Банкны Хянан шалгалтын нэгж мөн ДАГ-т харъяалагдаж байна.

Олон улсын үнэлгээ

2017 онд тус Банкны рейтингийн агентлагууд болох Мүүдиз болон Фитч Рейтинг үнэлгээ хийж, үр дүнд нь ХасБанкны гадаад рейтинг өссөн дүнтэй гарсан. Банк ялангуяа 2017 онд Активын чанарын үнэлгээ (AQR) хийлгэсэн, эдийн засгийн эерэг өсөлтийн үр дүнд улс орны рейтинг өссөн зэрэг нөхцөл байдалд рейтингийн агентлагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, ажил хэрэгчээр харилцаж ирлээ.

СҮҮЛИЙН ҮЕИЙН ҮЙЛ ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ:

- 2017 оны 2 дугаар сард ОУВС-гийн хөтөлбөртэй холбоотойгоор Мүүдиз агентлагаас тус улсын рейтингийн үнэлгээ хийж эхэлсэн.
- 2017 оны 4 дүгээр сард Мүүдиз Саа1 рейтинг тогтоосон.
- 2018 оны нэгдүгээр сард Мүүдиз манай рейтингийг Саа1-ээс В3 буюу тогтвортойгоос эерэг болгон сайжруулсан.
- 2017 оны нэгдүгээр сард Фитч Рейтинг манай өмнөх үнэлгээг дахин нотолсон.
- 2017 оны 11 дүгээр сард Фитч Рейтинг тус улсын үнэлгээг тогтвортойгоос эерэг болгосон бөгөөд үүнтэй уялдуулан ХасБанкны үнэлгээг мөн тогтвортойгоос эерэг болгон өсгөсөн.

Moody’s

Moody's Investor Service	Latest	2016
УХ/БХ гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгө	Саа1/NP	Саа2/NP
УХ/БХ төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө	В3/NP	Саа1/NP
Зээлжих чадварын үнэлгээ	В3	Саа1
УХ/БХ үнэт цаас гаргагч байгууллагын үнэлгээ	В3/NP	Саа1/NP
Хандлага	Тогтвортой	Тогтвортой

FitchRatings

Fitch Ratings	Latest	2016
УХ гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	В- / Эерэг	В- / Тогтвортой
БХ гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	В	В
УХ төгрөгөөр хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	В- / Эерэг	В- / Тогтвортой



Компанийн **засаглал**

Зохистой засаглал

КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫН ЕРӨНХИЙ ХҮРЭЭ

Компанийн зохистой засаглал нь ХасБанкны нэр нүүр болсон нэг чухал үзүүлэлт байсаар ирсэн билээ. Энэ нь Банкны бизнесийг амжилттай, тогтвортой байдлаар өргөжүүлж хөгжүүлэхэд манай суурь соёл юм. Манай Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлага компанийн засаглалын өндөр стандарт тогтоон мөрдөх, хувьцаа эзэмшигчид, бусад нэгдмэл сонирхолтой бүх оролцогч талын ашиг сонирхлын үүднээс компанийн сайн засаглалын зарчмыг баримталж ажиллахыг эрмэлздэг. ХасБанкны зохистой засаглалын ерөнхий хүрээ нь нийт хувьцаа эзэмшигчид, түүний дотор жижиг болон гадаадын хувьцаа эзэмшигчдэд ижил тэгш хандах, бүх түвшинд хариуцлага хүлээж ажиллах, мэдээлэх, ил тод байдлыг хангах, нийт оролцогчдын өмнө хариуцлага хүлээх зарчмуудад тулгуурласан байдаг.

Тус Банкны зохистой засаглалын практик нь дэлхий дахинаа баримтладаг зарчмууд, зарим шилдэг практик дээр суурилсан байдаг. ХасБанк Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулалтыг мөрдлөг болгон, системийн нөлөө бүхий арилжааны банкны хувьд банкны салбарын зохицуулагч болох Монголбанкнаас гаргадаг засаглалын дүрэм, журмыг мөрдөж ажилладаг. Тус Банк 2014 оны есдүгээр сард шинэчлэн гаргасан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Монголбанкинд зохистой засаглалын тайланг гаргаж хүргүүлдэг.

2017 онд гол анхааралыг компанийн зохистой засаглалын практикийг цаашид сайжруулахад хандуулан ажиллаж ирлээ.

ХасБанкны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, хараат бус гишүүдийг томилох асуудлаар тусдаа заалт оруулсан нь хууль тогтоомжийн шаардлагуудыг хангах, хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх асуудлаар буруу тайлбар гарахаас сэргийлэх зорилготой байлаа.

Манай оролцогч талуудын оролцоог хангах хүчин чармайлтыг албан ёсны “Нэгдмэл сонирхолтой талуудын оролцоог хангах төлөвлөгөө”-ний дор нэгтгэн төвлөрүүлж, оролцогч талуудтай харилцах харилцааг зохион байгуулалттайгаар зохицуулах, гол оролцогч талуудыг манай шинэчилсэн стратегийн алсын хараан дор нэгтгэх зорилгоор системтэй, үр нөлөөтэй оролцооны зорилтот үйл ажиллагаа бий болгох зорилго тавин ажиллаж байна.

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Банкны дотоод журмын дагуу толгой компани TCH ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Банкны хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд хамрагдахаар тусгайлан заасан асуудлуудаас бусад Банкны асуудлаар шийдвэр гаргана. ТУЗ нь Банкны стратегийн зорилт, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөц бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкыг стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсөв, мөн Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашиг гэсэн эрхэм зорилгын хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьдаг. Эрсдлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх дээр анхаарч ажилладаг.

ТУЗ нь үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахын тулд ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зориулалттай байнгын хороодыг байгуулж, эдгээр хороонд тодорхой үүрэг хариуцлага, шийдвэр гаргах эрхийг шилжүүлэн өгч ажиллуулдаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор мөн бусад түр хороог байгуулж ажиллуулж болдог.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкыг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй. Зохистой засаглалын тогтоолцооны хүрээнд ТУЗ-д шууд тайлагнадаг дотоод аудитор болон компанийн нарийн бичгийн даргыг удирдлагын түвшний албан тушаалд ажиллуулдаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ХУРАЛ

2017 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 3-р сарын 29-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар Банкны жилийн үр дүн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2016 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улируулан сонгох, ТУЗ-ийн төсөв зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Банкны ирээдүйн өсөлтийг хангах, Монголбанкны зөвлөмжийг биелүүлэх үүднээс 2016 оны ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Тайлангийн жилийн туршид Банкнаас чухал асуудлаар гаргасан шийдвэрүүдийг мэдээлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг зохих ёсоор эдлүүлэх, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргах үйл явцыг үр дүнтэй, шуурхай болгох замаар хувьцаа эзэмшигчдийн оролцоог тогтмол хангаж ирлээ.

Үүний дээр, хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцаа холбооны сувгийг онлайн хурал, үүнтэй ижил төстэй харилцаа холбооны арга хэрэгслээр хангаж ирлээ.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн манлайлал

төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

Төлөөлөн Удирдах Зөвлөл өөрийн бүтэц, бүрэлдэхүүнийг зохих түвшинд байна гэж үзэж байгаа бөгөөд төрөл бүрийн туршлага, үзэл бодол, гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус дүгнэлт хийх бие даасан гишүүдийн тоо, хуучин болон шинэ гишүүдийн хоорондын тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж, ТУЗ-ийн хурлыг явуулахдаа гишүүн тус бүр шийдвэр гаргалт, асуудлыг нухацтай авч хэлэлцэх процесст идэвхтэй оролцох боломжийг ханган ажиллаж ирлээ. Салбарын мэдлэг, ур чадвар, туршлага, мэргэжлийн чадвар, жендер, олон үндэстэн зэрэг хүчин зүйлсийн зохих ёсны тэнцвэртэй харьцаа барьж байх нь Банкны одоогийн болон шинээр гарч ирж буй асуудлуудыг зөв ойлгон, шийдвэрлэх чадвартай байх, менежментийн багийн үйл ажиллагаанд бодит үнэлгээ, дүгнэлт өгөхөд чухал үүрэгтэй гэж ТУЗ үзэж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнд үнэлгээ хийж, Банкны стратегийн чиг баримжаанд нийцүүлсэн өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг тодруулж байдаг.

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТУЗ нь Банкны ганц хувьцаа эзэмшигч, толгой компани болох TCH ХХК-ийн төлөөлсөн 11 гишүүнтэй байснаас нэг нь гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, 7 нь хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн гишүүд, 3 нь хараат бус гишүүд байв.

2017 онд Олон улсын санхүүгийн корпорациас нэр дэвшсэн ТУЗ-ийн гишүүн Ричард Ранкен тэтгэвэрт гарч, оронд нь Санжай Гүптаг нэр дэвшүүлж сонгосон.

№	Нэр	Овог	Албан тушаал	Төлөөлөл	Иргэншил
1	Ганболд	Чулуун	ТУЗ-ийн дарга	Жижиг хувцаа эзэмшигчид	Монгол
2	Болд	Магван	ТУЗ-ийн гишүүн	Гүйцэтгэх удирдлага ²	Монгол
3	Цэлмүүн	Нямтайшир	ТУЗ-ийн гишүүн	Монголын Алт (МАК) Корпораци	Монгол
4	Санжай	Гүпта	ТУЗ-ийн гишүүн	Олон улсын санхүүгийн корпораци (IFC)	Энэтхэг
5	Ёшиаки	Мацүока	ТУЗ-ийн гишүүн	ОРИКС Корпораци	Япон
6	Жулиан	Хили	ТУЗ-ийн гишүүн	ЕСБХБ (EBRD)	Их Британи
7	Ив	Жако	ТУЗ-ийн гишүүн	Канадын Үндэсний Банк (NBC)	Франц
8	Майкл	Мадден	ТУЗ-ийн гишүүн	Ронок Партнерз	Ирланд
9	Жеймс	Стент	Хараат бус гишүүн	-	АНУ
10	Уламбаяр	Баянсан	Хараат бус гишүүн	-	Монгол
11	Матью	Уэлч	Хараат бус гишүүн	-	Их Британи

²ХасБанкны дүрэмд заасны дагуу Гүйцэтгэх захирал санал өгөх эрхтэй ТУЗ-ийн гишүүн байна.

Зохистой засаглал

ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлага

ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг өөр өөр хүн гүйцэтгэх ба үүрэг хариуцлагын хуваарилалтыг Банкны дүрэмд тодорхой заасан байдаг. ТУЗ-ийн даргаар Чулууны Ганболд, Гүйцэтгэх захирлаар Магваны Болдоо нар тус тус ажиллаж байна. ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирал ажлын бүтээлч харилцаа, эрх мэдлийн зүй зохистой хуваарилалт, тайлагнах зарчим, бие даасан байдал дээр үндэслэн шийдвэр гаргалтад оролцдог.

ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, ТУЗ-өөс Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үнэлэх ажлыг удирдах, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж боловсруулах, хурлаар асуудал бүрийг зохистой түвшинд хэлэлцэж, гишүүн тус бүрээс хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож санал гаргах явдлыг дэмжин ажиллах үүрэг хариуцлагатай. ТУЗ-ийн дарга ТУЗ-ийг багийн зарчмаар үр дүнтэй ажиллуулж, шийдвэр гаргах явцад чиглүүлэн удирдана. ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянана, чиглүүлнэ, зөвлөнө.

Гүйцэтгэх захирал нь Банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөр батлагдсан стратеги, зорилго, бодлогын хэрэгжилтэнд анхаарч ажилладаг. Гүйцэтгэх захирал нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, хяналтын систем, дотоод дүрэм журмыг боловсруулах ажлыг хариуцаж удирддаг.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуульт хугацаа дуусахад ТУЗ-ийн гишүүн үүрэгт ажлаас чөлөөлөгдөнө эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. Банкны дүрэмд заасны дагуу ТУЗ-д орон тоо гарах эсвэл бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд ТУЗ-өөс шинэ гишүүнийг түр томилох бөгөөд түр томилогдсон гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар баталж сонгодог. Түр томилодсон гишүүн ТУЗ-ийн гишүүний бүх үүрэг хариуцлага, эрхийг эдэлнэ.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, түр томилох, сонгох, улируулан сонгох, чөлөөлөх журам нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журам болон ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журамд тусгагдсан байдаг. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны Даргын хамтарсан тушаалаар баталсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг чанд дагаж мөрдөх үүднээс 2017 онд Банкны дүрэмд хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх талаар тусдаа заалт оруулж, нэмэлт өөрчлөлт оруулсан.

ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшлүүлэх, нөхөн олговорын хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүний шаардлагыг хангасан нэр дэвшигчид, түүнчлэн хараат бус гишүүдийг үнэлэх, сонгон шалгаруулах, ТУЗ-д танилцуулах асуудлыг хариуцдаг.

ТУЗ-ийн гишүүн Санжай Гүпта, хараат бус гишүүн Матью Уэлч нар 2017 оны 3-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 жилийн хугацаатай сонгогдсон. Тус хурлаар ТУЗ-ийн гишүүн ба Гүйцэтгэх захирал Магваны Болдоо, ТУЗ-ийн гишүүд Ч.Ганболд, Майкл Мадден, Н.Цэлмүүн нар 2 жилийн хугацаатай улиран сонгогдсон.

ТУЗ-ийн гишүүд Жулиан Хили, Ив Жако, Ёшиаки Мацүока нар 2016 онд 2 жилийн хугацаатай сонгогдсон, хараат бус гишүүн Жеймс Стент улиран сонгогдсон тул 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эдгээр гишүүдийг улируулан сонгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Хараат бус гишүүн Б.Уламбаярын 2 жилийн сонгуульт хугацаа дуусч, ТУЗ-өөс түр томилогдсон байгаа тул 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар улируулан сонгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

ТУЗ-ийн хурал

ТУЗ нь 2017 оны 8-р сарын 9-ны өдөр шинэчлэн батлагдсан дүрэм, 2015 оны 6-р сарын 10-ны өдөр шинэчлэн батлагдсан ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. Ээлжит хурлын чөлөөт цаг ТУЗ-ийн хурлыг эчнээ санал хураалтаар явуулж шийдвэр гаргадаг.

2017 онд ТУЗ 5 удаа хуралдсан бөгөөд үүнээс 3 нь ээлжит хурал, 1 нь ээлжит бус хурал, 1 нь албан бус хурал байв. ТУЗ-ийн бүх хурал Улаанбаатар хотод хуралдсан бөгөөд хурлын ирцийг дараах хүснэгтээр харуулав.

#	Огноо	Хурлын төрөл	Ирц
1	2017 оны 3 сарын 29	Ээлжит	10/11
2	2017 оны 3 сарын 30	Ээлжит бус	10/11
3	2017 оны 6 сарын 14	Ээлжит	10/11
4	2017 оны 9 сарын 13	Ээлжит	10/11
5	2017 оны 12 сарын 6	Албан бус*	6/11

ТУЗ нь Банкны урт хугацааны стратеги төлөвлөгөөг хэлэлцэх зорилгоор жилд нэгээс доошгүй удаа бүтэн нэг өдрийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулдаг. 2017 онд энэ уулзалтыг 9-р сарын 12-ны өдөр зохион байгуулж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хооронд Банкны 2020 он хүртэлх дунд хугацааны стратегийг бизнесийн үйл ажиллагааны болон өрсөлдөөний орчин, макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдуулан хэлэлцэж, нэн тэргүүний зорилтуудыг тодорхойлсон.

2017 онд ТУЗ нь 33 тогтоол шийдвэр гаргасан ба үүнээс 10 тогтоол шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр эчнээ санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож банкны бизнес, санхүү, нягтлан бодох бүртгэл, хуулийн хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээллээр хангадаг.

ТУЗ-ийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлан өгөхөөс гадна ТУЗ-ийн гишүүд банкны гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүдтэй тогтмол албан бус байдлаар харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох нөхцөл боломж бий болгодог.

Зохистой засаглал

ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн ээлжит хурал, ТУЗ-ийн хорооны хуралд оролцох зэрэг ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлыг гүйцэтгэхэд нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд жил бүр цалин урамшуулал олгодог. ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллын хэмжээг Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоож өгдөг.

Монголбанкны зохистой засаглалын журмын дагуу Банкны хараат бус гишүүдэд олгодог цалин урамшууллын хэмжээ хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн гишүүдийн цалингаас багагүй байдаг.

ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хурал болон бусад арга хэмжээнд оролцсонтой холбоотойгоор гарсан зардлын нөхөн олговор авах эрхтэй. Нөхөн олговорын бодлогыг ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журамд тодорхойлсон байдаг.

ТУЗ-ийн гишүүн зуучлалын хөлс, зөвлөх үйлчилгээний хөлс зэрэг бусад төлбөр нөхөн олговор авдаггүй.

ТУЗ-ийн гишүүдийн сургалт, танилцуулга

Банкны зохистой засаглалын зарчмын дагуу, мөн Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75.9 зүйлд заасны дагуу Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд компанийн зохистой засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай.

2017 онд шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, холбогдох гэрчилгээг авсан болно.

Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдэд Банкны тухай мэдээлэл авах, Банкны стратеги, үйл ажиллагаа, дотоод хяналтын талаар судлах боломж олгосон танилцуулга сургалтын хөтөлбөр зохион байгуулдаг. Шинэ гишүүд Банкны ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагыг заасан Ёс зүйн журам, ашиг сонирхлын зөрчлийн тухай бодлогын баримт бичигтэй танилцаж, гарын үсэг зурдаг.

2017 онд ТУЗ-ийн бүх шинэ гишүүдэд танилцуулга сургалтын хөтөлбөр зохион байгуулж, Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон бусад албан тушаалтнуудтай уулзаж, Банкны өнөөгийн байдал, санхүүгийн салбарын талаар мэдээлэл авах, засаглалын асуудлуудыг хэлэлцэж ярилцах боломж олгосон.

ТУЗ-ИЙН ХОРООД

ХасБанк нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зориулалттай. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

· Засаглал, нэр дэвшүүлэх, нөхөн олговорын хороо;

· Эрсдэлийн удирдлагын хороо;

· Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байх юм. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй. Зохистой засаглалын олон улсын тогтсон хэв хэмжээний дагуу хараат бус гишүүн ТУЗ-ийн Аудитын хороог даргалдаг.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог ба 2017 онд байнгын хороодын 4 ээлжит хурал зохион байгуулагдав.

Зохистой засаглал

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОРЫН ХОРОО

ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, нөхөн олговорын хороо нь засаглалын зарчим, бодлого боловсруулах зэрэг компанийн засаглалын асуудлыг хянаж ажиллах ба Банктай нэгдмэл сонирхолтой бүх талын сонирхолд нийцсэн ил тод, тогтвортой үйл ажиллагааг хангах, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүдж ажилладаг. Тус хороо нь (1) ТУЗ болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд тохирох хүмүүсийг нэр дэвшүүлж, үнэлгээ дүгнэлт хийж, ТУЗ-д санал болгох, (2) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг хянаж цалин урамшууллыг тогтоох, урт хугацааны урамшууллын тогтолцоо бүрдүүлэх, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах үндсэн үүрэг хариуцлагатай. Хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлтэй холбоотой бүх асуудлаар болон эрсдэлийн удирдлагаар ТУЗ-д зөвлөмж гаргах, эрсдэлийг хянах, удирдах, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг асуудлыг хариуцаж ажилладаг. Тус хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын бүтэц, чиг үүрэг, эрсдэлийн лимит, зээлийн багцын чанар, ногдол ашгийн бодлого, зээлийг батлах лимит, чанаргүй зээлийг данснаас хасах эрх мэдэл, бодлогын баримт бичигт заасан лимитээс давсан гүйлгээ болон хэлцэл, холбогдох этгээдтэй хийх гүйлгээ зэрэг асуудлуудыг хянаж, үнэлгээ дүгнэлт өгөх үүрэг хариуцлагатай. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь дотоод хяналтын тогтолцооны бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэг хариуцлагатай. Тус хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайланг хууль тогтоомжийн дагуу гаргах буй эсэх, аудитлагдсан тайланг хэлэлцэх, хянах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, мэргэжлийн болон зохицуулагч байгууллагуудын дүгнэлт, тэдгээрийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл зэрэг асуудлыг хянаж, ТУЗ-д тодорхой санал оруулж, зөвлөмж гаргадаг. Аудитын хорооноос Ерөнхий аудиторыг томилж, ажлын гүйцэтгэлийг хянадаг. Аудитын хорооны дүрмийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ГИШҮҮД

Санжай Гүпта, Дарга

Ч.Ганболд

Ёшиаки Мацүока

Н.Цэлмүүн

Жулиан Хили

Ив Жако

Жэймс Стент

(Хараат бус гишүүн)

Б.Уламбаяр

(Хараат бус гишүүн)

ГИШҮҮД

Ёшиаки Мацүока, Дарга

Майкл Мадден

Жулиан Хили

Санжай Гүпта

Б.Уламбаяр

(Хараат бус гишүүн)

Матью Уэлч

(Хараат бус гишүүн)

ГИШҮҮД

Жэймс Стент, Дарга

(Хараат бус гишүүн)

Майкл Мадден

Н.Цэлмүүн

Ив Жако

Б.Уламбаяр

(Хараат бус гишүүн)

Матью Уэлч

(Хараат бус гишүүн)

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА МЭДЭЭЛЭЛ ИЛ БОЛГОХ

Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журам нь ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлон, мэдээлэл ил болгох, ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг шийдвэрлэх процедурыг зааж өгсөн байдаг. Жишээлбэл:

· ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхэд нь нөлөө үзүүлж болох аливаа хувийн, санхүүгийн болоод бусад ашиг сонирхол байвал тэр тухай ил мэдээлэх ёстой.

· Банкны хийх гэж байгаа ямар нэг хэлцэлтэй холбоотой ашиг сонирхлын зөрчил бүхий ТУЗ-ийн гишүүн тийм зөрчлийн мөн өөрийн ашиг сонирхлын талаар тухайн хэлцлийг авч хэлэлцэх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал дээр мэдэгдэх ёстой.

· Ашиг сонирхлын зөрчил бүхий ТУЗ-ийн гишүүн тухайн хэлцэл, түүнтэй холбоотой зохицуулалт, аливаа бусад асуудлаар ТУЗ-ийн шийдвэр гаргах явцад санал өгөхөөс түдгэлзэх, ирц бүрдүүлэхээс татгалзах ёстой.

Мэдээлэл ил болгох журмын дагуу, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүх гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн бүх гишүүд 2017 оны арванхоёрдугаар сарын 31-н гэхэд Мэдээлэл ил болгох мэдэгдлээ хүргүүлсэн байгаа.

ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭ

Компанийн зохистой засаглалыг мөрдлөг болгон, засаглал болон үйл ажиллагаагаа цаашид сайжруулах үүднээс Банкны ТУЗ өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, ажлаа сайжруулах, авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор дотоод үнэлгээг жил бүр хийдэг. Банкны ТУЗ 2017 оны дотоод үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Банкны санхүүгийн тайланг бэлтгэх үүрэг хүлээдэг бөгөөд санхүүгийн тайланд Банкны өнөөгийн байдлыг үнэн зөв, шударгаар илтгэж, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн зохих стандартыг мөрдөж ажилласан байх явдлыг хангасан байх ёстой. Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн гишүүдийг холбогдох тайлбар, мэдээллээр хангаж, Банкны зүгээс ТУЗ-д шийдвэр гаргуулахаар танилцуулсан санхүүгийн мэдээлэл, байр суурийн талаар мэдлэгтэй шийдвэр гаргах боломжийг нь бүрдүүлж өгөх ёстой.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг тодорхой давтамжтайгаа өөрчлөх, томилох үүрэг мөн хүлээдэг. Эрнст ба Янг Монголиа аудитын агентлагийн оронд 2014 онд томилогдож байсан Делоитт агентлаг 2017 оны хөндлөнгийн аудитороор дахин томилогдсон болно.

Шагналууд



TOP-100 ААН нэгжээс 6-рт эрэмбэлэгдлээ
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим



The Banker
Монгол улсын шилдэг банк
The Banker сэтгүүл



GLOBAL FINANCE
Монгол улсын шилдэг банк
Global Finance сэтгүүл



GLOBAL FINANCE
Гадаад валютын ханган нийлүүлэгч шилдэг банк
Global Finance сэтгүүл



ASIAMONEY
Жижиг дунд бизнесийг дэмжигч шилдэг банк
Asia Money awards



Child & Youth Finance International
Тэмүүлэл хадгаламж, Тэмүүлэл картууд хүүхэд залууст ээлтэй банкны үйлчилгээр тодорлоо
Child & Youth Finance International



Child & Youth Finance International
Ирээдүйн саятан хадгаламж хүүхэд залууст ээлтэй банкны үйлчилгээгээр тодорлоо
Child & Youth Finance International

ХАЯГ:

Олон Улсын Худалдааны төв
Жамъян гүний гудамж - 9
Ш/салбар 20А, ш/х-72
Улаанбаатар-14200, Монгол улс

Утас: +976 (11) 75771888
Факс: +976 (11) 328701
И-мэйл: info@xacbank.mn
www.xacbank.mn